

Хэрэглэгчийн Заавар

Зохиогчийн эрх

Seiko Epson Corporation-н урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрлийг авалгүйгээр энэхүү хэвлэмэл материалын ямар нэгэн хэсгийг дахин боловсруулах, эсвэл мэдээллийн системд хадгалах болон ямар нэг хэлбэрээр, эсвэл ямар нэгэн байдлаар, электрон, механик, фото хуулбар, бичлэг, эсвэл өөр замаар дамжуулж болохгүй. Энд агуулагдсан мэдээллийг ашиглахтай холбоотойгоор ямар нэг патентийн хариуцлагын асуудал үүсэхгүй. Түүнчлэн, энд агуулагдсан мэдээллийг ашиглахаас үүдэн гарсан хор хохирлыг хариуцахгүй. Энд агуулагдсан мэдээлэл нь зөвхөн Epson-н бүтээгдэхүүнийг ашиглахад зориулан гаргасан болно. Бусад бүтээгдэхүүнийг хэрэглэхийн тулд энэхүү мэдээллийг ямарваа байдлаар хэрэглэсэн хариуцлагыг Epson хүлээхгүй.

Осол зөрчил гаргасан, буруу хэрэглэсэн, эсвэл буруугаар ашигласан, дүр мэдэн өөрчлөлт оруулсан засвар хийсэн, эсвэл энэхүү бүтээгдэхүүнд өөрчлөлт оруулсан, эсхүл (АНУ-с бусад газар) Seiko Epson Corporation-н ашиглалт, засвар үйлчилгээний зааварчилгааг чанд мөрдөж чадаагүйгээс энэхүү бүтээгдэхүүний худалдан авагч, гуравдагч этгээдийн гаргасан хор хохирол, алдагдал, зардал, зарлагыг энэхүү бүтээгдэхүүнийг худалдан авагч, эсвэл гуравдагч этгээдийн өмнөөс Seiko Epson Corporation болон түүний салбар компаниуд хариуцахгүй.

Epson-н үндсэн бүтээгдэхүүн, эсвэл Epson-н Seiko Epson Corporation-р баталгаажуулсан бүтээгдэхүүн гэж тогтоосноос бусад ямарваа хэрэглээний бүтээгдэхүүн, эсвэл аливаа ашиглах сонголтоос үүдэн гарах ямарваа хор хохирол, асуудал бэрхшээлийг Seiko Epson Corporation болон түүний салбар компани хариуцахгүй.

Seiko Epson Corporation-н Epson-н баталгаажуулсан бүтээгдэхүүн гэж тодорхойлсноос бусад интерфэйсийн кабель утсыг ашигласнаас үүдэх цахилгаан соронзон цохилтоос үүдэн гарах ямарваа хор хохирлыг Seiko Epson Corporation хариуцахгүй.

© 2022 Seiko Epson Corporation. All rights reserved.

Энэхүү заавар, энэхүү бүтээгдэхүүний техникийн тодорхойлолтын агуулгыг аливаа мэдэгдэл өгөлгүйгээр өөрчилж болно.

Худалдааны тэмдэг

❑ EPSON® нь бүртгэлтэй худалдааны тэмдэг бөгөөд EPSON EXCEED YOUR VISION буюу EXCEED YOUR VISION нь Seiko Epson Corporation-н худалдааны тэмдэг болно.

❑ EPSON Scan software is based in part on the work of the Independent JPEG Group.

❑ libtiff

Copyright © 1988-1997 Sam Leffler

Copyright © 1991-1997 Silicon Graphics, Inc.

Permission to use, copy, modify, distribute, and sell this software and its documentation for any purpose is hereby granted without fee, provided that (i) the above copyright notices and this permission notice appear in all copies of the software and related documentation, and (ii) the names of Sam Leffler and Silicon Graphics may not be used in any advertising or publicity relating to the software without the specific, prior written permission of Sam Leffler and Silicon Graphics.

THE SOFTWARE IS PROVIDED "AS-IS" AND WITHOUT WARRANTY OF ANY KIND, EXPRESS, IMPLIED OR OTHERWISE, INCLUDING WITHOUT LIMITATION, ANY WARRANTY OF MERCHANTABILITY OR FITNESS FOR A PARTICULAR PURPOSE.

IN NO EVENT SHALL SAM LEFFLER OR SILICON GRAPHICS BE LIABLE FOR ANY SPECIAL, INCIDENTAL, INDIRECT OR CONSEQUENTIAL DAMAGES OF ANY KIND, OR ANY DAMAGES WHATSOEVER RESULTING FROM LOSS OF USE, DATA OR PROFITS, WHETHER OR NOT ADVISED OF THE POSSIBILITY OF DAMAGE, AND ON ANY THEORY OF LIABILITY, ARISING OUT OF OR IN CONNECTION WITH THE USE OR PERFORMANCE OF THIS SOFTWARE.

❑ Microsoft®, Windows®, and Windows Vista® are registered trademarks of Microsoft Corporation.

❑ Apple, Macintosh, Mac OS, OS X, Bonjour, Safari, iPad, iPhone, iPod touch, and iTunes are trademarks of Apple Inc., registered in the U.S. and other countries. AirPrint and the AirPrint logo are trademarks of Apple Inc.

❑ Google Cloud Print™, Chrome™, Chrome OS™, and Android™ are trademarks of Google Inc.

❑ Adobe, Adobe Reader, Acrobat, and Photoshop are trademarks of Adobe systems Incorporated, which may be registered in certain jurisdictions.

❑ Intel® is a registered trademark of Intel Corporation.

❑ Ерөнхий тэмдэглэл: Энд хэрэглэсэн бусад бүтээгдэхүүний нэр нь зөвхөн ялган таних зориулалттай ба зохих эзэмшигчийнхээ худалдааны тэмдэг байх боломжтой. Epson нь тэдгээр худалдааны тэмдгийн ямарваа болон бүх эрхээс татгалзана.

Агуулга

Зохиогчийн эрх

Худалдааны тэмдэг

Энэхүү гарын авлагын тухай

Гарын авлагын танилцуулга.	8
Тэмдэг тэмдэглэгээ.	8
Энэхүү гарын авлагад ашигласан тодорхойлолт.	9
Үйлдлийн системийн лавлагаа.	9

Чухал заавар

Аюулгүй байдлын заавар.	10
Принтерийн зөвлөгөө, анхааруулга.	11
Принтерийг тохируулах зөвлөгөө болон анхааруулга.	11
Принтерийг ашиглах зөвлөгөө болон анхааруулга.	12
Принтерийг зөөвөрлөх, хадгалах зөвлөгөө болон анхааруулга.	12
Утасгүй холболт бүхий принтерийг ашиглах зөвлөгөө ба анхааруулга.	12
LCD дэлгэц ашиглах талаар өгөх зөвлөгөө, анхааруулга.	13
Хувийн мэдээллээ хамгаалах.	13

Принтерийн үндсэн мэдээлэл

Эд ангийн нэр ба функцууд.	14
Хяналтын самбар.	16
Товч ба гэрэл.	16
LCD Дэлгэц дээр харагдах тэмдэг.	17
Тэмдэгтийг оруулах.	17
Цэсний сонголтууд.	18
Хувилах Горим.	18
Сканнердах горим.	19
Факсдах горим.	20
Тохируулга Горим.	21

Цаас ачаалах

Цаас ашиглахтай холбоотой анхааруулга. ...	28
Бэлэн байгаа цаас ба багтаамж.	29
Цаасны төрлийн жагсаалт.	30
Цаасан Кассет руу цаас ачаалах.	31

Эх хувийг байрлуулах

ADF-д зориулж бэлдсэн эх хувилбар.	34
ADF дээр эх хувийг байрлуулах.	34
Сканнерын Шил дээр эх хувийг байрлуулах.	36

Хэвлэх

Компьютероос хэвлэх.	38
Хэвлэх үндсэн мэдээлэл - Windows.	38
Хэвлэх үндсэн мэдээлэл - Mac OS X.	40
2-талаар хэвлэх.	41
Нэг хуудсан дээр хэд хэдэн хуудсыг хэвлэх.	44
Цаасны хэмжээнд тааруулж хэвлэх.	45
Олон тооны файлыг хамт хэвлэх (Windows-т зөвхөн).	46
Нэг зургийг олон хуудсан дээр хэвлэж зурагт хуудас үүсгэх (зөвхөн Windows). ...	47
Дээд зэргийн тохиргоог ашиглан хэвлэх. .	53
Epson Easy Photo Print ашиглаж фото зураг хэвлэх.	55
Ухаалаг төхөөрөмжөөс хэвлэх.	56
Epson iPrint ашиглах.	56
AirPrint ашиглах.	58
Хэвлэхийг цуцлах.	58
Хэвлэхийг цуцлах — Принтерийн товч. ...	58
Хэвлэхийг цуцлах — Windows.	59
Хэвлэхийг цуцлах — Mac OS X.	59

Хуулбарлах

Скандах

Хяналтын самбар ашиглаж скандах.	61
Үүлэн үйлчилгээ рүү скандах.	61
Компьютер руу скандах.	61
Компьютер руу скандах (WSD).	62
Компьютероос скандах.	62
Скандах үндсэн мэдээлэл.	62
Дээд зэргийн тохиргоо ашиглан скандах. .	64
Ухаалаг төхөөрөмжөөс скандах.	67

Факсдах

Факс тохируулах.	69
Утасны шугамтай холбох.	69

Факсын үндсэн тохиргоог хийх.	72
Факсдах харилцах хаягийг бүртгүүлэх.	75
Харилцах хаяг бүртгэх.	75
Бүлэглэсэн харилцах хаяг бүртгэх.	75
Компьютер ашиглан харилцах хаягийг бүртгэж нөөцлөн хадгалах.	76
Факс илгээх.	76
Факс илгээх үндсэн үйл ажиллагаа.	76
Факс илгээх төрөл бүрийн арга.	78
Факс хүлээн авах.	79
Хүлээн авах горимыг тохируулах.	79
Факс хүлээн авах төрөл бүрийн арга.	80
Хүлээн авсан факсыг компьютерт хадгалах.	82
Факсын бусад тохиргоог ашиглах.	83
Факсын тайлан, жагсаалтыг хэвлэх.	83
Хүлээн авсан факсыг дахин хэвлэх.	84

Бэх дүүргэх

Бэхний Түвшинг Шалгах.	85
Бэхний түвшинг шалгах - Windows.	85
Бэхний түвшинг шалгах — Mac OS X.	85
Бэхний хайрцагны код.	85
Бэхний лонхтой харьцах урьдчилсан санамж.	86
Бэхний савыг дахин дүүргэх.	87

Хэвлэх, скандах чанарыг сайжруулах

Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх.	91
Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх — Хяналтын самбар.	91
Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх — Windows.	92
Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх — Mac OS X.	92
Бэхний Хоолой доторх Бэхийг Солих.	93
Бэхний хоолой доторх бэхийг солих — Windows.	93
Бэхний хоолой доторх бэхийг солих — Mac OS X.	94
Принтерийн толгойг тохируулна.	94
Хэвлэх Толгойг Тэгштгэх - Хянах Самбар.	94
Принтерийн толгойг тохируулах — Windows.	95
Принтерийн толгойг тохируулах — Mac OS X.	95
Цаасны замын бэхний өнгөрийг цэвэрлэх. . .	96

ADF-г цэвэрлэх.	96
Сканнерын Шил-г цэвэрлэх.	98

Сүлжээний үйлчилгээ болон програмын мэдээлэл

Epson Connect үйлчилгээ.	100
Web Config.	100
Web Config-г вэб хөтөч дээр ажиллуулах	101
Web Config-ыг Windows дээр ажиллуулах.	101
Web Config-г Mac OS X дээр ажиллуулах.	102
Windows принтерийн драйвер.	102
Windows-н принтерийн драйверын тохиргоог хязгаарлах.	103
Windows принтерийн драйверт ашиглалтын тохиргоог хийх.	103
Mac OS X принтерийн драйвер.	104
Mac OS X Принтерийн Драйверт Ажиллагааны Тохиргоо хийх.	104
EPSON Scan (Сканнерийн драйвер).	105
Epson Event Manager.	105
PC-FAX Драйвер (Факсын драйвер).	106
FAX Utility.	106
Epson Easy Photo Print.	107
E-Web Print (Windows-т зөвхөн).	107
EPSON Software Updater.	108
EpsonNet Config.	108
Программ хангамжийг суулгах.	108
Программ хангамжийг устгах — Windows.	109
Программ хангамжийг устгах — Mac OS X.	109
Программ хангамжийг устгах.	110
Программ хангамж, компанийн программыг шинэчлэх.	111

Асуудлыг шийдэх

Принтерийн төлөвийг шалгах.	112
LCD дэлгэц дээрх зурвасыг шалгах.	112
Принтерийн төлөвийг шалгах — Windows.	113
Принтерийн төлөвийг шалгах — Mac OS X.	113
Бөглөрсөн цаасыг салгах.	114
Принтер дотроос бөглөрсөн цаасыг салгах.	114

Агуулга

Цаасан Кассет дотроос гацсан цаасыг авах.	116	Скандах талбай, эсвэл чиглэл буруу байх.	131
Арын Таг дотроос гацсан цаасыг авах. ...	117	Скандсан зургийн асуудал шийдэгдэхгүй байх.	131
ADF-аас гацсан цаасыг авах.	118	Скандах бусад асуудал.	132
Цаас зөв татагдахгүй байна.	120	Хураангуй урьдчилан харах функц зөв ажиллахгүй байна.	132
Цаас гацалт.	121	Хэт удаан скандаж байна.	132
Цаас хазайж татагдаж байвал.	121	PDF/Multi-TIFF руу скандах үед скандах ажиллагаа зогсоод байна.	132
Цаасны таталт байхгүй бол.	121	Факс илгээх, хүлээн авахад үүсэх асуудлууд.	132
Нэг дор хэд хэдэн хуудас татагдвал.	121	Факс илгээж, хүлээн авч чадахгүй байна	132
ADF дээр орохгүй эх хувь.	121	Факс илгээж чадахгүй байна.	134
Тэжээл ба хяналтын самбарын асуудал. ...	122	Тухайн хүлээн авагч руу факс илгээж чадахгүй байна.	134
Тэжээл асахгүй байна.	122	Факсыг тогтоосон цагт илгээж чадахгүй байна.	134
Тэжээл унтрахгүй байна.	122	Факс хүлээж авахгүй байна.	135
Тэжээл автоматаар унтарна.	122	Санах ой дүүрсэн алдаа заав.	135
LCD дэлгэц бараан болох.	122	Илгээсэн факсын чанар муу байна.	135
Принтер хэвлэхгүй байна.	122	Факсыг буруу хэмжээтэй илгээж байна. .	136
Хэвлэмэл материалын асуудал.	123	Хүлээж авсан факсын чанар муу байна. .	136
Хэвлэлтийн чанар муу байвал.	123	Хүлээн авсан факсыг хэвлэхгүй байх. ...	136
Хэвлэх толгойг тэгшитгэсний дараа ч хэвлэлтийн чанар сайжрахгүй байвал. ...	124	Факсдах бусад асуудал.	136
Зураг юмуу фото зураг хэвийн бус өнгөөр хэвлэгдэж байвал.	125	Сүлжээнд холбогдсон утаснаас дуудлага хийж болохгүй байна.	136
Барагцаагаар 3.3 см-ийн зайтай судлууд гарч ирвэл.	125	Хариулагч машин дуут дуудлагад хариу өгөхгүй байна.	137
Хуулах Чанар Муу байна.	125	Илгээгчийн факсын дугаар хүлээн авсан факс дээр харагдахгүй байна, эсвэл дугаар нь буруу байна.	137
Эх хувийн эсрэг талын зураг хуулбарласан зураг дээр гарах.	126	Бусад асуудал.	137
Хэвлэмэл материалын байрлал, хэмжээ, хүрээ буруу байх.	126	Принтерт хүрэхэд бага зэргийн тог цохиж байна.	137
Цаас балархайтах буюу үнгэгдсэн байвал.	126	Ажиллагаа чанга дуутай байвал.	137
Хэвлэсэн тэмдэгт буруу, ташаа байх. ...	127	ADF ажиллахгүй.	137
Хэвлэсэн зураг буруу харах.	127	ADF сканнердалт удаашрах.	138
Хэвлэмэл материалын асуудал шийдэгдэхгүй байх.	127	Огноо, цаг буруу байна.	138
Хэвлэх бусад асуудал.	128	Программ хангамжийг Firewall хаах (Windows-т зөвхөн).	138
Хэт удаан хэвлэх.	128	Бэхний түвшинг дахин тохируулахыг сануулсан зурвас гарч ирвэл.	138
Үргэлжилсэн Хэвлэлтийн Үед Хэвлэлт Удаашрах.	128		
Сканыг эхлүүлж чадахгүй байна.	128		
Хяналтын самбар ашиглаж байхад сканыг асааж чадахгүй байна.	129		
Скандсан зурагны асуудал.	129		
Сканнердах Чанар Муу байна.	129		
Тэмдэгтүүд тод бус гарах.	130		
Скандсан зураг дээр эх зурагны ар тал харагдах.	130		
Скандсан зураг дээр муар (хөндлөн зураас)-н дүрс харагдах.	130		
		Хавсралт	
		Техникийн тодорхойлолт.	139
		Принтерийн үзүүлэлт.	139
		Сканнерийн Үзүүлэлтүүд.	139
		Интерфэйсийн үзүүлэлт.	140
		Факсын үзүүлэлт.	140

Wi-Fi үзүүлэлт.	141
Ethernet үзүүлэлт.	141
Аюулгүй байдлын протокол.	141
Дэмждэг гуравдагч талын үйлчилгээ. ...	142
Хэмжээс.	142
Цахилгааны Үзүүлэлтүүд.	142
Орчны үзүүлэлт.	143
Системийн шаардлага.	143
Хууль журмын мэдээлэл.	144
Стандарт ба зөвшөөрөл.	144
Хуулбарлахад тавигдах хязгаарлалт. ...	145
Принтерээр дамжиж буй хуудасны нийт тоог шалгах.	146
Принтерээр дамжиж буй хуудасны нийт тоог шалгах — Хяналтын самбар. ...	146
Принтерээр дамжиж буй хуудасны нийт тоог шалгах — Windows.	146
Принтерээс гарсан нийт хуудасны тоог шалгах — Mac OS X.	146
Эрчим хүч хэмнэх.	146
Эрчим хүч хэмнэх - Хянах самбар.	147
Принтерийг зөөвөрлөх.	147
Хаанаас тусламж авах вэ.	149
Техник туслалцааны вэбсайт.	149
Epson-н тусламжтай холбогдох.	150

Энэхүү гарын авлагын тухай

Гарын авлагын танилцуулга

Дараах гарын авлагууд нь таны Epson принтерт дагалдаж ирсэн байгаа. Түүнчлэн эдгээр гарын авлагаас гадна Epson-н төрөл бүрийн программ хангамжид агуулагдсан тусламжуудыг бас лавлаарай.

☐ Энд эхлэ (хэвлэмэл гарын авлага)

Принтерийг тохируулах, программ хангамжийг суулгах, принтерийг ашиглах, асуудлыг шийдвэрлэх зэрэг мэдээллийг танд өгнө.

☐ Хэрэглэгчийн Заавар (дижитал гарын авлага)

Энэхүү гарын авлага. Принтерийг ашиглах, асуудлыг шийдвэрлэх талаар ерөнхий мэдээлэл, заавраар хангана.

☐ Сүлжээний Заавар (дижитал гарын авлага)

Сүлжээний тохиргоо болон принтерийг сүлжээнд ашиглах үед гарах асуудлыг шийдвэрлэх талаар мэдээллээр хангана.

Та дээрх гарын авлагуудын хамгийн сүүлийн хувилбарыг даараах аргуудаар олж авах боломжтой.

☐ Хэвлэмэл гарын авлага

Epson Европ вэбсайтад <http://www.epson.eu/Support> хаягаар, эсвэл Epson дэлхий дахины вэбсайтад <http://support.epson.net/> хаягаар зочлоорой.

☐ Дижитал гарын авлага

Компьютер дээрээ EPSON Software Updater-ийг эхлүүл. EPSON Software Updater нь Epson програм хангамж болон дижитал гарын авлагын боломжит шинэчлэлүүдийг шалгаж, хамгийн сүүлийн хувилбарыг татах боломжийг олгоно.

Холбогдох мэдээлэл

➔ [108 хуудас дээрх "EPSON Software Updater"](#)

Тэмдэг тэмдэглэгээ



Болгоомжтой:

Биедээ гэмтэл авахгүйн тулд анхааралтай дагах ёстой заавар.



Чухал:

Принтертээ гэмтэл учруулахаас сэргийлэхийн тулд дагах ёстой заавар.

Тэмдэглэл:

Нэмэлт, лавлагааны чанартай мэдээллээр хангана.

➔ Холбогдох мэдээлэл

Энэхүү гарын авлагын тухай

Холбогдох хэсэг рүү хөтлөх холбоос.

Энэхүү гарын авлагад ашигласан тодорхойлолт

- ❑ Принтерийн драйверын дэлгэцийн дүрслэл болон EPSON Scan (сканнер драйвер) дэлгэц нь Windows 8.1 эсвэл Mac OS X v10.10.x-с гарсан. Дэлгэц дээр дүрсэлсэн зүйлс загвар, нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байдаг.
- ❑ Энэхүү гарын авлагад ашигласан принтерийн зураглал зөвхөн жишээний үүрэгтэй. Загвараас шалтгаалан бага зэргийн ялгаа байж болох ч, ажиллуулах арга ажиллагаа адил байна.
- ❑ LCD дээрх цэсний зүйлийн заримын дэлгэц загвар, тохиргооноос шалтгаалж өөр өөр байна.

Үйлдлийн системийн лавлагаа

Windows

Энэхүү гарын авлагад дурдсан "Windows 8.1", "Windows 8", "Windows 7", "Windows Vista", "Windows XP", "Windows Server 2012 R2", "Windows Server 2012", "Windows Server 2008 R2", "Windows Server 2008", "Windows Server 2003 R2", "Windows Server 2003" зэрэг нэршил нь дараах үйлдлийн системийг илэрхийлсэн болно. Түүнчлэн, "Windows" нь бүх хувилбарыг илэрхийлнэ.

- ❑ Microsoft® Windows® 8.1 үйлдлийн систем
- ❑ Microsoft® Windows® 8 үйлдлийн систем
- ❑ Microsoft® Windows® 7 үйлдлийн систем
- ❑ Microsoft® Windows Vista® үйлдлийн систем
- ❑ Microsoft® Windows® XP үйлдлийн систем
- ❑ Microsoft® Windows® XP Professional x64 Edition үйлдлийн систем
- ❑ Microsoft® Windows Server® 2012 R2 үйлдлийн систем
- ❑ Microsoft® Windows Server® 2012 үйлдлийн систем
- ❑ Microsoft® Windows Server® 2008 R2 үйлдлийн систем
- ❑ Microsoft® Windows Server® 2008 үйлдлийн систем
- ❑ Microsoft® Windows Server® 2003 R2 үйлдлийн систем
- ❑ Microsoft® Windows Server® 2003 үйлдлийн систем

Mac OS X

Энэхүү гарын авлагад дурдсан "Mac OS X v10.10.x" нь OS X Yosemite-ийг, "Mac OS X v10.9.x" нь OS X Mavericks-ийг, мөн "Mac OS X v10.8.x" нь OS X Mountain Lion-ийг илэрхийлж байгаа болно. Түүнчлэн, "Mac OS X" нь "Mac OS X v10.10.x", "Mac OS X v10.9.x", "Mac OS X v10.8.x", "Mac OS X v10.7.x", мөн "Mac OS X v10.6.8" бүх хувилбарыг илэрхийлнэ.

Чухал заавар

Аюулгүй байдлын заавар

Энэхүү принтерийг аюулгүй ашиглахын тулд дараах зааврыг уншиж даган мөрдөнө үү. Энэхүү гарын авлагыг ирээдүйд ашиглахын тулд хадгална уу. Түүнчлэн, энэхүү принтер дээр тэмдэглэсэн бүх анхааруулга, зааврыг мөрдөж биелүүлнэ үү.

- ☐ Таны принтерт хэрэгдэгдэж байгаа зарим таних тэмдгүүд нь принтерийг зөв, аюулгүй ашиглахад зориулагдсан байдаг. Уг таних тэмдгүүдийн утга учрын талаар мэдэхийн тулд дараах веб сайтад зочилно уу.
<http://support.epson.net/symbols>
- ☐ Энэхүү принтертэй цуг ирсэн тэжээлийн утсыг зөвхөн ашиглаж, аливаа бусад тоног төхөөрөмжийн тэжээлийн утсыг ашиглахаас татгалзана уу. Энэхүү принтерт бусад төхөөрөмжийн цахилгаан утсыг ашиглах, эсвэл цуг ирсэн тэжээлийн утсыг өөр бусад тоног төхөөрөмж дээр ашиглах нь гал түймэр, цахилгаанд цохиулах аюулгүй бий болгоно.
- ☐ АС тэжээлийн утас дотоодын аюулгүй ажиллагааны зохих стандартад нийцэж байгаа эсэхийг шалгана уу.
- ☐ Принтерийн гарын авлага дээр тодорхой зааснаас бусад тохиолдолд тэжээлийн утас, залгуур, принтерийн эд анги, сканнерийн эд ангийг өөрийн мэдлээр хэзээ ч бүү задалж, өөрчлөн, засахыг оролдох хэрэггүй.
- ☐ Дараах тохиолдолд принтерийг тэжээлээс салгаж, ур чадвар бүхий үйлчилгээний ажилтнаар засвар үйлчилгээ хийлгэнэ үү:
Тэжээлийн утас, эсвэл залгуур эвдэрсэн; принтерт шингэн нэвтэрсэн; принтерийг унагаасан, эсвэл гаднах хайрцаг эвдэрсэн; принтер ердийн байдлаар ажиллахгүй эсвэл ажиллагаанд нь онцгой өөрчлөлт орсон. Ашиглалтын зааварт ороогүй хяналтын үйл ажиллагааг тохируулж болохгүй.
- ☐ Залгуурыг хялбар холбож болохоор байрлалд ханын залгуурт ойр принтерийг байрлуулна.
- ☐ Их хэмжээний тоос шороо, ус, халууны эх үүсвэр бүхий гадаа байрлалд принтерийг тавихгүй байх, эсвэл цахилгаанд цохиулах, чичиргээнд өртөх өндөр температур, чийгтэй газар тавьж болохгүй.
- ☐ Принтер дээр шингэн асгахгүй байхад анхаарал хандуулж, принтерт нойтон гараар хүрч ажиллуулахгүй байх.
- ☐ Зүрхний хэм хэмжигчээс принтерийг 22 см-с доошгүй зайд байрлуулна. Энэхүү принтерээс гарах радио долгион зүрхний хэм хэмжигчийн ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой.
- ☐ LCD дэлгэц гэмтсэн бол, худалдааны төлөөлөгчтэйгөө холбоо барь. Шингэн кристал уусмалыг гартаа хүргэвэл, тэр хэсгийг саван, усаар сайтар угаана. Шингэн кристал уусмалыг нүдэндээ оруулбал, нэн даруй усаар зайлж угаана. Сайн зайлсны дараа ч таагүй байдал мэдрэгдэж, сайтар харахгүй байвал, эмчтэй яаралтай үзүүлнэ.
- ☐ Цахилгаан шуурганы үед телефон утас хэрэглэхээс зайлсхийнэ. Аянга цахилгаанаас цахилгаанд цохиулах алсын аюул эрсдэл байж болно.
- ☐ Хий асгарсан газар хий асгарсан талаар мэдээлэхдээ утас ашиглаж болохгүй.

Чухал заавар

- ☐ Бэхний сав, бэхний савны таг, онгойлгосон бэхний хайрцаг, бэхний хайрцагны тагтай ажиллах үедээ бэхэнд хүрэхгүй байхад анхаарал хандуулна.
- ☐ Хэрэв бэх таны арьсанд хүрвэл, хүрсэн газрыг савантай усаар сайтар угаагаарай.
- ☐ Хэрэв бэх таны нүдэнд орвол, тэр даруйд нь усаар зайлаарай. Хэрэв сайтар зайлсны дараа ч эвгүйрхэх эсвэл хараанд асуудал үлдвэл, тэр даруйд нь эмчид үзүүлээрэй.
- ☐ Хэрэв бэх таны аманд орвол, тэр таруйд нь эмчид үзүүлээрэй.
- ☐ Бэхний хайрцагны түгжээг мулталсны дараа, сэгсэрч хазайлгаж болохгүй ба энэ нь бэхийг асгарахад хүргэнэ.
- ☐ Бэхний хайрцаг, бэхний хайрцагны хэсгийг хүүхдийн гар хүрэхгүй газар хадгална. Бэхний хайрцаг, бэхний хайрцагны тагийг задалж уух, тэдгээрээр тоглох боломж хүүхдэд олгохгүй байх хэрэгтэй.

Принтерийн зөвлөгөө, анхааруулга

Принтер болон өөрийн эд хөрөнгөө эвдрэл гэмтлээс сэргийлэхийн тулд дараах зааврыг дагаж мөрдөнө үү. Энэхүү гарын авлагыг ирээдүйд ашиглахын тулд хадгална уу.

Принтерийг тохируулах зөвлөгөө болон анхааруулга

- ☐ Принтерийн хоолой, нээлхийг хааж, таглахгүй байх.
- ☐ Принтерийн шошго дээр заасан тэжээлийн эх үүсвэрийн төрлийг ашиглах.
- ☐ Байнга асаж унтарч байдаг хувилагч машин, эсвэл агаарын хяналтын систем зэрэгтэй нэг хэлхээнд байрлах залгуурт залгахгүй байх.
- ☐ Ханын унтраалга, эсвэл автомат цаг зэргийн удирддаг цахилгаан залгуур хэрэглэхээс зайлсхийх.
- ☐ Чанга яригч, утасгүй телефон утасны үүр зэрэг цахилгаан соронзон нөлөөлөл бүхий боломжит эх үүсвэрээс компьютерийн ерөнхий системийг хол байрлуулах.
- ☐ Эрчим хүчний тэжээлийн цахилгаан утсыг зулгарах, зүсэгдэх, эрчлэх, хугарах, нугаларахаас сэргийлж байрлуулна. Эрчим хүчний тэжээлийн цахилгаан утсан дээр эд юмс тавьж болохгүй бөгөөд эрчим хүчний тэжээлийн цахилгаан утсан дээр гишгэх гүйхийг хориглоно. Трансформатор руу орж байгаа болон гарч байгаа төгсгөлийн хэсэг дээр эрчим хүчний тэжээлийн цахилгаан утсыг шулуун байлгахад онцгой анхаарал хандуулна.
- ☐ Принтер дээр уртасгагч цахилгаан утас ашиглах бол, уртасгагч утсанд залгах төхөөрөмжийн нийт ампер нь цахилгаан утасны амперийн хэмжээнээс хэтрэхгүй байхад анхаарал хандуулна. Түүнчлэн, ханын залгуур залгасан бүх төхөөрөмжийн амперийн хэмжээ ханын залгуурын нийт амперийн хэмжээнээс хэтрэхгүй байхад анхаарна.
- ☐ Та энэхүү принтерийг Герман улсад ашиглахаар төлөвлөж байгаа бол, принтерийн богино холболтын хамгаалалт, хэт гүйдлийн хамгаалалтын зохих түвшинг хангахын тулд ашиглах барилга дээрх суурилуулалтыг 10 эсвэл 16 амперын хэлхээ таслагчаар хамгаалах ёстой.
- ☐ Принтерийг компьютер болон бусад төхөөрөмжтэй кабель утсаар холбох үед холболт зөв чиглэлтэй хийгдсэн эсэхийг бататгах хэрэгтэй. Холбогч бүрт холболтын цорын ганц зөв чиглэл байдаг. Холбогчийг буруу чиглэлээр хийх нь кабель утсаар холбосон хоёр төхөөрөмжийн аль алинд эвдрэл гэмтэл учруулах боломжтой.
- ☐ Принтерийг принтерийн сууриас бүх чиглэлд сунгах боломжтой тэгш, тогтвортой гадаргуу дээр байрлуулна. Принтерийг тодорхой өнцгөөр хазайлгасан үед зохих ёсоор ажиллахгүй.

Чухал заавар

- ☐ Цаасны тагийг бүрэн нээх боломжтой байхын тулд принтерийн дээд хэсэгт зайтай байлгах.
- ☐ Цаасыг бүрэн гаргаж авах боломжтой байхын тулд принтерийн урд талд хангалттай зай үлдээх.
- ☐ Температур, чийгшлийн эрс өөрчлөлт бүхий газарт байрлуулахаас зайлсхийх. Түүнчлэн, принтерийг нарны шууд тусгал, хурц гэрэл, халууны эх үүсвэрээс хол байлгана.

Принтерийг ашиглах зөвлөгөө болон анхааруулга

- ☐ Принтерийн сувгаар дамжуулж эд юмс оруулахгүй байх.
- ☐ Хэвлэж байхад принтер дотор гараа оруулахгүй байх.
- ☐ Принтерийн дотор талын цагаан хавтгай кабель утас, бэхний хоолойд гараа хүргэхгүй байх.
- ☐ Принтерийн дотор талд болон эргэн тойронд шатамхай хий агуулсан аэрозолын бүтээгдэхүүн ашиглахгүй байх. Тэдгээрийг ашигласнаар гал түймэр гарч болно.
- ☐ Хэвэлх толгойг гараар хөдөлгөж болохгүй; эс бөгөөс та принтерийг гэмтээж болзошгүй.
- ☐ Сканнерийн эд ангийг хаахдаа гараа хавчуулахаас болгоомжилно уу.
- ☐ Эх хувийг тавихдаа сканнерын шил дээр хэт чанга дарахгүй байх.
- ☐ Бэхний түвшинг бэхний саван дээрээс бодитоор харж шалгаарай. Бэх барагдсан үед принтерийг үргэлжлүүлэн хэрэглэх нь принтерт гэмтэл учруулж болзошгүй. Принтер ажиллаагүй үед бэхний савыг дээд зураас хүртэл нь дүүргэн, бэхний түвшинг дахин тохируулахыг Epson зөвлөж байна.
- ☐ Үргэлж  товчийг ашиглаж принтерийг унтрааж байх.  гэрэл анивчихаа болих хүртэл принтерийн залгуурыг салгахгүй, эсвэл тэжээлийг залгуураар унтраахгүй байх.
- ☐ Та принтерийг удаан хугацаагаар ашиглахгүй бол, тэжээлийн цахилгаан утсыг цахилгааны залгуураас салгахаа мартуузай.

Принтерийг зөөвөрлөх, хадгалах зөвлөгөө болон анхааруулга

- ☐ Принтерийг хадгалах буюу зөөвөрлөх үед, хазайлгах, босоогоор нь байрлуулах, доош нь харуулахаас болгоомжил; эс бөгөөс бэх гоожиж болзошгүй.
- ☐ Принтерийг тээвэрлэхээс өмнө, принтерийн толгой үндсэн (баруун өнцөг) байрлалд байгааг эсэхийг шалгах.

Утасгүй холболт бүхий принтерийг ашиглах зөвлөгөө ба анхааруулга

- ☐ Энэхүү принтерээс гарч буй радио долгион эрүүл мэндийн электрон тоног төхөөрөмжид сөрөг нөлөө үзүүлж, тэдгээрийг бүрэн гүйцэд ажиллагаанд саад учруулж болно. Эрүүл мэндийн байгууламж, эсвэл эрүүл мэндийн тоног төхөөрөмжийн ойролцоо тус принтерийг ашиглахдаа, эрүүл мэндийн байгууламжийг төлөөлж буй эрх бүхий ажилтны өгсөн зааварчилгааг дагаж, эрүүл мэндийн тоног төхөөрөмжийн бүх анхааруулга, санамжийг дагах хэрэгтэй.

Чухал заавар

- ❑ Энэхүү принтерээс гарч буй радио долгион автомат хаалга болон галын дохио зэрэг автомат хяналттай төхөөрөмжийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай ба үйл ажиллагааны доголдлоос болж осол зөрчилд хүргэж болно. Энэхүү принтерийг автомат хяналттай төхөөрөмжийн дэргэд ашиглахдаа, тэдгээр төхөөрөмжийн бүх анхааруулга, санамжийг дагаж мөрдөнө үү.

LCD дэлгэц ашиглах талаар өгөх зөвлөгөө, анхааруулга


- ❑ The LCD дэлгэц нь цөөн тооны жижиг цайвар ба хар цэгийг агуулж болох бөгөөд тохируулгаасаа болоод үүнд ижил бус цайралттай байж болно. Эдгээр нь хэвийн бөгөөд энэ нь ямар нэг байдлаар эвдэрч гэмтсэн гэдгийг илэрхийлэхгүй болно.
- ❑ Цэвэрлэх үед хуурай, зөөлөн даавууг зөвхөн ашиглана. Шингэн эсвэл химийн бодистой угаагч бодис ашиглаж болохгүй.
- ❑ LCD дэлгэц хүнд цохилтод өртвөл гадаад хүрээ нь эвдэрч гэмтэж болно. Дэлгэцийн гадаргуу бутарч, хагарсан бол худалдааны төлөөлөгчтэйгөө холбоо барьж, хагарсан хэсэгт хүрч түүнийг салгахыг оролдож болохгүй.

Хувийн мэдээллээ хамгаалах


Та тус принтерийг хэн нэгэнд өгөх, эсвэл хаяхдаа, хяналтын самбар дээрх **Тохируулга > Өгөгдмөл Тохиргоог Сэргээх > Бүх Өгөгдөл болон Тохиргоог Арилгах**-г сонгосноор принтерийн санах ойд хадгалагдсан бүх хувийн мэдээллээ арилгаж болно.

Принтерийн үндсэн мэдээлэл

Эд ангийн нэр ба функцууд




①	ADF (Автомат Баримт Татагч)-ийн таг	ADF доторх гацсан эхийг авахын тулд үүнийг онгойлгоно.
②	ADF оролтын тэвш	Эхийг автоматаар татна.
③	ADF ирмэг заагч	Эхийг шууд принтерт татна. Эхийн ирмэгт тултал гулгуул.
④	ADF гаралтын тэвш	ADF-с гаргасан эхийг тогтооно.
⑤	Цаасан кассет	Цаасыг ачаална.




①	Хэвлэх толгой (энэ хэсгийн доор)	Бэхийг шүршинэ.
---	----------------------------------	-----------------

Принтерийн үндсэн мэдээлэл

②	Гаралтын тэвш	Гаргасан цаасыг тогтооно.
③	Ирмэг заагч	Цаасыг шууд принтерт татна. Цаасны ирмэгт тултал гулгуул.
④	Цаасан кассет	Цаасыг ачаална.




①	Баримтын таг	Сканнердаж байхад гадны гэрлийг хаана.
②	Сканнерын шил	Эхийг байрлуул.
③	Хянах самбар	Принтерийг ажиллуулна.



①	Сканнерийн нэгж	Байрлуулсан эхийг сканнердана. Принтер доторх гацсан цаасыг авахын тулд үүнийг онгойлго.
---	-----------------	--

Принтерийн үндсэн мэдээлэл


②	Бэхний савны нэгж	Бэхний савыг агуулна.
③	Бэх хадгалах сав (Бэхний сав)	Хэвлэх толгойд бэхийг хангана.



①	Арын таг	Гацсан цаасыг авахдаа салга.
②	LAN порт	LAN кабелийг холбоно.
③	USB порт	USB кабелийг холбоно.
④	AC оролт	Тэжээлийн залгуурыг холбоно.
⑤	LINE порт	Утасны шугамыг холбоно.
⑥	EXT. порт	Гадаад утасны төхөөрөмжийг холбоно.

Хяналтын самбар

Товч ба гэрэл



①		Принтерийг асааж унтраана. Тэжээлийн гэрэл унтарсан үед тэжээлийн цахилгаан утсыг салгана.
---	--	---

Принтерийн үндсэн мэдээлэл

②		Үндсэн дэлгэцийг харуулна.
③		Сүүлд залгасан дугаарыг оруулж, факсын дугаар оруулахдаа пауз оруулна.
④		Одоогийн үйл ажиллагааг зогсооно.
⑤	-	Цэс, мэдээллийг харуулна.
⑥	◀, ▶, ▲, ▼, OK	Цэсийг сонгохын тулд ◀, ▶, ▲, ба ▼ дээр дарна. Өөрийн сонголтоо баталгаажуулж сонгосон тохиргоогоо ажиллуулахын тулд OK дээр дарна.
⑦		Өмнөх дэлгэц рүү буцах.
⑧	0 - 9 *, #	Тоо, тэмдэгт, тэмдэг оруулна.
⑨		Харилцах жагсаалтыг нээнэ.
⑩		Хар цагаанаар хэвлэх, хуулбарлах, скандах, факсдахыг эхлүүлнэ.
⑪		Өнгөтөөр хэвлэх, хуулбарлах, скандах, факсдахыг эхлүүлнэ.

LCD Дэлгэц дээр харагдах тэмдэг

Принтерийн төлөвөөс шалтгаалж дараах тэмдэг LCD дэлгэц дээр гарч ирэх болно.

	ADF дээр эх хувийг байрлуулахад асна.
	Утастай (Ethernet) сүлжээг идэвхгүй болгож Ethernet кабель утсыг холбоогүй байхад асна.
	Принтер утастай (Ethernet) сүлжээнд холбогдсон үед асна.
	Принтер утасгүй (Wi-Fi) сүлжээнд холбогдоогүй үед асна.
	Принтер утасгүй (Wi-Fi) сүлжээнд холбогдсон үед асна. Баганы тоо нь холболтын дохионы хүчийг харуулна. Олон багана байх тусам, холболт хүчтэй байна.
+	Принтерийн утасгүй (Wi-Fi) сүлжээний холболтод асуудал үүсэх, эсвэл принтер утасгүй (Wi-Fi) сүлжээ хайх үед асна.
	Принтер урьдчилан тогтоосон горимд холбогдсон гэдгийг харуулна.
	Энгийн AP горим болон Wi-Fi шууд горимыг идэвхгүйжүүлсэн гэдгийг илтгэнэ.
	Принтер Wi-Fi Direct горимд холбогдсон гэдгийг харуулна.
	Энгийн AP горим идэвхжсэнийг заана.
	Эко горимыг идэвхжүүлэх үед асна.

Тэмдэгтийг оруулах

Сүлжээний тохиргоонд тэмдэгт болон ялгах тэмдэгүүдийг оруулах, мөн хянах самбараас факсын дугаарыг оруулахдаа тоон гар болон товчийг ашиглаарай. Оруулахыг хүссэн тэмдэгтээ гарч ирэх

Принтерийн үндсэн мэдээлэл

хүртэл гарны товчлуурыг хэд хэдэн удаа дарна. ОК товчийг дарж оруулсан тэмдэгтээ баталгаажуулна.

Тохиргооны зүйлүүдээс хамаарч харагдах дэлгэц ялгаатай байна. Дараах дэлгэц нь Wi-Fi сүлжээний нууц үгийг оруулах дэлгэц болно.



Таних тэмдэг	Тодорхойлолт
▲ ▼	Тэмдэгтийн төрлийг сэлгэнэ. Одоогийн тэмдэгтийн төрлийг заах таних тэмдэг нь LCD дэлгэцийн баруун дээд талд харагдана. A: Том үсэг оруулна. a: Жижиг үсэг оруулна. 1: Тоо болон ялгах тэмдэг оруулна.
◀	Зүүн талын тэмдэгтийг устгана (ухраах).
OK	Оруулсан тэмдэгтийг баталгаажуулна.
⏏	Дуудах үед завсарлага (гурван секундын турш завсарлана) оруулна. Завсарлах тэмдгийг төлөөлүүлж богино зураас (-) оруулна.

Цэсний сонголтууд

Хувилах Горим

Тэмдэглэл:

- ☐ Таны сонгосон бүдүүвчээс шалтгаалж ашиглаж болох цэс ялгаатай байж болно.
- ☐ Тохиргооны нуугдсан цэсийг харуулахын тулд ОК товч дээр дарна.

Цэс	Тохиргоо ба Тайлбарууд
Хувилах тоо	Хувилах тоог оруулна.

Принтерийн үндсэн мэдээлэл

Цэс	Тохиргоо ба Тайлбарууд	
Бүдүүвч	Хүрээтэй	Ирмэгийг нь тойруулж хүрээтэй хувилна.
	2-ыг 1-т	Нэг хуудсан дээр олон эх хуудсыг хувилна. Эхийг ADF дээр тавихдаа, дээд эсвэл зүүн ирмэгээс нь татагч оруулна. Босоо эхийг доор харуулсанчлан ачаалж, Босоо-г Баримтын Чиг дээр сонгоно.  Хэвтээ эхийг доор харуулсанчлан ачаалж, Хэвтээ-г Баримтын Чиг дээр сонгоно. 
	Үнэмлэхийн Карт	ID картны хоёр талыг хоёуланг нь сканнердаж, A4 хэмжээтэй цаасны нэг тал дээр хувилна.
Баримтын Хэмжээ	Эхийн хэмжээг сонго.	
Томруулах	Эхийг томруулж эсвэл жижигрүүлнэ. Сонгосон цаасны эх үүсвэрийн хэмжээнд тааруулахын тулд Автоматаар Цаасанд Багтаах-г сонгоно.	
2-талт	2-талт бүдүүвчийг сонго. Бүдүүвчийг сонгож, ► товчийг дараад, цаасны үдэх байрлалыг сонгоно.	
Баримтын Чиг	Эхийн чиглэлийг сонго.	
Чанар	Эхийн төрлийг сонго. Текст: Илүү хурдан хэвлэх боловч, хэвлэлт бүдэг байж магадгүй. Текст & Зураг(Сайн): Илүү өндөр чанараар хэвлэх боловч, хэвлэх хурд удаан байж магадгүй.	
Нягтшил	Хувилах нягтшилийг тохируул.	
Бүдүүвчийн Тохиргоо	2-ыг 1-т-г Бүдүүвч тохиргоогоор сонгосон бол, олон хуудасны хувилах бүдүүвчийг сонго.	
Хатах Хугацаа	Хатах хугацааг сонго.	

Сканнердах горим

Үүлэн

Цэс	Тохиргоо, тайлбар
Чиглэл	Erson-ы холболтын сервер дээр бүртгэсэн чиглэлийг сонгоно.

Принтерийн үндсэн мэдээлэл

Цэс	Тохиргоо, тайлбар	
Тохиргоо	Формат	Скандсан зургийг хадгалах форматаа сонгоно.
	Сканнердах Талбай	Сканы талбайг сонгоно. Автоматаар Тайрах: Скандах үед текст эсвэл зургийн эргэн тойронд байрлах цагаан зайг багасгаж хэвлэнэ. Хамгийн том Талбай: сканнерын шил эсвэл ADF-н скандах дээд талбай дахь скандалтууд.
	Баримтын Төрөл	Эх хувийнхаа төрлийг сонгоно.
	Нягтшил	Скандсан зургийн тодролтыг сонгоно.
	Баримтын Чиг	Эх хувийнхаа чиглэлийг сонгоно.

Компьютер

Цэс	Тохиргоо, тайлбар	
Компьютерийг Сонгох	USB ашиглан, эсвэл сүлжээгээр холбогдсон компьютеруудын жагсаалтаас, скандсан зураг хадгалахыг хүсэж буй компьютероо сонгоно.	
Тохиргоо	Формат	Скандсан зургийг хадгалах форматаа сонгоно.

Компьютер (WSD)

Цэсэнд тохиргооны зүйл байхгүй байна.

Факсдах горим

Факсдах-г үндсэн дэлгэц дээрээс сонгоод дараа нь ОК товчийг дарна.

Цэс	Тохиргоо, тайлбар	
Нарийвчлал	Илгээж буй факсын нарийвчлалыг сонгоно. Текст ба фото зурган мэдээлэл агуулдаг эх хувийн тухайд Фото -г сонгоно.	
Нягтшил	Илгээж буй факсын нягтралыг тохируулна.	
Шууд Илгээх	Дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд энэхүү тохиргоог тодорхойлсон хуудсыг үзнэ үү.	
Дамжуулалтын Тайлан	Факс илгээсний дараа дамжуулсан тайланг автоматаар хэвлэнэ. Алдаа гарсан үед зөвхөн тайланг хэвлэхийн тулд Алдаа гарсан үед Хэвлэх -г сонгоно.	
Факсыг Дараа Илгээх	Дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд энэхүү тохиргоог тодорхойлсон хуудсыг үзнэ үү.	
Бүртгэгдсэн факсыг хүлээн авах		
Факсыг Дахин хэвлэх	Хамгийн сүүлчийн факсаас эхлээд принтерийн санах ойд түр хадгалагдсан хүлээн авсан факсыг хэвлэнэ.	

Принтерийн үндсэн мэдээлэл

Цэс	Тохиргоо, тайлбар	
Факсын Тайлан	Факсын Тохиргооны жагсаалт	Одоогийн факсын тохиргоог хэвлэнэ.
	Факсын Лог	Факс илгээсэн, хүлээн авсан ажлын түүхийг харуулна эсвэл хэвлэнэ. Та дараах цэсийг ашиглан энэхүү тайланг автоматаар хэвлэх тохиргоог хийж болно. Тохируулга > Факсын Тохиргоо > Гаралтын Тохиргоо > Факсын Логийг Автоматаар Хэвлэх
	Хамгийн сүүлийн дамжуулалт	Санал асуулгын дагуу илгээж хүлээн авсан өмнөх факсын тайланг хэвлэнэ.
	Протоколын Мөрдлөг	Илгээж хүлээн авсан өмнөх факсын нарийвчилсан тайланг хэвлэнэ.

Холбогдох мэдээлэл

- ➔ 79 хуудас дээрх “Монохромт баримт бичгийн олон хуудсыг илгээх (Шууд Илгээх)”
- ➔ 78 хуудас дээрх “Факсыг тогтоосон цагт илгээх (Факсыг Дараа Илгээх)”
- ➔ 81 хуудас дээрх “Санал хураалтаар факс хүлээн авах (Бүртгэгдсэн факсыг хүлээн авах)”

Тохируулга Горим

Цэс	Тохиргоо ба Тайлбарууд	
Арчилгаа	Хэвлэх Толгой Хошуу Шалгах	Хэвлэх толгойн хошуу бөглөрсөн эсэхийг шалгах хээг хэвлэнэ.
	Хэвлэх Толгойг Цэвэрлэх	Хэвлэх толгойн бөглөрсөн хошууг цэвэрлэнэ.
	Бэхний Түвшинг Ресет хийх	Бэхний савыг дахин дүүргэхээс өмнө бэхний түвшинг дахин тохируулахын тулд үүнийг сонгоорой.
	Хэвлэх Толгойг Тэгштгэх	Хэвлэх чанарыг сайжруулахын тулд, хэвлэх толгойг тэгштгэнэ. Хэрэв хэвлэлт бүрсгэр буюу текст болон шугамнууд нь тэгш бус харагдвал Босоогоор Тэгшитгэх -г ажиллуул. Хэрэв хэвлэлтэнд тогтмол зайтай хөндлөн судлууд харагдвал Хөндлөнгөөр Тэгштгэх -г ажиллуул.
	Цаас Заагчийг Цэвэрлэх	Дотоод дамарт бэх тогтсон, эсвэл цаас татахад асуудал тулгарсан тохиолдолд цаас ачаалж цэвэрлэхийн тэлд энэ үзүүлэлтийг ашиглаарай.
Цаасны Тохируулга	Цаасны эх үүсвэрт ачаалсан цаасныхаа хэмжээ, төрлийг сонгоно.	
Статус Хуудсыг Хэвлэх	Тохируулгын Статус Хуудас	Принтерийн одоогийн төлөв болон тохиргоог харуулсан мэдээллийн хуудсуудыг хэвлэнэ.
	Ашиглалтын Түүхийн Хуудас	Принтерийн ашиглалтын түүхийг харуулсан мэдээллийн хуудсуудыг хэвлэнэ.

Принтерийн үндсэн мэдээлэл

Цэс	Тохиргоо ба Тайлбарууд		
Принтерийн Тохиргоо	Цаасны Эхийн Тохиргоо	A4/Захидал Шилжүүлэх	Хэвлэх ажлын цаасны хэмжээний тохиргоо болон цаасны эх үүсвэрт ачаалсан цаас хоорондоо таарахгүй байсан ч алдааны зурвасыг харуулахгүй байхын тулд энэхүү тохиргоог идэвхжүүлнэ үү. Энэхүү тохиргоог зөвхөн цаасны хэмжээг A4 эсвэл Letter тохируулсан үед ашиглах боломжтой.
		Алдааны Мэдэгдэл	Цаасны Тохируулга дээрх цаасны хэмжээ эсвэл төрлийн тохиргоо нь хэвлэх тохиргоотой таарахгүй бол алдааны зурвас гаргана.
	Автомат Алдаа Ялгагч	2-талт хэвлэлтийн алдаа гарсан үед гүйцэтгэх үйлдлийг сонгоно. Идэвхжсэн: Хэрэв 2-талт хэвлэлтийг дэмжих цаас байхгүй тохиолдолд 2-талт хэвлэлтийн ажил илгээгдсэн бол, принтер нь алдааны зурвас гаргаж, автоматаар зөвхөн цаасны нэг талд хэвлэнэ. Идэвхгүй болсон: Принтер алдааны зурвас гаргаж хэвлэлтийг цуцална.	
	USB-ээрх PC холболт	Компьютерт USB холболтоор холбогдсон принтерийг идэвхжүүлнэ. Хэрэв энэхүү тохиргоог идэвхгүй болговол, компьютер нь USB холболттой принтерийг танихгүй болно.	

Принтерийн үндсэн мэдээлэл

Цэс	Тохиргоо ба Тайлбарууд	
Түгээмэл Тохиргоонууд	Дуу	Дууны түвшинг тохируулж, аудио файлын төрлийг сонгоно.
	Унтах Цаг тоологч	Ямар ч үйлдэл гүйцэтгээгүй үед принтер унтах горимд (эрчим хүч хэмнэх горим) орох хүртэлх хугацааг сонгоно. Тохируулсан хугацаа өнгөрсний дараа LCD дэлгэц харлана.
	Унтраах Тохиргоо	Үйлдвэрлэсэн огноо, худалдан авсан газраас хамааран таны бүтээгдэхүүнд энэ үзүүлэлт эсвэл Унтраах Цаг Тоологч үзүүлэлт байж магадгүй.
		Идэвхгүй бол Унтраах Эрчим хүчний удирдлага хэрэгжих хүртэлх хугацааг тохируулах боломжтой. Энэ хугацааг ямарваа нэг хэмжээгээр ихэсгэх нь принтерийн эрчим хүчний хэмнэлтэд нөлөөлнө. Тиймээс ямар нэг өөрчлөлт хийхээс өмнө байгаль орчинд үзүүлэх нөлөөг нь тунгаан бодоорой.
		Салгагдсан бол Унтраах LINE порт зэрэг бүх порт салгагдсанаас хойш заасан хугацааны дараа принтерийг унтраахын тулд энэ тохиргоог сонгоно уу. Энэ онцлог таны бүсээс хамаараад байхгүй байж болно. Заасан хугацааны тухайд дараах вэбсайтаас үзнэ үү. https://www.epson.eu/energy-consumption
	Унтраах Цаг Тоологч	Эрчим хүчний удирдлага хэрэгжих хүртэлх хугацааг тохируулах боломжтой. Энэ хугацааг ямарваа нэг хэмжээгээр ихэсгэх нь принтерийн эрчим хүчний хэмнэлтэд нөлөөлнө. Тиймээс ямар нэг өөрчлөлт хийхээс өмнө байгаль орчинд үзүүлэх нөлөөг нь тунгаан бодоорой.
	LCD Ялгарал	LCD дэлгэцний тодролтыг тохируулна.
	Огноо/Цагийн Тохиргоо	Огноо/Цаг Одоогийн цаг, огноог оруулна.
		Зуны Цаг Өөрийн бүсийн зуны цагийн тохиргоог сонгоно.
		Цагийн зөрүү Орон нутгийн цаг болон UTC (Үндсэн Цагийн Бүс)-ийн хоорондох цагийн зөрүүг оруулна.
	Улс/Бүс	Улс эсвэл бүс нутгаа сонгоно.
	Хэл/Language	Дэлгэцэнд гарах хэлээ сонгоно.
	Гүйлгэх Хурд	LCD дэлгэцний гүйлгэх хурдыг сонгоно.

Принтерийн үндсэн мэдээлэл

Цэс	Тохиргоо ба Тайлбарууд		
Сүлжээний Тохиргоо	Сүлжээний Статус	Сүлжээний тохиргоо, холболтын төлөвийг харуулж, хэвлэнэ.	
	Wi-Fi Тохируулга	Wi-Fi Тохируулгын Визард	Илүү дэлгэрэнгүй мэдээллийг <i>Сүлжээний Заавар</i> -с үзнэ үү.
		Товчны Тохируулга (WPS)	
		PIN Код Тохируулга (WPS)	
		Wi-Fi Автомат Холболт	
	Wi-Fi-г хаах	Wi-Fi тохиргоог идэвхгүй болгож, Wi-Fi тохиргоог дахин хийснээр сүлжээний асуудлыг шийдэж магадгүй. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг <i>Сүлжээний Заавар</i> -с үзнэ үү.	
	Wi-Fi Direct Тохируулга	Илүү дэлгэрэнгүй мэдээллийг <i>Сүлжээний Заавар</i> -с үзнэ үү.	
Холболтыг Шалгах	Сүлжээний холболтын төлөвийг шалгаж, сүлжээний холболтыг шалгасан тайланг хэвлэнэ. Холболтод ямар нэг асуудал гарсан бол, асуудлыг шийдэхийн тулд шалгах тайланг үзнэ үү.		
Мэргэшсэн Тохируулга	Илүү дэлгэрэнгүй мэдээллийг <i>Сүлжээний Заавар</i> -с үзнэ үү.		
Epson Холболт Үйлчилгээ	Epson Connect буюу Google Cloud Print үйлчилгээг түр зогсоож дахин эхлүүлэх, эсвэл эдгээр үйлчилгээг бүр ашиглахаа болих боломжтой (өгөгдмөл тохиргоог сэргээнэ).		
Google Cloud Хэвлэлт	Дэлгэрэнгүй мэдээллийг Epson Connect портал вэбсайтаас үзээрэй. https://www.epsonconnect.com/ http://www.epsonconnect.eu (зөвхөн Европод)		
Факсын Тохиргоо	Факсын Тохиргоо дээрээс цэсний жагсаалтыг үзнээрэй.		
Хэвлэх Нэгдсэн Тохиргоо	Эдгээр хэвлэх тохиргоонууд нь принтерийн драйверийг ашиглахгүйгээр гадаад төхөөрөмж ашиглан хэвлэх хэрэгжинэ.		
	Дээд Зах	Цаасны дээд эсвэл зүүн захыг тааруулна.	
	Зүүн Зах		
	Арын дээд талын оффсет	2-талаар хэвлэх үед, ар талын дээд болон зүүн талын захыг тааруулна.	
	Зүүн дээд талын оффсет		
	Цаасны Өргөнийг Шалгах	Принтер хэвлэж эхлэхээс өмнө цаасны өргөнийг шалгана. Ингэснээр цаасны тохиргоо буруу өгөгдсөн үед, цаасны ирмэгээс хэтэрч хэвлэхээс сэргийлэх боловч, хэвлэх хугацаа үл ялиг удааширч магадгүй.	
	Хатах Хугацаа	2-талаар хэвлэх үеийн хатах хугацааг сонгоно.	
	Хоосон Хуудсын Алгасах	Автоматаар хэвлэх өгөгдөл доторх хоосон хуудсыг алгасна.	

Принтерийн үндсэн мэдээлэл

Цэс	Тохиргоо ба Тайлбарууд	
Эко Горим	Дараах Эко горимын тохиргоог ашиглах боломжтой. Эдгээр тохиргоог идэвхгүй болгосон үед, Түгээмэл Тохиргоонууд дээрх тохиргоонууд хэрэглэгдэнэ.	
	Унтах Цаг тоологч	Ямар ч үйлдэл гүйцэтгээгүй үед принтер унтах горимд (эрчим хүч хэмнэх горим) орох хүртэлх хугацааг сонгоно. Тохируулсан хугацаа өнгөрсний дараа LCD дэлгэц харлана.
	2-Талт(Хувилалт)	2-талт хэвлэлтийг өгөгдмөл утганд тохируулна.
Өгөгдмөл Тохиргоог Сэргээх	Сонгосон тохиргоог өгөгдмөл утга руу нь буцаана.	

Холбогдох мэдээлэл

- ➔ 18 хуудас дээрх **"Хувилах Горим"**
- ➔ 19 хуудас дээрх **"Сканнердах горим"**
- ➔ 25 хуудас дээрх **"Факсын Тохиргоо"**

Факсын Тохиргоо

Үндсэн дэлгэцнээс **Тохируулга > Факсын Тохиргоо**-г сонгоно.

Цэс	Тохиргоо, тайлбар	
Хэрэглэгч. Анхны Тохиргоо	Энэхүү цэсэн дээр хийгдсэн тохиргоо факс илгээх таны үндсэн тохиргоо боллоо. Зүйлсийг тохируулах талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авахын тулд Факсдах горим дээрх цэсний жагсаалтыг үзнэ үү.	
Хүлээн авах Тохиргоо	Хүлээн авах Горим	Хүлээн авах горимыг сонгоно.
	DRD	Та телефон утасны компани дээрээ тусгай дуудлагын үйлчилгээнд бүртгүүлсэн бол, ирж буй факсанд ашиглах дуудлагын төрлийг сонгоно (эсвэл Асаах -г сонгоно).
	Хариулах Дохио өгөх	Принтер автоматаар факс хүлээн авахаас өмнө дуугарах дуудлагын тоог сонгоно. Та факсыг ямарваа дуугүйгээр хүлээн авахыг хүсэж байвал "0" (тэг)-г сонгоно.
	Алсын Хүлээн авалт	Та принтертэй холбогдсон утсаар ирж буй факсын дуудлагад хариу өгөх үед, та утсаа ашиглан код оруулж факс хүлээн авч эхлүүлэх боломжтой.

Принтерийн үндсэн мэдээлэл

Цэс	Тохиргоо, тайлбар	
Гаралтын Тохиргоо	Факсын Гаралт	Хүлээн авсан баримтуудыг компьютер дээр хадгална. Та компьютер дээрх FAX Utility дээр тохиргоо хийх шаардлагатай.
	Автоматаар Багасгах	Цаасны эх үүсвэрийн цаасан дээр багтаахын тулд хүлээж авсан баримт бичгийг хэмжээг багасгана. Хүлээж авсан мэдээллээс шалтгаалж үргэлж багасгах боломжгүй байж болно. Энэхүү тохиргоог унтраавал, том баримт бичгүүд олон хуудсан дээр анхны хэмжээгээрээ хэвлэгдэх, эсвэл хоёрдогч хоосон цаас үйлдвэрлэх болно.
	Автоматаар Эргүүлэх	Хөндлөн чиглэлтэй A5 хэмжээтэй баримт бичгийг хүлээн авсан үед A5 хэмжээтэй цаасан дээр хэвлэхээр автоматаар эргүүлэх ба цаасны эх үүсвэр тохиргоо A5 дээр хийгдэнэ. Энэхүү тохиргоог идэвхгүй болгосон үед A4 хэмжээтэй цаасан дээр хэвлэнэ.
	Зэрэгцүүлсэн багана	Хэвлэсэн баримт бичиг хуудасны зөв дарааллаар байхын тулд хүлээж авсан баримт бичгийг сүүлийн хуудас (буурах дарааллаар хэвлэнэ)-наас хэвлэнэ. Принтерийн санах ой багассан үед, энэхүү тохиргоог ашиглах боломжгүй байж болно.
	Хэвлэлтийг Саатуулах Хугацаа	Оруулсан цаг хугацаанд хүлээн авсан баримт бичгийг хэвлэхээ зогсоож дахин асна. Тогтоосон цаг хугацаанд хүлээн авсан баримт бичгийг хэвлэхгүй боловч санах ойд хадгалагдана. Принтерийн санах ой багассан үед, энэхүү тохиргоог ашиглах боломжгүй байж болно. Унтраагаад асаасны дараа хүлээн авсан баримт бичгийг автоматаар хэвлэнэ. Шөнийн цагт дуу чимээнээс хамгаалах, таныг байхгүй хооронд нууц мэдээллийг задруулахаас сэргийлэх зорилгоор энэхүү тохиргоог ашиглаж болно.
	Тайланд зураг хавсаргах	Илгээсэн баримт бичгийн эхний хуудасны зургийг Дамжуулалтын Тайлан -ний хамт хэвлэнэ. Асаах (Том Зураг): Хуудасны дээд хэсгийг багасгахгүйгээр хэвлэнэ. Асаах (Жижиг Зураг): Тайланд багтаахаар бүхэл хуудсыг багасгаж хэвлэнэ.
	Факсын Логийг Автоматаар Хэвлэх	Факсын бүртгэлийг автоматаар хэвлэнэ. Асаах(30 факс тутамд): 30 факсын ажил хүлээн авсах бүрт бүртгэлийг хэвлэнэ. Асаах(Хугацаа): Бүртгэлийг заасан хугацаанд хэвлэнэ. Гэвч, факсын ажлын тоо 30-с хэтэрсэн үед, тогтоосон цаг хугацаанаас өмнө бүртгэлийг хэвлэнэ.
	Тайлангийн Формат	Протоколын Мөрдлөг -с бусад факсын тайлангийн форматыг сонгоно. Алдааны кодыг хэвлэхийн тулд Дэлгэрэнгүй -г сонгоно.

Принтерийн үндсэн мэдээлэл

Цэс	Тохиргоо, тайлбар	
Үндсэн Тохиргоо	Факсын Хурд	Факс дамжуулах хурдыг сонгоно. Гадаадаас факс авах/гадаад руу илгээх үед болон та IP (VoIP) утасны үйлчилгээ ашиглах үед холболтын алдаа байнга тохиолддог бол Удаан(9,600bps) -г сонгохыг бид санал болгож байна.
	ЕСМ	Телефон утасны шугамын дуунаас үүссэн факс дамжуулах алдааг автоматаар засна (Алдаа засах горим). Энэхүү тохиргоог идэвхгүй болговол, та баримт бичгийг өнгөтөөр явуулж хүлээж авч чадахгүй болно.
	Дуудлагын Дохио Танилт	Залгаж эхлэхээс өмнө залгах дууг илрүүлнэ. Принтер нь PBX (Хувийн салбарын солилцох) эсвэл дижитал утасны сүлжээнд холбогдсон, принтер залгаж эхлэхдээ алдаа гаргах болно. Энэ тохиолдолд, Шугамын Төрөл тохиргоог PBX болгож өөрчилнө. Ингээд болохгүй бол, энэхүү тохиргоог идэвхгүй болго. Гэвч, энэхүү тохиргоо идэвхгүй болгосноор факсын дугаарын эхний орныг устгаж, факсын машинд буруу дугаар явуулах магадлалтай.
	Дуудах Горим	Принтерт холбосон утасны системийн төрлийг сонгоно. Чичиргээ дээр тохируулсан үед, та залгах горимоо * ("Т"-г оруулсан) дээр дарж факсын дээд дэлгэц дээр дугаар оруулангаа пульсээс тон руу түр зуур шилжүүлж болно. Бүс нутгаас хамаарч, энэхүү тохиргоо гарч ирэхгүй байж болно.
	Шугамын Төрөл	Принтерт холбосон шугамын төрлийг сонгоно. Дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд факсын үндсэн тохиргоог тодорхойлсон хуудсыг үзнэ үү.
	Толгой	Илгээгчийн нэр болон факсын дугаараа оруулна. Энэ нь гадагш явж буй факсны толгой болж харагдана. Та нэр дээрээ 40 хүртэл тэмдэгт, факсын дугаар дээрээ 20 хүртэлх тоог оруулах боломжтой.
Аюулгүй байдлын Тохиргоо	Нөөцлөх Өгөгдлийг Автоматаар Арилгах	Хяналтын самбар ашиглан устгасан факсын баримт бичиг нь LCD дэлгэцээс арилах боловч тэдгээрийн нөөц хувилбар санах ойд түр зуур хадгалагдана. Дараах тохиргоо нөөц хувилбарыг устгана. Нөөцлөх Өгөгдлийг Автоматаар Арилгах: Явуулсан эсвэл хүлээн авсан баримт бичгийг устгах бүрт нөөц хувилбарыг автоматаар устгана. Нөөцлөх Өгөгдлийг Арилгах: Бүх нөөц хувилбарыг устгана. Та тус принтерийг хэн нэгэнд өгөх, эсвэл хаяхдаа үүнийг ажиллуулна.
	Нөөцлөх Өгөгдлийг Арилгах	
Факсын Холболтыг шалгах	Принтер утасны шугамд холбогдож факс дамжуулахад бэлэн эсэхийг шалгаж, шалгасан үр дүнгээ А4 хэмжээтэй ердийн цаасан дээр хэвлэнэ.	
Факсын Тохиргооны Визард	Дэлгэц дээрх зааврыг дагаснаар факсын үндсэн тохиргоог хийх сонголтыг хийнэ. Дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд факсын үндсэн тохиргоог тодорхойлсон хуудсыг үзнэ үү.	


Холбогдох мэдээлэл

- ➔ 20 хуудас дээрх “**Факсдах** горим”
- ➔ 72 хуудас дээрх “Факсын үндсэн тохиргоог хийх”


Цаас ачаалах

Цаас ашиглахтай холбоотой анхааруулга

- ❑ Цаастай цуг ирэх зааврын хуудсыг унших.
- ❑ Ачаалахаас өмнө цаасны өнцгийг имэрч эгнүүлэх. Фото цаасыг имэрч нугалж болохгүй. Тэгсэн тохиолдолд цаасны хэвлэх талд гэмтэл учруулна.



- ❑ Хэрэв цаас нугаларсан бол ачаалахаас өмнө түүнийг тэнийлгэж, эсрэг талаар нь бага зэргээр нугална. Нугаларсан цаасан дээр хэвлэх нь хэвлэх үед цаасыг бөглөрөх, бохирдоход хүргэнэ.



- ❑ Үрчийсэн, урагдсан, зүссэн, нугалсан, чийгтэй хэт зузаан, эсвэл хэт нимгэн наалт наасан цаасыг ашиглахгүй. Эдгээр төрлийн цаасыг ашигласнаас цаас бөглөрөх, хэвлэмэл материал бохирдоход хүргэнэ.
- ❑ Ачаалахаас өмнө дугтуйн өнцгийг имэрч эгнүүлэх. Давхарласан дугтуйн дотор зай орсон бол, ачаалахаас өмнө тэдгээрийг доош нь дарж агаарыг гаргана.



- ❑ Үрчийсэн, эсвэл нугаларсан дугтуйг ашиглахгүй. Эдгээр дугтуйг ашигласнаас цаас бөглөрөх, хэвлэмэл материал бохирдоход хүргэнэ.
- ❑ Дугтуй, нэвт харагддаг дугтуйн дээрх наалдамтгай гадаргуутай дугтуйг ашиглахгүй.
- ❑ Хэт нимгэн дугтуй нь хэвлэх явцад нугаларах магадлалтай тул ашиглахаас зайлсхийх.

Холбогдох мэдээлэл

➔ [139 хуудас дээрх “Принтерийн үзүүлэлт”](#)

Бэлэн байгаа цаас ба багтаамж

Өндөр чанартай хэвлэлтийг гаргахын тулд жинхэнэ Epson цаасыг ашиглахыг Epson зөвлөж байна.

Жинхэнэ Epson цаас

Хэрэгслийн Нэр	Хэмжээ	Ачаалах Багтаамж (Хуудас)	2-талт Хэвлэлт
Epson Bright White Ink Jet Paper	A4	120	Автомат, Гар аргаар ^{*1}
Epson Premium Glossy Photo Paper ^{*2}	A4, 13×18 см (5×7 инч), 16:9 өргөн хэмжээтэй (102×181 мм), 10×15 см (4×6 инч)	20 ^{*3}	-
Epson Matte Paper-Heavyweight ^{*2}	A4	20	-
Epson Photo Quality Ink Jet Paper ^{*4}	A4	80	-

*1 Нэг талд нь аль хэдийн хэвлэсэн 30 хүртэлх хуудсыг ачаалах боломжтой.

*2 Зөвхөн компьютер эсвэл ухаалаг төхөөрөмжөөс хэвлэх боломжтой.

*3 Хэрэв цаас зөв ачаалагдахгүй эсвэл хэвлэлт жигд бус өнгөтэй, балархайтсан байвал цаасыг нэг нэгээр нь ачаал.

*4 Зөвхөн компьютероос хэвлэх боломжтой.

Тэмдэглэл:

- ❑ Цаасны олдоц байрлалаас шалтгаалж ялгаатай байна. Өөрийн бүсийн цаасны олдцын талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээллийг авахын тулд Epson тусламж үйлчилгээтэй холбоо барина уу.
- ❑ Хэрэглэгчийн тодорхойлсон хэмжээтэй жинхэнэ Epson цаасан дээр хэвлэж байх үед зөвхөн **Стандарт** эсвэл **Normal** хэвлэлтийн чанарыг ашиглах боломжтой. Зарим принтерийн драйвер дээр илүү сайн чанарын хэвлэлтийг сонгож болох боловч, эцсийн хэвлэлт **Стандарт** эсвэл **Normal** чанараар л хэвлэгдэнэ.

Худалдаанд бэлэн байгаа цаас

Хэрэгслийн Нэр	Хэмжээ	Ачаалах Багтаамж (Хуудас буюу Дугтуйнууд)	2-талт Хэвлэлт
Ердийн цаас Хуулбар цаас	Letter, A4, B5 ^{*1}	Ирмэг заагч дээрх гурвалжин тэмдгийн заасан шугам хүртэл.	Автомат, Гар аргаар ^{*2}
	A5, A6 ^{*1}		Гар аргаар ^{*2}
	Legal	30	Гар аргаар ^{*3}
	Хэрэглэгчийн Тодорхойлсон ^{*1}	1	Автомат, Гар аргаар

Цаас ачаалах

Хэрэгслийн Нэр	Хэмжээ	Ачаалах Багтаамж (Хуудас буюу Дугтуйнууд)	2-талт Хэвлэлт
Дугтуй* ¹	Дугтуй #10, Дугтуй DL, Дугтуй C6	10	-

*1 Зөвхөн компьютер эсвэл ухаалаг төхөөрөмжөөс хэвлэх боломжтой.

*2 Нэг талд нь аль хэдийн хэвлэсэн 30 хүртэлх хуудсыг ачаалах боломжтой.

*3 Нэг талд нь аль хэдийн хэвлэсэн 1 хүртэлх хуудсыг ачаалах боломжтой.

Холбогдох мэдээлэл

➔ [149 хуудас дээрх "Техник туслалцааны вэбсайт"](#)

Цаасны төрлийн жагсаалт


Хамгийн шилдэг хэвлэмэл материалыг гаргахын тулд цаасанд тохирсон цаасны төрлийг сонгоно.

Хэрэгслийн нэр	Хэрэгслийн төрөл	
	Хяналтын самбар	Принтер драйвер, ухаалаг төхөөрөмж*
Epson Bright White Ink Jet Paper	цулгүй цааснууд	Цулгүй цаас
Epson Premium Glossy Photo Paper	Дээд зэргийн. Гялгар	Epson Premium Glossy
Epson Matte Paper-Heavyweight	Матте	Epson Matte
Epson Photo Quality Ink Jet Paper	Матте	Epson Matte
Ердийн цаас	цулгүй цааснууд	Цулгүй цаас
Дугтуй	Дугтуй	Дугтуй


* Ухаалаг төхөөрөмжийн хувьд Epson iPrint-г ашиглаж хэвлэх үед эдгээр хэрэгслийн төрлийг сонгож болно.

Цаасан Кассет руу цаас ачаалах

1. Принтер ажиллаагүй байгаа эсэхийг шалгаад цаасан кассет-ийг татаж гарга.




2. Ирмэг заагчийг дээд цэгт нь тултал гүйлгэ.




Тэмдэглэл:

А4 хэмжээнээс том цаас ашиглах үед, цаасан кассет-ийг сунгана.




3. Урд ирмэг заагчийг ашиглахыг хүссэн цаасны хэмжээндээ тааруулж гүйлгэ.



Цаас ачаалах


4. Цаасыг хэвлэх нүүрийг нь доош харуулан урд ирмэг заагчид тулгаж ачаал.




Чухал:

- ❑ Цаас цаасан кассет-ийн эцэс дэх гурвалжин тэмдэгээс цааш гараагүй эсэхийг магадла.
- ❑ Тухайн цаасанд заасан хуудасны дээд тооноос илүү ихийг бүү ачаалаарай. Цулгүй цаасны хувьд, ирмэг заагч дээрх гурвалжин тэмдгийн заасан шугамаас дээш гаргаж ачаалахгүй байх хэрэгтэй.

❑ Дугтуй



❑ Цоолбортой цаас




Цаас ачаалах

Тэмдэглэл:

Цоолбортой цаасыг дараах нөхцөлд ашиглаж болно. Автомат 2-талт хэвлэлтийг цоолбортой цаасанд ашиглах боломжгүй.

- ❑ Ачаалах багтаамж: Нэг хуудас
- ❑ Боломжтой хэмжээ: A4, B5, A5, A6, Letter, Legal
- ❑ Үдэх нүх: Дээд эсвэл доод талдаа үдэх нүхтэй цаасыг бүү ачаал.
Цоолсон нүхэн дээгүүр хэвлэхээс сэргийлж файлынхаа хэвлэх байрлалыг тохируул.

5. Ирмэг заагчийг цаасны ирмэг рүү тулгаж гулгуул.




6. цаасан кассет-ийг цааш нь бүрэн түлхэж оруул.
7. Хянах самбар дээр, цаасан кассет-т ачаалсан цаасныхаа хэмжээ, төрлийг тохируулна.

Тэмдэглэл:

Та мөн **Тохируулга > Цаасны Тохируулга**-г сонгож цаасны хэмжээ, цаасны төрлийн тохиргооны дэлгэцийг харуулах боломжтой.

8. Гаралтын тэвшийг гулсуулж гарга.



Холбогдох мэдээлэл

- ➔ 28 хуудас дээрх "Цаас ашиглахтай холбоотой анхааруулга"
- ➔ 29 хуудас дээрх "Бэлэн байгаа цаас ба багтаамж"

Эх хувийг байрлуулах

сканнерын шил эсвэл ADF дээр эх хувийг байрлуулна. ADF-н дэмждэггүй эх хувь дээр сканнерын шил-г ашиглана.

Та ADF-тай нэг зэрэг олон тооны хуулбарыг скандаж болно.

ADF-д зориулж бэлдсэн эх хувилбар

Бэлэн байгаа цаасны хэмжээ	A4, Захидал, Албан хэрэглээний цаас
Цаасны төрөл	Ердийн цаас
Цаасны зузаан (Цаасны жин)	64-с 95 гр/м ²
Ачаалах хүчин чадал	A4, Letter: 30 хуудас ба 3 мм Legal: 10 хуудас

Хэдийгээр эх ADF дээр байрлуулах медианы үзүүлэлттэй тохирсон ч гэсэн ADF-с татахгүй эсвэл цаасны чанар болон үзүүлэлтээс хамаарч сканнерийн чанар муудаж болзошгүй.



Чухал:

Гэрэл зураг болон үнэтэй цэнэтэй урлагийн бүтээлийг ADF рүү оруулж болохгүй. Буруу оруулснаар эх хувийг үрчийлгэж, гэмтээж болзошгүй. Ийм бичиг баримтуудыг сканнерийн шилэн дээр тавьж сканнердана уу.

Цаас бөглөрөхөөс сэргийлэхийн тулд ADF дээр дараах эх хувийг байрлуулахаас зайлсхий. Эдгээр төрлийн хувьд сканнерын шил-г ашиглана.


- ☐ Урагдсан, нугалсан, үрчийсэн, муудсан, эсвэл базсан эх хувь
- ☐ Цоолтуурын нүхтэй эх хувь
- ☐ Наалт, үдээс, цаас хавчигч зэргээр холбосон эх хувь.
- ☐ Тэдгээрийг холбох стикер эсвэл шошго бүхий эх хувь
- ☐ Ердийн бусаар зүссэн, эсвэл зөв өнцөггүй эх хувь
- ☐ Нэгтгэсэн эх хувь
- ☐ ОНР-үүд, дулаан дамжуулагч цаас, эсвэл нүүрстөрөгчийн артай

ADF дээр эх хувийг байрлуулах


1. Эх хувийг хүрээ хүртэл эгнүүлнэ.

Эх хувийг байрлуулах

2. ADF төгсгөлийн чиглүүлэгчийг гулгуулна.




3. Эх хувийн нүүрийг дээш харуулж ADF дээр байрлуулна.



Чухал:

- ❑ Эх хувийг ADF хүрээний чиглүүлэгч доторх ▼ тэмдгийн яг дор байрлах шугамаас дээш гаргаж ачаалахгүй байх.
- ❑ Скандаж байхдаа эх хувийг нэмж болохгүй.

4. ADF ирмэгийн чиглүүлэгчийг эх хувийн ирмэг рүү гулгуул.



Холбогдох мэдээлэл

- ➔ 34 хуудас дээрх “ADF-д зориулж бэлдсэн эх хувилбар”

Сканнерын Шил дээр эх хувийг байрлуулах



Болгоомжтой:


Баримтын тагийг хаахдаа хуруугаа хавчуулахаас болгоомжлоорой. Эс бөгөөс гэмтэх аюултай.




Чухал:

Ном зэрэг том оврын эх хувийг байрлуулахдаа сканнерын шил дээр гадны гэрэл шууд тусахаас сэргийлнэ.

1. Баримтын тагийг нээнэ.



2. сканнерын шил дээрх аливаа тоос, толбыг арилгана.
3. Эх хувийн нүүрийг доош харуулж, өнцгийн тэмдэг рүү шахаж тавина.



Эх хувийг байрлуулах

Тэмдэглэл:

- ☐ сканнерын шил-н хүрээнээс 1,5 мм-н зайд буй хэсгийг скандахгүй.
- ☐ Эх хувийг ADF дээр болон сканнерын шил дээр байрлуулах үед, ADF дээрх эх хувьд давуу талыг өгнө.

4. Тагийг зөөлөн хаана уу.



Чухал:

сканнерын шил эсвэл бичиг баримтын гадар дээр хэт дарж болохгүй. Эс бөгөөс тухайн зүйлс гэмтэж болно.

Тэмдэглэл:

Скандаж, эсвэл хуулбарлаж дууссаны дараа эх хувийг авна уу. Эх хувийг сканнерын шил дээр удаан хугацаагаар байлгавал, тэдгээр нь шилний гадаргуутай наалдах аюултай.

ХЭВЛЭХ

Компьютероос хэвлэх

Хэвлэх үндсэн мэдээлэл - Windows

Тэмдэглэл:

- ❑ Тохиргооны хэсгүүдийн тайлбарыг онлайн тусламжаас харна уу. Тухайн хэсэг дээр хулганы баруун товчоор дарж, **Тусламж**-г дарна.
- ❑ Програмаас шалтгаалж үйлдлүүд нь ялгаатай байж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.

1. Принтерт цаасыг ачаал.




Чухал:

Хянах самбар дээр цаасны тохиргоог хийнэ.

2. Хэвлэхийг хүссэн файлаа нээ.
3. **Хэвлэх** эсвэл **Хэвлэх Тохируулга**-г **Файл** цэснээс сонгоно.
4. Принтерээ сонгоно.

Хэвлэх

5. Принтерийн драйверын цонхонд хандахын тулд **Тохируулгууд** эсвэл **Шинж чанар**-г сонгоно уу.



6. Дараах тохиргоог хийнэ үү.

- ☐ Баримтын Хэмжээ: Принтерт ачаалсан цаасны хэмжээгээ сонгоно.
- ☐ Чиг: Програмд тохируулсан чиглэлээ сонгоно.
- ☐ Цаасны Төрөл: Ачаалсан цаасны төрлөө сонгоно.
- ☐ Өнгө: Хар, эсвэл саарал өнгүүдээр хэвлэхийг хүсвэл **Грейскейл**-г сонгоно.

Тэмдэглэл:

- ☐ *Хэрэв өндөр нягтшилтай өгөгдлийг цулгүй цаас, захидлын толгой, урьд нь хэвлэсэн цаасан дээр хэвлэх бол, улам тод харгадуулж хэвлэхийн тулд Стандарт-Тод-г Чанар тохиргоонд сонгоно.*
- ☐ *Дугтуйн дээр хэвлэх үед, Хэвтээ-г **Чиг** тохиргоо болгож сонгоно.*

7. **ОК** товчийг дарж принтерийн драйверын цонхыг хаана.

8. **Хэвлэх** товчийг дар.

Холбогдох мэдээлэл

- ➔ 29 хуудас дээрх "Бэлэн байгаа цаас ба багтаамж"
- ➔ 31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"
- ➔ 30 хуудас дээрх "Цаасны төрлийн жагсаалт"

Хэвлэх үндсэн мэдээлэл - Mac OS X

Тэмдэглэл:

- ❑ Энэ хэсгийн тайлбарт TextEdit-ийг жишээ болгон хэрэглэсэн. Програмаас шалтгаалж үйлдлүүд болон дэлгэцний байдал нь ялгаатай байна. Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.
- ❑ Дугтуй хэвлэхдээ, програмыг ашиглан өгөгдлийг 180 хэм эргүүлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.

1. Принтерт цаасыг ачаал.




Чухал:

Хянах самбар дээр цаасны тохиргоог хийнэ.

2. Хэвлэхийг хүссэн файлаа нээ.
3. Хэвлэх харилцах цонход хандахын тулд **Хэвлэх**-ийг **Файл** цэс буюу өөр бусад удирдлагаас сонго.

Хэрэв шаардлагатай бол, **Дэлгэрэнгүйг Харуулах** эсвэл ▼-г дарж хэвлэх цонхыг томруулна.



4. Дараах тохиргоог хийнэ үү.
 - ❑ Принтер: Принтерээ сонгоно.
 - ❑ Урьдчилсан тохиргоо: Бүртгэгдсэн тохиргоог ашиглахыг хүсвэл үүнийг сонгоно.
 - ❑ Цаасны Хэмжээ: Принтерт ачаалсан цаасны хэмжээгээ сонгоно.
 - ❑ Чиглэл: Програмд тохируулсан чиглэлээ сонгоно.

Тэмдэглэл:

- ❑ Хэрэв дээрх тохиргооны цэснүүд харагдахгүй байвал, **Цаасны Тохируулга**-г **Файл** файл цэснээс сонгож тохиргоог хийнэ.
- ❑ Захидал хэвлэх үед, хөндлөн чиглэлийг сонгоно.

Хэвлэх

5. Дэлгэгддэг цэснээс **Хэвлэх Тохиргоо**-г сонгоно.

Тэмдэглэл:

Mac OS X v10.8.x болон дараагийн хувилбаруудад, **Хэвлэх Тохиргоо** цэс гарч ирэхгүй бол, Epson принтерийн драйвер зөв суулгадаагүй байна гэсэн үг.

Системийн Тохируулгууд-г  цэс > **Принтер & Сканнер** (эсвэл **Хэвлэх & Сканнердах, Хэвлэх & Факсдах**)-аас сонгож, принтерийг устгаад дахин нэмнэ. Принтер нэмэх зааврыг дараахаас харна уу.

<http://epson.sn>

6. Дараах тохиргоог хийнэ үү.

- ☐ Media Type: Ачаалсан цаасны төрлөө сонгоно.
- ☐ Грейскейл: Хар буюу саарал өнгүүдээр хэвлэх үед сонгоно.

Тэмдэглэл:

Хэрэв өндөр нягтшилтай өгөгдлийг цулгүй цаас, захидлын толгой, урьд нь хэвлэсэн цаасан дээр хэвлэх бол, улам тод харгадуулж хэвлэхийн тулд **Normal-Vivid**-г **Print Quality** тохиргоонд сонгоно.

7. **Хэвлэх** товчийг дар.

Холбогдох мэдээлэл

- ➔ 29 хуудас дээрх "Бэлэн байгаа цаас ба багтаамж"
- ➔ 31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"
- ➔ 30 хуудас дээрх "Цаасны төрлийн жагсаалт"

2-талаар хэвлэх

Хоёр талаар хэвлэхийн тулд доорх аргуудын аль нэгийг ашиглах боломжтой.


Хэвлэх

☐ Автомат 2-талт хэвлэлт

☐ Гар аргаар 2-талт хэвлэлт (зөвхөн Windows)

Принтер эхний талыг хэвлэж дууссаны дараа, цаасыг эргүүлж нөгөө тал дээр нь хэвлэнэ.

Хэвлэсэн материалыг нугалж товхимол үүсгэхээр бас хэвлэж боломжтой. (Зөвхөн Windows)



Тэмдэглэл:

- ☐ 2-талт хэвлэлтэнд тохиромжтой цаасыг ашиглахгүй бол, хэвлэлийн чанар муудаж, цаас гацалт үүсэх боломжтой.
- ☐ Цаас болон өгөгдлөөс шалтгаалж, бэх цаасны нөгөө тал руу нэвчиж магадгүй.

Холбогдох мэдээлэл

➔ 29 хуудас дээрх "Бэлэн байгаа цаас ба багтаамж"

2-талаар хэвлэх - Windows

Тэмдэглэл:

- ☐ **EPSON Status Monitor 3** идэвхижсэн тохиолдолд гар аргаар 2-талт хэвлэлтийг хийх боломжтой. Хэрэв **EPSON Status Monitor 3** идэвхижээгүй бол, принтерийн драйверт нэвтэрч, **Өргөтгөсөн Тохиргоо**-г **Арчилгаа** таб дээрээс сонгоод, **EPSON Status Monitor 3-г идэвхжүүл**-г сонгоно.
 - ☐ Принтерт сүлжээгээр дамжиж хандах, эсвэл принтерийг хуваан хэрэглэж байгаа тохиолдолд гар аргаар 2-талт хэвлэлтийг гүйцэтгэх боломжгүй.
1. Принтерт цаасыг ачаал.
 2. Хэвлэхийг хүссэн файлаа нээ.
 3. Принтерийн драйверийн цонхонд хандана.
 4. **Үндсэн** табын **2-талт Хэвлэлт** дээрх **Автомат (Урт-ирмэгээр үдэх)**, **Автомат (Богино-ирмэгээр үдэх)**, **Гар аргаар (Урт-ирмэгээр үдэх)**, эсвэл **Гар аргаар (Богино-ирмэгээр үдэх)**-ийг сонгоно.
 5. **Тохиргоо**-г дарж зохих тохиргоог хийгээд **ОК**-г дарна.

Тэмдэглэл:

Нугалмал товхимол хэвлэхийн **Товхимол**-г сонгоно.

Хэвлэх

6. **Хэвлэх Нягтшил**-г дарж, **Баримтын Төрлийг Сонгох** дээрээс баримтын төрлийг сонгоод **ОК**-г дарна.

Принтерийн драйвер нь тухайн баримтын төрөлд тааруулан **Тааруулга** сонголтыг автоматаар хийх болно.

Тэмдэглэл:

- ☐ **Хэвлэх Нягтшил Тааруулах** цонхон дахь **Баримтын Төрлийг Сонгох** болон **Үндсэн** таб дахь **Чанар** дээр сонгосон сонголтуудын зохицолоос шалтгаалж хэвлэлт удаашрах боломжтой.
- ☐ Гар аргаар 2-талт хэвлэлт хийхэд, **Хэвлэх Нягтшил Тааруулах** тохиргоог ашиглах боломжгүй.

7. Шаардлагатай бол **Үндсэн** болон **Илүү Сонголтууд** таб дээрх бусад зүйлсийг тохируулсны дараа **ОК**-г дарна.

8. **Хэвлэх** товчийг дар.

Гар аргаар 2-талт хэвлэлтийг гүйцэтгэх үед, эхний тал хэвлэгдэж дууссаны дараа, компьютер дээр дэлгэгддэг цонх гарч ирнэ. Дэлгэц дээрх зааврыг дагаарай.

Холбогдох мэдээлэл

- ➔ 31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"
- ➔ 38 хуудас дээрх "Хэвлэх үндсэн мэдээлэл - Windows"

2-талаар хэвлэх - Mac OS X

1. Принтерт цаасыг ачаал.
2. Хэвлэхийг хүссэн файлаа нээ.
3. Принтерийн харилцах цонхонд хандана.
4. Дэлгэгддэг цэснээс **Two-sided Printing Settings**-г сонгоно.
5. Үдэлт болон **Document Type**-ийг сонго.

Тэмдэглэл:

- ☐ **Document Type** тохиргооноос болж хэвлэлт удааширсан байх бас боломжтой.
- ☐ Хэрэв зураг, фото зураг зэрэг өндөр нягтшилтай өгөгдлийг хэвлэж байгаа бол, **Text & Graphics** эсвэл **Text & Photos-r Document Type** тохиргоонд сонгоорой. Хэрэв цаас үнгэгдэх, эсвэл зураг эсрэг талдаа нэвтэрч харагдвал, хэвлэх нягтшил болон бэх хатах хугацааг **Adjustments**-ийн хажуу дахь суман тэмдгэн дээр дарж тааруулна.


6. Шаардлагатай бусад тохиргоог бас хийнэ.
7. **Хэвлэх** товчийг дар.

Холбогдох мэдээлэл

- ➔ 31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"
- ➔ 40 хуудас дээрх "Хэвлэх үндсэн мэдээлэл - Mac OS X"

Нэг хуудсан дээр хэд хэдэн хуудсыг хэвлэх

Та нэг хуудсан дээр 2 эсвэл 4 хуудас мэдээллийг хэвлэх боломжтой.



Нэг хуудсан дээр олон хуудас хэвлэх — Windows

1. Принтер дээр цаас ачаалах.
2. Хэвлэхийг хүсэж буй файлаа нээнэ.
3. Принтерийн драйверийн цонхонд хандана.
4. **2-дээшээ** эсвэл **4-дээшээ**-г **Олон-Хуудаст** тохиргоо болгож **Үндсэн** таб дээр сонгоно.
5. **Хуудасны Дараалал** дарж зохих тохиргоог хийж, дараа нь **ОК**-г дарж цонхыг хаана.
6. Шаардлагатай бол **Үндсэн** болон **Илүү Сонголтууд** таб дээр бусад зүйлсийг тохируулж, дараа нь **ОК** товчийг товшино.
7. **Хэвлэх** товчийг товшино.

Холбогдох мэдээлэл

- ➔ 31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"
- ➔ 38 хуудас дээрх "Хэвлэх үндсэн мэдээлэл - Windows"

Нэг хуудсан дээр олон хуудас хэвлэх — Mac OS X

1. Принтер дээр цаас ачаалах.
2. Хэвлэхийг хүсэж буй файлаа нээнэ.
3. Принтерийн харилцах цонхонд хандана.
4. Дэлгэгддэг цэснээс **Загвар**-г сонгоно.

Хэвлэх

5. **Нүүрэн дээрх хуудас**-ны тоо, **Загварын чиглэл** (хуудасны дараалал), **Хүрээ**-г тохируулна.
6. Шаардлагатай бол бусад зүйлсийг тохируулна.
7. **Хэвлэх** товчийг товшино.

Холбогдох мэдээлэл

- ➔ 31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"
- ➔ 40 хуудас дээрх "Хэвлэх үндсэн мэдээлэл - Mac OS X"

Цаасны хэмжээнд тааруулж хэвлэх

Принтерт ачаалсан цаасныхаа хэмжээтэй тохируулж хэвлэх боломжтой.



Цаасны хэмжээнд тохируулж хэвлэх — Windows

1. Принтер дээр цаас ачаалах.
2. Хэвлэхийг хүсэж буй файлаа нээнэ.
3. Принтерийн драйверийн цонхонд хандана.
4. **Илүү Сонголтууд** таб дээрх дараах тохиргоог хийнэ.
 - ☐ Баримтын Хэмжээ: Программ хангамжид тохируулсан цаасны хэмжээгээ сонгоно.
 - ☐ Гаралтын Цаас: Принтерт ачаалсан цаасны хэмжээгээ сонгоно.**Хуудсанд Тааруулах** автоматаар сонгогдоно.
Тэмдэглэл:
*Та цаасны голд багасгасан зураг хэвлэхийг хүсэж байгаа бол **Төв** тохиргоог сонгоно.*
5. Шаардлагатай бол **Үндсэн** болон **Илүү Сонголтууд** таб дээр бусад зүйлсийг тохируулж, дараа нь **ОК** товчийг товшино.
6. **Хэвлэх** товчийг товшино.

Хэвлэх

Холбогдох мэдээлэл

- ➔ 31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"
- ➔ 38 хуудас дээрх "Хэвлэх үндсэн мэдээлэл - Windows"

Цаасны хэмжээнд тохируулж хэвлэх — Mac OS X


1. Принтер дээр цаас ачаалах.
2. Хэвлэхийг хүсэж буй файлаа нээнэ.
3. Принтерийн харилцах цонхонд хандана.
4. Программ хангамж дотор **Цаасны Хэмжээ** тохиргоонд сонгосон цаасны хэмжээгээ тохируулна.
5. Дэлгэгддэг цэснээс **Цаас ашиглах** тохиргоог сонгоно.
6. **Цаасны хэмжээнд тохируулах хэмжээ** тохиргоог сонгоно.
7. **Сонгосон цаасны хэмжээ** тохиргоо болгож принтерт ачаалсан цаасны хэмжээгээ сонгоно.
8. Шаардлагатай бол бусад зүйлсийг тохируулна.
9. **Хэвлэх** товчийг товшино.

Холбогдох мэдээлэл

- ➔ 31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"
- ➔ 40 хуудас дээрх "Хэвлэх үндсэн мэдээлэл - Mac OS X"

Олон тооны файлыг хамт хэвлэх (Windows-т зөвхөн)

Ажил Эмхлэгч Лайт нь өөр өөр программ хангамжийн тусламжтай бүтээсэн хэд хэдэн файлыг нэгтгэж нэг хэвлэх ажил болгон хэвлэх боломжийг олгоно. Та нэгтгэсэн файлын хувьд хэвлэх тохиргоо буюу загвар, хэвлэх дараалал, чиглэл зэргийг тодорхойлж болно.



Тэмдэглэл:

Прожектыг Хэвлэх-г Ажил Эмхлэгч Лайт дээр хадгалсан байршлаас нээхийн тулд **Ажил Эмхлэгч Лайт-г** принтерийн драйверийн **Арчилгаа** таб дээрээс дарна. Дараа нь, файлаа сонгохын тулд **Нээх-г Файл** цэснээс сонгоно. Хадгалсан файлын өргөтгөл нь "esl" байна.

1. Принтер дээр цаас ачаалах.

Хэвлэх


2. Хэвлэхийг хүсэж буй файлаа нээнэ.
3. Принтерийн драйверийн цонхонд хандана.
4. **Ажил Эмхлэгч Лайт**-г **Үндсэн** таб дээрээс сонгоно.
5. Принтерийн драйверийн цонхыг хаахын тулд **ОК** товчийг товшино.
6. **Хэвлэх** товчийг товшино.
Ажил Эмхлэгч Лайт цонх гарч ирэн, хэвлэх ажил **Прожектыг Хэвлэх** дээр нэмэгдэнэ.
7. **Ажил Эмхлэгч Лайт** цонх нээлттэй байхад, одоо ажиллаж буй файлтайгаа нэгтгэхийг хүсэж буй файлаа нээн, дээрх 3-6 алхмыг давтан хийнэ.
Тэмдэглэл:
Ажил Эмхлэгч Лайт цонхыг та хаасан бол, хадгалагдаагүй **Прожектыг Хэвлэх** устгагдана.
Дараа нь хэвлэхийн тулд **Хадгалах**-г **Файл** цэснээс дарна.
8. **Бүдүүвч** болон **Засах** цэсийг **Ажил Эмхлэгч Лайт**-с сонгож **Прожектыг Хэвлэх**-г шаардлагатай бол засварлана.
9. **Хэвлэх**-г **Файл** цэснээс сонгоно.

Холбогдох мэдээлэл

- ➔ 31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"
- ➔ 38 хуудас дээрх "Хэвлэх үндсэн мэдээлэл - Windows"

Нэг зургийг олон хуудсан дээр хэвлэж зурагт хуудас үүсгэх (зөвхөн Windows)

Энэ тохиргоо нь танд, нэг зургийг олон хуудас цаасан дээр хэвлэх боломжийг олгоно. Хэвлэсэн хэсгүүдээ нийлүүлэн нааж илүү том зурагт хуудас үүсгэх боломжтой.



1. Принтер дээр цаас ачаалах.
2. Хэвлэхийг хүсэж буй файлаа нээнэ.
3. Принтерийн драйверийн цонхонд хандана.
4. **2x1 Плакат**, **2x2 Плакат**, **3x3 Плакат**, эсвэл **4x4 Плакат**-г **Олон-Хуудаст-с Үндсэн** таб дээрээс сонгоно.

Хэвлэх


5. **Тохиргоо** дарж зохих тохиргоог хийж, дараа нь **ОК**-г дарна.
6. Шаардлагатай бол **Үндсэн** болон **Илүү Сонголтууд** таб дээр бусад зүйлсийг тохируулж, дараа нь **ОК** товчийг товшино.
7. **Хэвлэх** товчийг товшино.

Холбогдох мэдээлэл

- ➔ 31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"
- ➔ 38 хуудас дээрх "Хэвлэх үндсэн мэдээлэл - Windows"


Давхардсан Зэрэгцүүлэлтын Тэмдэг ашиглан зурагт хуудас хийх

2x2 Плакат-г сонгосон үед, **Давхардсан Зэрэгцүүлэлтын Тэмдэг**-г **Таслах Зураас Хэвлэх** дээр сонгосон байхад зурагт хуудсыг хэрхэн хийх жишээг доор харуулав.




Хэвлэх

1. Sheet 1 ба Sheet 2-г бэлтгэнэ. Sheet 1-н хүрээг цэнхэр босоо шугамын дагуу хайчилж, дээд болон доод хөндлөн тэмдгийн голоор дайруулан зүснэ.




2. Sheet 1-н ирмэгийг Sheet 2-н дээд талд байрлуулж, хөндлөн тэмдгийг тааруулна. Дараа нь, хоёр хуудсыг ар талаар нь нийлүүлж түр наалтаар наана.




Хэвлэх

- Тохируулсан тэмдэглэлийн дагуу татсан босоо улаан шугамаар наасан хуудсыг хуваана (энэ удаад хөндлөн тэмдэглэгээний зүүн талын шугам).




- Хуудсуудыг ар талаар нь наана.




- Sheet 3 болон Sheet 4-г наахад 1-4-р алхмыг давтана.

Хэвлэх

- Зүүн болон баруун талын хөндлөн тэмдэглэгээний дундуур татсан хөндлөн хөх шугамаар Sheet 1 болон Sheet 2-н хүрээг тайрна.




- Sheet 1 болон Sheet 2 ирмэгийг Sheet 3 болон Sheet 4-н орой дээр байрлуулж, хөндлөн тэмдгийг тааруулан, дараа нь тэдгээрийг ар талаар нь түр наана.




Хэвлэх

8. Тохируулсан тэмдэглэгээний дундуур татсан улаан шугамын дагуу наасан хуудсыг хоёр хуваана (энэ удаад хөндлөн тэмдэгийн дээрх шугамаар).




9. Хуудсуудыг ар талаар нь наана.



Хэвлэх

10. Гаднах тэмдгийн дагуу үлдсэн хүрээг тайрна.

**Дээд зэргийн тохиргоог ашиглан хэвлэх**

Энэхүү хэсэгт принтерийн драйверийн ашиглах боломжтой нэмэлт загвар, хэвлэлийн төрөл бүрийн тохиргоог танилцуулна.

Холбогдох мэдээлэл

- ➔ [102 хуудас дээрх "Windows принтерийн драйвер"](#)
- ➔ [104 хуудас дээрх "Mac OS X принтерийн драйвер"](#)

Хэвлэх Урьдчилсан тохиргоог Нэмж Хялбархан Хэвлэх

Хэрэв та принтерийн драйверт өөрийн байнга хэрэглэдэг хэвлэх тохиргооноос урьдчилсан тохируулга үүсгэвэл, жагсаалтаас урьдчилсан тохируулгыг сонгон хялбархан хэвлэх боломжтой.

Хэвлэх

Windows

Өөрийн урьдчилсан тохируулгыг нэмэхийн тулд **Баримтын Хэмжээ** болон **Цаасны Төрөл** зэргийг **Үндсэн** эсвэл **Илүү Сонголтууд** таб дээр тохируулж **Урьдчилсан тохиргоог Нэмэх/Хасах**-ийг **Хэвлэлт Урьдчилж тохируул** дээр дар.

Тэмдэглэл:

Нэмсэн урьдчилсан тохируулгыг устгахын тулд **Урьдчилсан тохиргоог Нэмэх/Хасах**-ийг дарж, устгах тохируулгын нэрийг сонгоод устга.

Mac OS X

Хэвлэх харилцах цонхонд ханд. Өөрийн урьдчилсан тохируулгыг нэмэхийн тулд **Цаасны Хэмжээ** болон **Media Type** зэргийг тохируулаад одоогийн тохиргоог **Presets** тохиргоонд хадгал.

Тэмдэглэл:

Нэмсэн урьдчилсан тохируулгыг устгахын тулд **Presets > Show Presets**-ыг дарж, устгах тохируулгын нэрийг сонгоод устга.

Жижигрүүлсэн эсвэл томруулсан баримт бичгийг хэвлэх

Та тодорхой хувиар баримт бичгийн хэмжээг жижигрүүлж, эсвэл томруулж болно.

Windows

Баримтын Хэмжээ-г **Илүү Сонголтууд** таб дээр тохируулна. **Баримтыг Багасгах/Томсгох, Хүртэл томсго**-г сонгож дараа нь дүрслэлийн хувиа оруулна.

Mac OS X

Тэмдэглэл:

Програмаас шалтгаалж үйлдлүүд нь ялгаатай байна. Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.

Цаасны Тохируулга (эсвэл **Хэвлэх**)-ийг **Файл** цэснээс сонго. **Зориулсан Формат** хэсэгт принтерийг сонгож, цаасны хэмжээ сонгоод, **Хуваарь** хэсэгт хувийг оруулна. Цонхыг хаагаад, хэвлэх үндсэн зааврын дагуу хэвлэнэ.

Принтерийн өнгийг тохируулах

Та хэвлэх ажилд хэрэглэж буй өнгийг тохируулах боломжтой.

ФотоСайжрилт нь үндсэн зургийн мэдээллийн тодрол, хурц, цайвар байдлыг автоматаар тохируулснаар тод зургийг хэвлэж, илүү тод өнгийг гаргадаг.

Тэмдэглэл:

- ☐ Эдгээр тохируулгыг үндсэн мэдээлэл дээр хийдэггүй.
- ☐ **ФотоСайжрилт** нь дүрсний байрлалд шинжилгээ хийснээр өнгийг тохируулдаг. Тиймээс, та зургийг жижигрүүлж, томруулж, тайрч, эргүүлэн дүрсний байрлалыг өөрчилсөн бол, зурагны өнгө гэнэт өөрчлөгдөх магадлалтай. Хэрэв зураг фокусгүй болсон байвал, өнгө зохицол нь хэвийн бус болсон байх ёстой. Өнгө өөрчлөгдөж хэвийн бус болсон байвал **ФотоСайжрилт**-с өөр горимоор хэвлэнэ үү.

Windows

Өнгө Засалт-с **Илүү Сонголтууд** табан дээрээс өнгө засах аргыг сонгоно уу.

Хэвлэх

Хэрэв та **Автоматыг** сонговол, өнгө нь цаасны төрөл, хэвлэлийн чанарын тохиргоотой нийцэж автоматаар тохируулагдана. Хэрэв та **Өөрчлөх** цэсийг сонгож **Нэмэлт** хэсэг дээр дарвал, та өөрийн тохиргоогоо хийх боломжтой болно.

Mac OS X

Принтерийн харилцах цонхонд хандана. Дэлгэгддэг цэснээс **Color Matching**-г сонгож, дараа нь **EPSON Color Controls**-г сонгоно. Дэлгэгддэг цэснээс **Color Options**-г сонгож, дараа нь бэлэн байгаа сонголтуудын нэгийг сонгоно. **Мэргэшсэн Тохиргоо**-н хажууд байгаа сумыг дарж, зохих тохиргоог хийнэ.

Хуулбарлалтын эсрэг хээг хэвлэх (зөвхөн Windows)

Та баримтыг "Хуулбар" зэрэг үл харагдах бичвэртэй хэвлэх боломжтой. Эдгээр бичвэр нь фото хуулбар хийх үед баримтан дээр гарч ирэх учраас хуулбарыг эх хувиас ялгах боломжтой болно. Та мөн өөрийн хуулбарлалтын эсрэг хээг нэмэх боломжтой.

Тэмдэглэл:

Энэхүү үзүүлэлтийг зөвхөн дараах тохиргоо сонгогдсон үед л ашиглах боломжтой.

- ☐ Цаасны Төрөл: Цулгүй цаас
- ☐ Чанар: Стандарт
- ☐ Автомат 2-талт хэвлэлт: Идэвхижээгүй
- ☐ Өнгө Засалт: Автомат

Усан тэмдгийн Үзүүлэлтүүд-г Илүү Сонголтууд таб дээрээс дарж, хуулбарлалтын эсрэг хээг сонгоно. Хэмжээ, нягтшил зэрэг дэлгэрэнгүй тохиргоог өөрчлөхийн тулд **Тохиргоо**-г дарна.

Усан тэмдгийг Хэвлэх (зөвхөн Windows)

Та хэвлэлтэн дээрээ "Нууц" гэх мэт усан тэмдгийг хэвлэх боломжтой. Та мөн өөрийн усан тэмдгээ нэмэх боломжтой.

Усан тэмдгийн Үзүүлэлтүүд-ийг Илүү Сонголтууд таб дээрээс дараад усан тэмдгийг сонго. **Тохиргоо**-г дарж усан тэмдгийн нягтрал, байрлал зэрэг нарийн тохиргоог өөрчилнө.

Хуудасны толгой, доод хэсгийг хэвлэх (Windows-т зөвхөн)

Та хэрэглэгчийн нэр, хэвлэсэн огноо зэрэг мэдээллийг толгой, доод хэсэгт хэвлэж болно.

Усан тэмдгийн Үзүүлэлтүүд-г Илүү Сонголтууд таб дээрээс дарж, дараа нь **Дээд хэсэг/Доод хэсэг**-г сонгоно. **Тохиргоо** дээр дарж, дэлгэгддэг жагсаалтаас шаардлагатай зүйлсийг сонгоно.

Epson Easy Photo Print ашиглаж фото зураг хэвлэх

Epson Easy Photo Print нь төрөл бүрийн цаасан дээр фото зургийг хялбархан бүдүүвчилж хэвлэх боломжтой. Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.

Тэмдэглэл:

Epson-н жинхэнэ фото цаасан дээр хэвлэснээр бэхний чанар дээд зэргээр гарч, хэвлэмэл материал тод, гоё өнгөтэй байна.

Холбогдох мэдээлэл

- ➔ 29 хуудас дээрх "Бэлэн байгаа цаас ба багтаамж"
- ➔ 31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"
- ➔ 107 хуудас дээрх "Epson Easy Photo Print"

Ухаалаг төхөөрөмжөөс хэвлэх

Epson iPrint ашиглах

Epson iPrint нь ухаалаг утас эсвэл таблет зэрэг ухаалаг төхөөрөмжөөс фото зураг, баримт, вэб хуудсыг хэвлэх боломжтой програм юм. Принтертэй ижил утасгүй сүлжээнд холбогдсон ухаалаг төхөөрөмжөөс хэвлэх дотоод хэвлэлт, эсвэл, интернэтээр дамжуулан алсын байрлалаас хэвлэх алсын хэвлэлтийн аль нэгийг сонгох боломжтой. Алсын хэвлэлтийг ашиглахын тулд принтерээ Epson Connect үйлчилгээнд бүртгүүлнэ.



Холбогдох мэдээлэл

- ➔ 100 хуудас дээрх "Epson Connect үйлчилгээ"

Epson iPrint Суулгах

Та дараах URL эсвэл QR кодоос ухаалаг төхөөрөмж дээрээ Epson iPrint суулгаж болно.

<http://ipr.to/c>




Epson iPrint ашиглан хэвлэх

Ухаалаг төхөөрөмжөөсөө Epson iPrint-г эхлүүлж, нүүр дэлгэцээс ашиглахыг хүссэн зүйлээ сонгоно.

Хэвлэх

Дараах дэлгэцний байдал нь урьдчилж мэдэгдэлгүйгээр өөрчлөгдөх боломжтой.



①	Аппликейшн эхлэхэд нүүр дэлгэц нь гарч ирнэ.
②	Принтерийг хэрхэн тохируулах болон Түгээмэл Асуулт Хариултуудыг харуулна.
③	Принтерийг сонгож, принтерийн тохиргоог хийх дэлгэцийг харуулна. Принтерийг нэг сонгосон бол дараагийн удаа дахин сонгох шаардлагагүй болно.
④	Фото зураг, баримт бичиг, вэб хуудас зэрэг хэвлэхийг хүссэн зүйлээ сонгоно.
⑤	Цаасны хэмжээ, цаасны төрөл зэрэг хэвлэх тохиргоог хийх дэлгэцийг харуулна.
⑥	Таны сонгосон фото зураг, баримт бичгийг харуулна.
⑦	Хэвлэж эхэлнэ.

Тэмдэглэл:

iPhone, iPad, iPod touch зэрэг iOS дээр ажилладаг төхөөрөмжөөс хэвлэхийн тулд Epson iPrint-г iTunes дээрх файл хуваалцах функцыг ашиглан хэвлэхийг хүссэн баримтаа шилжүүлсний дараа ажиллуулна.

AirPrint ашиглах

AirPrint нь өөрийн AirPrint-г идэвхжүүлсэн принтер рүү iOS төхөөрөмжөөс iOS-н хамгийн сүүлийн хувилбар ашиглан өөрийн Mac OS X v10.7.х эсвэл түүнээс хойш гарсан хувилбараас утасгүй сүлжээ ашиглан хэвлэх боломж олгоно.



Тэмдэглэл:

Дэлгэрэнгүй мэдээллийг AirPrint хуудаснаас Apple вэбсайтаас үз.

1. Принтер дээр цаас ачаалах.
2. Принтерийн ашиглаж байгаатай адил утасгүй сүлжээнд төхөөрөмжөө холбоно.
3. Өөрийн төхөөрөмжөөс принтер рүү хэвлэх.

Холбогдох мэдээлэл

➔ [31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"](#)

Хэвлэхийг цуцлах

Тэмдэглэл:

- ❑ Windows дээр хэвлэх ажил принтер рүү бүрэн илгээгдсэний дараа компьютероос хэвлэх ажлыг цуцлах боломжгүй. Энэхүү тохиолдолд, принтерийн хяналтын самбарыг ашиглан хэвлэх ажлыг цуцална.
- ❑ Mac OS X-с хэд хэдэн хуудсыг хэвлэх үед, та хяналтын самбарыг ашиглан бүх ажлыг цуцлах боломжгүй. Энэ тохиолдолд, компьютероос хэвлэх ажлыг цуцална.
- ❑ Та хэвлэх ажлыг Mac OS X v10.6.8-с сүлжээгээр дамжуулж илгээсэн бол та компьютероос хэвлэх ажлыг цуцлах боломжгүй болох юм. Энэхүү тохиолдолд, принтерийн хяналтын самбарыг ашиглан хэвлэх ажлыг цуцална. Та компьютероос хэвлэхийг цуцлахын тулд Web Config дээрх тохиргоог өөрчлөх шаардлагатай. Дэлгэрэнгүй мэдээллийг Сүлжээний Заавар-с үзнэ үү.

Хэвлэхийг цуцлах — Принтерийн товч

Явагдаж буй хэвлэх ажлыг цуцлахын тулд  дээр дарна.

Хэвлэхийг цуцлах — Windows

1. Принтерийн драйверийн цонхонд хандана.
2. **Арчилгаа** табыг сонгоно.
3. **Хэвлэх Дараалал** дээр дарна.
4. Цуцлахыг хүсэж буй ажил дээр хулганы баруун товчийг дарж дараа нь **Цуцлах**-г сонгоно.

Холбогдох мэдээлэл

➔ [102 хуудас дээрх "Windows принтерийн драйвер"](#)

Хэвлэхийг цуцлах — Mac OS X

1. **Тавцан** дээрх принтерийн тэмдэг дээр дарна.
2. Цуцлахыг хүсэж буй ажлаа сонгоно.
3. Ажлыг цуцална.
 - ☐ Mac OS X v10.8.x буюу түүнээс хойших
Үйл явц хэмжигчийн хажуугийн  дээр дарна.
 - ☐ Mac OS X v10.6.8-с v10.7.x
Устгах дээр дарна.

Хуулбарлах

1. Принтер дээр цаас ачаалах.
2. Эх хувийг байрлуулна.
3. Үндсэн дэлгэцнээс **Хувилах**-г оруулна уу.
4. ▲, ▼ товчуудыг дарж хуулбарын тоог оруулна.
5. ОК товчийг дарна.
6. **Бүдүүвч**-г сонгоод дараа нь зохих загварыг сонгоно.
7. ▼ товч дээр дарж, дараа нь шаардлагатай бол бусад тохиргоог хийнэ.
8. ⬅ товчийг дарна.

Холбогдох мэдээлэл

- ➔ 31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"
- ➔ 34 хуудас дээрх "Эх хувийг байрлуулах"
- ➔ 18 хуудас дээрх "**Хувилах** Горим"

Скандах

Хяналтын самбар ашиглаж скандах

Үүлэн үйлчилгээ рүү скандах

Та скандсан зургийгEpson Connect-г ашиглан үүлэн үйлчилгээ рүү илгээж болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг Epson Connect портал вэбсайтаас үз.

<https://www.epsonconnect.com/>

<http://www.epsonconnect.eu> (Зөвхөн Европт)

Холбогдох мэдээлэл

➔ 19 хуудас дээрх "Сканнердах горим"

Компьютер руу скандах



Чухал:

Та энэхүү тохиргоог ашиглахын тулд компьютер дээрээ EPSON Scan ба Epson Event Manager суулгасан байх ёстой.

1. Эх хувийг байрлуулна.
2. Үндсэн дэлгэцнээс **Сканнердах**-г оруулна уу.
3. **Компьютер** сонгоно.
4. Скандсан зургийг хадгалах компьютероо сонгоно.

Тэмдэглэл:

- ☐ Баримт бичгийн төрөл, хадгалах хавтас, хадгалах формат зэрэг байнга ашигладаг сканы тохиргоог Epson Event Manager ашиглан өөрчилж болно.
- ☐ Принтерийг сүлжээнд холбох үед, принтерийн хяналтын самбар дээр 20 хүртэлх компьютер харагдаж болно.
- ☐ Скандсан зургийг хадгалахыг хүсэж буй компьютерыг сүлжээн дээр илрүүлбэл, компьютерын нэрний эхний 15 тэмдэгтийг хяналтын самбар дээр гаргана. Epson Event Manager дээр та сүлжээний сканы нэрийг тохируулсан бол, энэ нь хяналтын самбар дээр харагдана.

5. ОК товчийг дараад дараа нь файлын форматыг сонгоно.
6. товчийг дарна.

Холбогдох мэдээлэл

➔ 34 хуудас дээрх "Эх хувийг байрлуулах"

Скандах

- ➔ 105 хуудас дээрх "Epson Event Manager"
- ➔ 19 хуудас дээрх "Сканнердах горим"

Компьютер руу скандах (WSD)

Тэмдэглэл:

- ❑ Энэхүү үзүүлэлтийг зөвхөн Windows 8.1/Windows 8/Windows 7/Windows Vista ажиллаж байгаа компьютер дээр л ашиглах боломжтой.
- ❑ Хэрэв Windows 7/Windows Vista ашиглаж байгаа бол, энэхүү үзүүлэлтийг хэрэглэхээсээ өмнө компьютертоо тохируулга хийх шаардлагатай. Дэлгэрэнгүй мэдээллийг Сүлжээний Заавар-с үзнэ үү.

1. Эх хувийг байрлуулна.
2. Үндсэн дэлгэцнээс **Сканнердах**-г оруулна уу.
3. **Компьютер (WSD)** сонгоно.
4. Компьютерийг сонгоно.
5.  товчийг дарна.

Холбогдох мэдээлэл

- ➔ 34 хуудас дээрх "Эх хувийг байрлуулах"
- ➔ 19 хуудас дээрх "Сканнердах горим"

Компьютероос скандах

"EPSON Scan"-н сканнерийн драйверийг ашиглан скандана. Тохиргоо бүрийн тайлбарыг EPSON Scan-н тусламж хэсгээс үзнэ.

Скандах үндсэн мэдээлэл

Энэхүү хэсэгт скандах үндсэн мэдээллийг тайлбарлахын тулд EPSON Сканы **Home Mode**-г ашиглана. Үйл ажиллагааны ажлын дараалал нь бусад скандах горимтой адил байна.


Тэмдэглэл:

ADF-аас сканнердах тохиолдолд **Home Mode**-г ашиглах боломжгүй. сканнерын шил-нээс сканнердах буюу **Office Mode** эсвэл **Professional Mode**-ыг ашигла.

1. Эх хувийг байрлуулна.
2. EPSON Scan-г эхлүүлнэ.

Скандах

3. **Home Mode**-г **Mode** жагсаалтаас сонгоно.



4. Дараах тохиргоог хийнэ үү.

- ☐ **Document Type:** Скандахыг хүссэн эхийнхээ төрлийг сонгоно.
- ☐ **Image Type:** Скандахыг хүссэн зургийнхаа өнгөний төрлийг сонгоно.
Хэдийгээр үүнийг **Document Type** тохиргоогоор автоматаар сонгодог боловч, та уг тохиргоог өөрчилж болно.
- ☐ **Destination:** Скандахыг хүссэн зургийнхаа нарийвчлалыг сонгоно.
Хэрэв та **Other**-г сонговол, **Resolution**-г сонгох боломжтой болно.
- ☐ **Thumbnail:** Зөвхөн **Photograph**-г Document Type тохиргоонд сонгосон тохиолдолд ашиглах боломжтой.
Та энэхүү төрлийг сонгож, **Preview** дээр дарвал, баримт бичгийн сканы талбай, чиглэл, налууг автоматаар илрүүлж скандах боломжтой бөгөөд сканнерын шил дээр олон тооны зураг тавьж скандаж болно.

Скандах

5. **Preview** дээр дарна.

Тэмдэглэл:

- ❑ Фото зураг болон скандах нөхцөл байдлаас хамаарч скандан гарах үр дүн хүссэний дагуу биш байж болно. **Thumbnail**-г арилгаж, нэг зургийг тавина.
- ❑ Олон тооны зураг тавих үед тэдгээрийг 20 мм (0.8 инч)-с доошгүй зайтай тавина. Түүнчлэн, сканнерын шил-н захыг талбайг скандахгүй.

6. Шаардлагатай бол зургийн чанар, цайвар байдлыг тохируулна.

Тэмдэглэл:

Эх хувиас шалтгаалан сканы үр дүн хүссэний дагуу биш байж болно.

7. **Scan** дээр дарна.

8. **File Save Settings** дэлгэц дээр, зохих файлын нэр, байрлал, зургийн форматын төрөл зэрэг тохиргоог хийсний дараа **OK**-г дар.

Тэмдэглэл:

Show this dialog box before next scan-г арилгасан үед, **File Save Settings** дэлгэц гарч ирэлгүй шууд сканнердаж эхэлнэ. **File Save Settings** дэлгэцийг гаргахын тулд, сканнердаж эхлэхээс өмнө **Scan**-ий баруун тал дахь  (**File Save Settings**) таних тэмдгийг дараарай.

Холбогдох мэдээлэл

- ➔ [34 хуудас дээрх "Эх хувийг байрлуулах"](#)
- ➔ [105 хуудас дээрх "EPSON Scan \(Сканнерийн драйвер\)"](#)

Дээд зэргийн тохиргоо ашиглан скандах


Заасан хэмжээгээр скандах (Office Mode)

Зургийг урьдчилан харахгүйгээр, эхийг тодорхой заасан хэмжээгээр сканнердах боломжтой. ADF ашигласнаар олон баримт бичгийг хурдан сканнердах боломжтой. EPSON Scan дахь **Mode** жагсаалтаас **Office Mode**-ыг сонго.

Скандах

Тэмдэглэл:

- ❑ Та нэг файлд олон баримт бичгийг скандахыг хүсэж байвал, PDF форматаар хадгална.
- ❑ Та ADF-г ашиглаж байгаа ба **Preview** дээр дарахыг хүсэж байвал, урьдчилан харахыг хүссэн эх хувийнхаа эхний хуудсыг зөвхөн дуудна уу. Урьдчилж харсныхаа дараа, урьдчилж харсан эх хувийнхаа эхний хуудсыг оруулаад эх хувийг бүхэлд нь ачаалаад дараа нь **Scan**-г товш.




Зургийн чанарыг тохируулж скандах (Professional Mode)

Та чанар, өнгийг тохируулж зургийн скандах боломжтой. Энэхүү горимыг дээд түвшний хэрэглэгчдэд санал болгож байна. **Professional Mode**-г **Mode** жагсаалтаас EPSON Scan дээрээс сонгоно.

Скандах

Тэмдэглэл:

- ❑ ADF-г ашиглаж скандахыг хүсэж байвал, **ADF-г Document Source** болгож сонгоно.
- ❑ Та ADF-г ашиглаж байгаа ба **Preview** дээр дарахыг хүсэж байвал, урьдчилан харахыг хүссэн эх хувийнхаа эхний хуудсыг зөвхөн дуудна уу. Урьдчилж харсныхаа дараа, урьдчилж харсан эх хувийнхаа эхний хуудсыг оруулаад эх хувийг бүхэлд нь ачаалаад дараа нь **Scan**-г товш.



Ухаалаг төхөөрөмжөөс скандах

Epson iPrint нь таны принтертэй адил утасгүй сүлжээнд холбогдсон ухаалаг утас эсвэл таблет зэрэг ухаалаг төхөөрөмжөөс зураг, баримт бичгийг скандах боломжийг танд олгодог программ хангамж юм. Та скандсан мэдээллээ ухаалаг төхөөрөмж, эсвэл Үүлэн үйлчилгээнд хадгалж, үүнийг и-мэйлээр илгээж, эсвэл хэвлэж болно.

Та дараах URL эсвэл QR кодоос ухаалаг төхөөрөмж дээрээ Epson iPrint суулгаж болно.


<http://ipr.to/c>



Epson iPrint ашиглах

Та ухаалаг төхөөрөмжөөсөө Epson iPrint-г асааж үндсэн дэлгэцээс ашиглахыг хүсэж буй зүйлээс сонгож болно.

Дараах дэлгэц нь урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчлөгдөж болно.



1	Программ хангамжийг эхлүүлэхэд үндсэн дэлгэц гарч ирнэ.
2	Принтерийг хэрхэн тохируулах, тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг харуулна.
3	Принтерийг сонгож, принтерийн тохиргоог хийх дэлгэцийг харуулна. Та принтерийг сонгосноор дараагийн удаа дахин сонгох шаардлагагүй болно.
4	Скандах дэлгэцийг харуулна.

Скандах

5	Нягтрал зэрэг сканы тохиргоог хийж болох дэлгэцийг харуулна.
6	Скандсан зургийг харуулна.
7	Скандаж эхэлнэ.
8	Скандсан мэдээллээ ухаалаг төхөөрөмж, Үүлэн үйлчилгээнд хадгалж болох дэлгэцийг харуулна.
9	Скандсан мэдээллээ и-мэйлээр илгээж болох дэлгэцийг харуулна.
10	Скандсан мэдээллээ хэвлэж болох дэлгэцийг харуулна.

Факсдах

Факс тохируулах

Утасны шугамтай холбох

Телефон утасны тохирох шугам

Та стандарт аналог телефон утасны шугам (PSTN = Олон нийтийн сольдог телефон утасны сүлжээ) болон PBX (Хувийн салбарын солилцоо) телефоны системийг ашиглах боломжтой.

Та дараах утасны сүлжээ, эсвэл систем дээр принтерийг ашиглах боломжгүй.

- ☐ DSL болон шилэн кабелийн дижитал үйлчилгээ зэрэг VoIP утасны шугам
- ☐ Дижитал утасны шугам (ISDN)
- ☐ Зарим PBX телефоны системүүд
- ☐ Терминалийн адаптор, VoIP адаптор, салаалагч, болон DSL рүтер зэрэг адапторууд телефон утасны ханын үүр болон принтерийн хооронд холбосон байхад

Принтерийг утасны шугамтай холбох

Принтерийг ханан дахь телефон шугамын залгуурт RJ-11 (6P2C) утасны кабелийг ашиглан холбо. Телефон утсыг принтерт холбохдоо, хоёр дахь RJ-11 (6P2C) утасны кабелийг ашигла.

Ашиглаж буй бүс нутгаас хамаарч, утасны кабель утсыг принтертэй хамт ирүүлж болно. Кабель утас цуг ирвэл, түүнийг ашиглана.

Танай улс эсвэл бүс нутагт зориулан ирүүлсэн адаптортой утасны кабелийг холбох шаардлагатай болно.



Чухал:


Зөвхөн телефоныг принтерт холбохдоо принтерийн EXT. портоос тагийг салгана. Телефоныг холбохгүй бол, тагийг бүү салга.

Аянга цахилгааны аюул тогтмол тохиолддог газарт бид таныг хүчдэлийн өсөлтөөс хамгаалагчийг ашиглахыг зөвлөж байна.

Факсдах

Утасны стандарт шугам (PSTN) эсвэл PBX-тай холбох

Телефон утасны ханын үүр эсвэл PBX портоос гарсан утасны кабель шугамыг принтерийн ар талын LINE порттой холбоно.

**Холбогдох мэдээлэл**


➔ [74 хуудас дээрх "PBX утасны системийн тохиргоог хийх"](#)

DSL эсвэл ISDN рүү холбох

DSL модем эсвэл ISDN терминалийн адаптороос гарсан утасны кабель шугамыг принтерийн ар талын LINE порттой холбоно. Дэлгэрэнгүй мэдээллийг модем эсвэл адаптортой хамт ирсэн баримт бичгээс үзнэ үү.

Тэмдэглэл:

Таны модем дотор нь суурилуулсан DSL фильтрээр тоноглогдоогүй бол, тусдаа DSL фильтр холбоно.




Утасны төхөөрөмжийг принтертэй холбох

Нэг утасны шугам дээр принтер, телефон ашиглахдаа телефоныг принтертэй холбоно.

Тэмдэглэл:


- ❑ Таны утсанд факсын ажиллагаа байдаг бол, холбохоос өмнө факсын ажиллагааг идэвхгүй болгоно. Дэлгэрэнгүй мэдээллийг утасны төхөөрөмжтэй хамт ирсэн баримт бичгээс үзнэ үү.
- ❑ Хариулагч машины дуудлагын тооноос их тоогоор хүлээж авахаасаа өмнө **Хариулах Дохио өгөх**-н тоог тохируулна.

1. Принтерийн ар талын EXT. портоос тагийг салгана.



Факсдах

2. Утасны төхөөрөмж, EXT. портыг утасны кабельтай холбоно.



Чухал:

Утасны дан шугамыг хуваалцан хэрэглэх үед, утасны төхөөрөмжийг принтерийн EXT. порттой холбохоо мартуузай. Та утасны төхөөрөмж, принтерийн тусад нь холбохоор, шугамыг салаалсан бол, утас, принтер зохих ёсоор ажиллахгүй.

3. Холбосон утасны төхөөрөмжийн харилцуурыг авч мэдээлэл нь LCD дэлгэц дээр гарч буй факс илгээх, хүлээн авахын аль нэгийг сонгохыг асууж байгаа эсэхийг баталгаажуулна.

Уг мэдээлэл гарахгүй байвал, утасны кабель EXT. порттой аюулгүй холбогдсон эсэхийг шалгана.

Холбогдох мэдээлэл

➔ [80 хуудас дээрх "Хариулагч машины тохиргоо"](#)

Факсын үндсэн тохиргоог хийх

Эхлээд факсын үнсэн тохиргоог хийх ба үүнд **Хүлээн авах Горим** орох бөгөөд **Факсын Тохиргооны Визард**-г ашиглана, дараа нь шаардлагатай бол бусад тохиргоог хийнэ.

Принтер анх удаа ассан үед **Факсын Тохиргооны Визард**-г автоматаар харуулна. Та тохиргоогоо хийж дууссаны дараа, холболтын орчин өөрчлөгдөөгүй бол түүнийг дахин хийх шаардлагагүй.

Факсын Тохиргооны Визард ашиглаж факсын үндсэн тохиргоог хийх

Дэлгэц дээрх зааврыг дагаснаар тохиргоог хийнэ.

1. Принтерийг утасны шугамд холбох.



Чухал:

Дарааллын төгсгөлд факсын холболтын автомат шалгалт хийгддэг тул, дарааллыг эхлэхээс өмнө принтерийг утасны шугамтай холбохоо мартуузай.

2. Үндсэн дэлгэцнээс **Тохируулга**-г оруулна уу.

3. **Факсын Тохиргоо** > **Факсын Тохиргооны Визард**-г сонгож, дараа нь ▲ товчийг дарна. Тохиргоо эхэлнэ.

4. Факсын толгой оруулах дэлгэц дээр танай компанийн нэр зэрэг илгээгчийн нэрийг оруулна.

Тэмдэглэл:

Таны илгээгчийн нэр болон факсын дугаар гадагш илгээх факс дээр толгой хэлбэрээр харагдана.

5. Утасны дугаар оруулах дэлгэцэн дээр факсынхаа дугаарыг оруулна.

6. DRD тохиргоо ашиглаж буй эсэхээ сонгоно.

- ☐ Хэрэв та телефон утасны компани дээрээ тусгай дуудлагын аяны үйлчилгээнд бүртгүүлсэн бол: ▲ товчийг дарж, ирж буй факс дээр дуугарах аяны төрлийг сонгож, дараа нь алхам 9 рүү шилжинэ үү. **Хүлээн авах Горим** нь автоматаар **Автомат**-д тохируулагдсан.

- ☐ Та энэхүү сонголтыг тохируулах шаардлагагүй: ▼ товчийг дараад дараагийн алхам руу шилжинэ үү.

Тэмдэглэл:

- ☐ Телефон утасны олон компанийн санал болгодог утасны аяны онцгой үйлчилгээ (компани бүрт үйлчилгээний нэр өөр байдаг), нэг утасны шугам дээр хэд хэдэн утасны дугаартай байх боломжийг олгоно. Дугаар бүрт хэд хэдэн аяны төрлийг оноодог. Та дуут дуудлагад нэг дугаар, факсын дуудлагад өөр дугаарыг ашиглах боломжтой. **DRD** дээр факсанд оноосон аяны төрлийг сонгоно.

- ☐ Бүс нутгаас хамаарч, **Асаах** ба **Унтраах** нь **DRD**-н сонголт хэлбэрээр харагдана. Тусгай дуудлагын тохиргоог ашиглахын тулд, **Асаах**-г сонгоно.

7. Принтерт холбосон утасны төхөөрөмж ашиглаж буй эсэхээ сонгоно.

- ☐ Холбогдсон үед: ▲ товчийг дараад дараагийн алхам руу шилжинэ үү.

- ☐ Холбогдоогүй үед: ▼ товчийг дараад 9-р алхам руу шилжинэ үү. **Хүлээн авах Горим** нь **Автомат**-д тохируулагдсан.

8. Автоматаар факс хүлээн авахыг хүсч буй эсэхээ сонгоно уу.

- ☐ Автоматаар хүлээн авахад: ▲ товчийг дарна. **Хүлээн авах Горим** нь **Автомат**-д тохируулагдсан.

- ☐ Гар аргаар хүлээн авахад: ▼ товчийг дарна. **Хүлээн авах Горим** нь **гар аргаар**-д тохируулагдсан.

Факсдах

9. **Тохиргоог Бататгах** дэлгэц дээрээс ОК товчийг дарна. Өөрийн хийсэн тохиргоогоо шалгахын тулд ▲ ба ▼ товчийг дарж, дараа нь ОК товч дээр дарна.

Тохиргоог засах өөрчлөхийн тулд ⏮ товч дээр дарна.

10. **Эхлэх**-г сонгож, шалгалтын үр дүнг хэвлэх заавар авсан байхад, ⏏ товчийг дарна.

Холболтын төлөвийг шалгасан шалгалтын үр дүнгийн тайланг хэвлэнэ.

Тэмдэглэл:

- ❑ *Мэдээлсэн асуудал байвал, тэдгээрийг шийдвэрлэхийн тулд тайлан дээрх зааврыг дагана.*
- ❑ *Шугамын төрлийг сонгохыг сануулвал, шугамын төрлийг сонгоно. Та принтерээ PBX утасны систем, терминалийн адапторт холбож байхдаа, **PBX**-г сонгоно уу.*
- ❑ *Залгах ая илрээгүй гэж дэлгэц дээр гарч байвал, залгах ая илрүүлэх тохиргоог идэвхгүй болгохын тулд ▲ товч дээр дарна.*
Гэвч, залгах ая илрүүлэх тохиргоог идэвхгүй болгосноор залгах үед принтерийг факсын дугаарын эхний орныг алгасч, факсын машинд буруу дугаар явуулахад хүргэх магадлалтай.

11. **Эхлэх** дахин гарч ирэхэд, ▼ товчийг дарна. Визардаас гарахын тулд **Боллоо**-г сонгоно.

Холбогдох мэдээлэл

- ➔ 69 хуудас дээрх "Принтерийг утасны шугамтай холбох"
- ➔ 79 хуудас дээрх "Хүлээн авах горимыг тохируулах"
- ➔ 74 хуудас дээрх "PBX утасны системийн тохиргоог хийх"
- ➔ 25 хуудас дээрх "**Факсын Тохиргоо**"

Хувийн факсын үндсэн тохиргоог хийх

Та тохиргооны цэс бүрийг өөрөө сонгох замаар факсын тохиргооны дарааллыг ашиглахгүйгээр факсын тохиргоог хийх боломжтой. Энэхүү дарааллыг ашиглан хийсэн тохиргоог мөн өөрчлөх боломжтой. Дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд факсын тохиргооны цэсний жагсаалтыг үзнэ үү.

Холбогдох мэдээлэл

- ➔ 25 хуудас дээрх "**Факсын Тохиргоо**"

PBX утасны системийн тохиргоог хийх

Дотуур утас ашигладаг, 0, 9 зэрэг гадаад шугам руу гадагшаа нэвтрэх код ашигладаг оффист принтерийг ашиглах үед, дараах тохиргоог хийнэ.

1. Үндсэн дэлгэцнээс **Тохируулга**-г оруулна уу.
2. **Факсын Тохиргоо** > **Үндсэн Тохиргоо** > **Шугамын Төрөл** сонгоно.
3. **PBX** сонгоно.
4. **Ашиглах**-г нэвтрэх код хэлбэрээр сонгоно.

Факсдах

5. **Хандалтын Код** дэлгэц дээр утасныхаа системд ашигласан гадаад нэвтрэх кодыг оруулаад дараа нь ОК товчийг дарна.

Нэвтрэх код принтерт хадгалагдана. Гадаад факсын дугаар луу факс илгээхдээ бодит нэвтрэх кодын оронд # (чагт) оруулна.

Тэмдэглэл:

Факсын дугаарын өмнө # (чагт) оруулсан үед, принтер дуудлага хийхдээ #-г хадгалагдсан нэвтрэх кодоор орлуулна. #-г ашиглах нь гадаад шугам руу холбогдох үед холболтын асуудлаас сэргийлэхэд тусалдаг.

Факсдах харилцах хаягийг бүртгүүлэх

Тогтмол хэрэглэгддэг факсын дугаарыг харилцах хаягийн жагсаалтад бүртгүүлсэнээр факсыг илгээхэд хялбархан болно. Оролтуудаас бүлэг үүсгэж, нэг зэрэг олон хүлээн авагчид факс илгээх боломжтой. 60 хүртэлх оролт (бүлэг оролт нь нэг оролтоор тоологдоно) бүртгэх боломжтой.

Харилцах хаяг бүртгэх

1.  товчийг **Факсдах** горимоос дарна.
2. # товч дээр дарж, дараа нь **Оролт Нэмэх**-г сонгоно.
3. Бүртгэхийг хүсэж буй бүртгэлийн дугаараа сонгоно.
4. Нэр, факсын дугаарыг оруулна.

Тэмдэглэл:

Факсын дугаар оруулахдаа, хэрэв таны утасны систем PBX бол, факсын дугаарын эхэнд байрлах гадаад нэвтрэх кодыг оруулж, гадаад шугамд холбогдохын тулд та нэвтрэх код авах шаардлагатай. Хэрэв нэвтрэх кодыг **Шугамын Төрөл** тохиргоогоор тохируулсан байвал, бодит нэвтрэх кодын оронд # (чагт) оруулна. Пауз (3 секундын пауз)-г залгах үеэр нэмж,  товч дээр дарснаар зураас оруулна.

5. Факсын хурдыг сонгоно. ► товчийг дарж өөрчлөлтийг хийнэ.

Тэмдэглэл:

Факсын хурдны өгөгдмөл утга нь **Тохируулга > Факсын Тохиргоо > Үндсэн Тохиргоо > Факсын Хурд** дахь утгаар тохируулагдана. Хэрэв хүлээн авагчид тогтмол алдаа гарах бувуу хүлээн авагч гадаадад байгаа бол, энэ утгыг **Удаан(9,600bps)** дээр тохируулахыг зөвлөж байна.

6. Харилцах хаягийг бүртгэхийн тулд ОК товчийг дарна.

Тэмдэглэл:

Оруулгыг өөрчлөх, устгахын тулд, зорилтот оруулгыг сонгож, ► товч дээр даран, дараа нь **Засварлах** эсвэл **Устгах**-г сонгоно.

Бүлэглэсэн харилцах хаяг бүртгэх

Харилцах хаягийг бүлэгт нэмснээр нэг зэрэг олон тооны хаяг руу факс илгээх боломжийг танд олгоно.

Факсдах

1.  товчийг **Факсдах** горимоос дарна.
2. # дээр дарж, дараа нь **Бүлэг Нэмэх**-г сонгоно.
3. Бүртгэхийг хүсэж буй бүртгэлийн дугаараа сонгоно.
4. Нэрээ оруулаад дараа нь ОК товчийг дарна.
5. Тухайн бүлэгт бүртгэхийг хүсэж буй харилцах хаягуудаа сонгохын тулд * товчийг дарна.

Тэмдэглэл:

- ☐ Та 30 хүртэлх харилцах хаяг бүртгэж болно.
- ☐ Сонголтыг арилгахын тулд * товчийг дахин дарна.

6. Харилцах хаягуудыг бүлэг хэлбэрээр бүртгэхийн тулд, ОК товчийг дарна.

Тэмдэглэл:

Бүлэг болгосон харилцах хаягийг өөрчлөх, устгахын тулд, зорилтот харилцах хаягийг сонгож, ► товч дээр даран, дараа нь **Засварлах** эсвэл **Устгах**-г сонгоно.

Компьютер ашиглан харилцах хаягийг бүртгэж нөөцлөн хадгалах

FAX Utility ашиглан компьютер дээрээ харилцах хаягийн жагсаалт үүсгэн, принтер рүүгээ импортлох боломжтой. Мөн принтерт хадгалагдсан харилцах хаягийн өгөгдлийн компьютертээ нөөцлөн хадгалах боломжтой. Дэлгэрэнгүйг FAX Utility-н тусламжаас лавлаарай.

Принтерийн үйл ажиллагааны доголдлоос болж харилцах хаягийн өгөгдөл арилах магадлалтай. Өгөгдлийг шинэчлэх бүртээ нөөцлөн хадгалж байхыг зөвлөж байна. Аливаа өгөгдлийн алдагдал, өгөгдөл ба/буюу тохиргооны нөөц хадгалалт, сэргээлтэд Epson нь хариуцлага хүлээхгүй ба энэ нь баталгаат хугацааны туршид ч хамааралтай.

Холбогдох мэдээлэл

➔ [106 хуудас дээрх "FAX Utility"](#)

Факс илгээх

Факс илгээх үндсэн үйл ажиллагаа

Факсыг өнгөт эсвэл монохромомор илгээх (B&W).

Тэмдэглэл:

Факсын дугаар завгүй эсвэл асуудал үүсвэл, принтер нэг минутын дараа хоёр удаа автоматаар дахин залгана.

Факсдах

Хяналтын самбар ашиглаж факс илгээх

1. Эх хувийг байрлуулна.

Тэмдэглэл:

Нэг дамжуулалтаар 100 хүртэлх хуудсыг илгээх боломжтой; гэвч үлдсэн санах ойн хэмжээнээс хамааран 100 хуудаснаас цөөн факсыг ч илгээх боломжгүй байж болно.

2. Үндсэн дэлгэцнээс **Факсдах**-г оруулна уу.

3. Хүлээн авагчийг зааж өгнө.

☐ Гар аргаар оруулахын тулд: Тоон гарыг ашиглаж тоог оруулаад, ОК товчийг дарна.

☐ Харилцах жагсаалтаас сонгох:  товчийг дараад дараа нь хүлээн авагчийг сонгоно.

☐ Сүүлд залгасан дугаарыг сонгохын тулд:  товчийг дарна.

Тэмдэглэл:

☐ Та ижил монохромт факсыг 30 хүртэлх хүлээн авагч руу илгээж болно. Өнгөт факсыг нэг удаад зөвхөн нэг хүлээн авагчид илгээж болно.

☐ Пауз (3 секундын пауз)-г залгах үеэр нэмж,  дээр дарснаар зураас оруулна.

☐ Хэрэв та **Шугамын Төрөл**-д гадаад нэвтрэх код тохируулсан бол, бодит нэвтрэх кодын оронд факсын дугаарын өмнө "#" (чагт)-г оруулна уу.

☐ Та  товчийг дарж, сүүлийн факс бүлэг рүү залгах дугаар руу илгээгдсэн бол, бүлэгт сүүлд бүртгэгдсэн дугаарыг харуулна.

☐ Сонгосон хүлээн авагчаа устгахын тулд,  товчийг дараад дараа нь **Холбоо барихийг устгах**-г сонгоно.

4. ОК товч дээр дарж, дараа нь нарийвчлал, илгээх арга зэрэг бусад тохиргоог шаардлагатай бол хийнэ.

5.  товчийг дарна.

Тэмдэглэл:

☐ Илгээхээ болихын тулд,  товчийг дарна.

☐ Принтер скандах, илгээх ажиллагааг зэрэг явуулж буй тул факсыг өнгөтөөр илгээхэд илүү их хугацаа зарцуулна. Принтер өнгөт факс илгээж байх зуур та бусад тохиргоог ашиглах боломжгүй.

☐ Эхийн агуулга болон сонгосон нарийвчлалаас хамаарч факс илгээх хурд нь ялгаатай байна.

Холбогдох мэдээлэл

➔ 34 хуудас дээрх "Эх хувийг байрлуулах"

➔ 20 хуудас дээрх "Факсдах горим"

➔ 75 хуудас дээрх "Факсдах харилцах хаягийг бүртгүүлэх"

Утасны гадаад төхөөрөмжөөс факсад дуудлага илгээх

Факс илгээхээс өмнө утсаар ярих, эсвэл хүлээн авагчийн факсын машин факс руу автоматаар шилжихгүй байхад холбогдсон утсыг ашиглан залгаж факс илгээх боломжтой.

Факсдах

1. Эх хувийг байрлуулна.

Тэмдэглэл:

Та нэг дамжуулалтаар 100 хүртэлх хуудсыг илгээх боломжтой.

2. Холбосон утасны харилцуурыг авна.
3. Принтерийн хяналтын самбар дээр **Илгээх**-г сонгож, дараа нь утас ашиглан хүлээн авагчийн факсын дугаар руу залгана.
4. ОК товч дээр дарж, дараа нь нарийвчлал, илгээх арга зэрэг бусад тохиргоог шаардлагатай бол хийнэ.
5. Та факсын дуу сонсвол,  товч дээр дарж, дараа нь харилцуураа тавина.

Тэмдэглэл:

☐ Холбогдсон утсыг ашиглан дугаар руу залгах үед, принтер скандах, илгээх ажиллагааг зэрэг явуулж буй тул факс илгээхэд хугацаа зарцуулна. Факс илгээж байх зуур та бусад тохиргоог ашиглах боломжгүй.

☐ Эхийн агуулга болон сонгосон нарийвчлалаас хамаарч факс илгээх хурд нь ялгаатай байна.

Холбогдох мэдээлэл

➔ 34 хуудас дээрх "Эх хувийг байрлуулах"

➔ 20 хуудас дээрх "Факсдах горим"

Факс илгээх төрөл бүрийн арга

Факсыг тогтоосон цагт илгээх (Факсыг Дараа Илгээх)

Та факсыг тогтоосон цагт илгээхээр тохируулж болно. Илгээх цагийг тодорхойлсон үед монохромт факсыг зөвхөн илгээж болно.

1. Эх хувийг байрлуулна.
2. Үндсэн дэлгэцнээс **Факсдах**-г оруулна уу.
3. Хүлээн авагчийг зааж өгнө.
4. ОК товч дээр дарж, дараа нь **Факсыг Дараа Илгээх**-г сонгоно.
5. **Асаах**-г сонгож, дараа нь ОК товчийг дарна.
6. Факс илгээх цагаа оруулаад дараа нь ОК товчийг дарна.
7. Шаардлагатай бол нарийвчлал, нягтрал зэрэг тохиргоог хийнэ.
8.  товчийг дарна.

Тэмдэглэл:

Тогтоосон цагт факсыг илгээх хүртэл, та бусад факсыг илгээх боломжгүй. Факсыг цуцлахын тулд, факсын дээд дэлгэц дээрх  товчийг дараад дараа нь  товчийг дарна.

Факсдах

Холбогдох мэдээлэл

- ➔ 77 хуудас дээрх "Хяналтын самбар ашиглаж факс илгээх"
- ➔ 34 хуудас дээрх "Эх хувийг байрлуулах"
- ➔ 20 хуудас дээрх "Факсдах горим"

Монохромт баримт бичгийн олон хуудсыг илгээх (Шууд Илгээх)

Монохромор факс илгээх үед, скандсан баримт бичгийг принтерийн санах ойд түр хадгалдаг. Тиймээс, олон тооны хуудсыг илгээх нь принтерийн санах ойг дуусгах, факс илгээхийг зогсооход хүргэнэ. **Шууд Илгээх** тохиргоог идэвхжүүлж та үүнээс сэргийлж болох ч, принтер скандах, илгээх ажиллагааг зэрэг явуулж буй тул факс илгээхэд илүү их хугацаа зарцуулна. Зөвхөн нэг хүлээн авагч байгаа үед энэхүү тохиргоог ашиглаж болно.

Үндсэн дэлгэц дээрээс **Факсдах**-г сонгоод, дараа нь ОК товчийг дарна. **Шууд Илгээх**-г **Асаах** болгож тохируулна.

Компьютероос факс илгээх

Та FAX Utility болон PC-FAX драйвер ашиглах компьютероос факс илгээж болно. Ашиглалтын зааврыг үзэхийн тулд FAX Utility болон PC-FAX драйверийн тусламжийг үзнэ үү.

Холбогдох мэдээлэл

- ➔ 106 хуудас дээрх "PC-FAX Драйвер (Факсын драйвер)"
- ➔ 106 хуудас дээрх "FAX Utility"

Факс хүлээн авах

Хүлээн авах горимыг тохируулах

Та **Хүлээн авах Горим**-г **Факсын Тохиргооны Визард** ашиглан тохируулж болно. Та факсын тохиргоог анх хийх үедээ, **Факсын Тохиргооны Визард**-г ашиглахыг бид санал болгож байна. Та **Хүлээн авах Горим** тохиргоог өөрөө өөрчлөхийг хүсэж байвал, доорх алхмыг дагана уу.

1. Үндсэн дэлгэцнээс **Тохируулга**-г оруулна уу.
2. **Факсын Тохиргоо** > **Хүлээн авах Тохиргоо** > **Хүлээн авах Горим** сонгоно.
3. Хэрхэн хүлээн авахаа сонгоно.
 - ☐ Автомат: Ачаалал ихтэй факс хэрэглэгчдэд санал болгож байна. Таныг дуугарах дуудлагын тоог зааж өгсний дараа принтер автоматаар факс хүлээн авна.



Чухал:

Та утсаа принтерт холбоогүй үед, **Автомат** горимыг сонго.

Факсдах

- ❑ гар аргаар: Факс байнга ашигладаггүй бөгөөд холбогдсон утсаар дуудлагад хариулсны дараа факс хүлээн авахыг хүсэж буй хэрэглэгчид санал болгож байна. Факс хүлээн авахад, харилцуурыг аваад дараа нь принтерийг ажиллуулна.

Тэмдэглэл:

Та **Алсын Хүлээн авалт** тохиргоог идэвхжүүлэх үед, холбогдсон утас ашигласнаар факс хүлээн авч эхэлж болно.

Холбогдох мэдээлэл

- ➔ 73 хуудас дээрх "Факсын Тохиргооны Визард ашиглаж факсын үндсэн тохиргоог хийх"
- ➔ 80 хуудас дээрх "Гар аргаар факс хүлээн авах"
- ➔ 81 хуудас дээрх "Холбогдсон утас ашиглаж факс хүлээн авах (Алсын Хүлээн авалт)"

Хариулагч машины тохиргоо

Та хариулах машин ашиглахын тулд тохиргоо хийх шаардлагатай.

- ❑ Принтерийн **Хүлээн авах Горим-г Автомат** болгож тохируулна.
- ❑ Принтерийн **Хариулах Дохио өгөх** тохиргоог хариулагч машины дуудлагын тооноос их тоогоор тохируулна. Эс тэгвээс, хариулах машин дуут зурвасыг бичихийн тулд дуут дуудлагыг хүлээж авах боломжгүй. Хариулах машинтай цуг ирэх гарын авлагаас тохиргоог нь үзнэ үү.
Бүс нутгаас хамаарч, **Хариулах Дохио өгөх** тохиргоо гарч ирэхгүй байж болно.

Холбогдох мэдээлэл

- ➔ 25 хуудас дээрх "**Факсын Тохиргоо**"

Факс хүлээн авах төрөл бүрийн арга

Гар аргаар факс хүлээн авах

Та утас холбож, принтерийн **Хүлээн авах Горим** тохиргоог хийх үед **гар аргаар**, факс хүлээн авахын тулд дараах алхмыг дагана уу.

1. Телефон утас дуугарах үед, харилцуурыг авна.
2. Та факсын дуу сонсох үед, принтерийн хяналтын самбар дээрх **Хүлээн авах-г** сонгоно.

Тэмдэглэл:

Та **Алсын Хүлээн авалт** тохиргоог идэвхжүүлэх үед, холбогдсон утас ашигласнаар факс хүлээн авч эхэлж болно.

3. ◇ товчийг дараад харилцуурыг тавина.

Холбогдох мэдээлэл

- ➔ 81 хуудас дээрх "Холбогдсон утас ашиглаж факс хүлээн авах (Алсын Хүлээн авалт)"

Холбогдсон утас ашиглаж факс хүлээн авах (Алсын Хүлээн авалт)

Гар аргаар факс хүлээн авахын тулд, утасны харилцуурыг авсныхаа дараа та принтерийг ажиллуулах шаардлагатай. **Алсын Хүлээн авалт** тохиргоог ашигласнаар, та зүгээр л утсыг ажиллуулснаар факс хүлээн авч эхэлж болно.

Алсын Хүлээн авалт тохиргоог аяар залгах үйлдлийг дэмждэг утсанд ашиглах боломжтой.

Холбогдох мэдээлэл

➔ 80 хуудас дээрх "Гар аргаар факс хүлээн авах"

Алсын Хүлээн авалт тохируулах

1. Үндсэн дэлгэцнээс **Тохируулга**-г оруулна уу.
2. **Факсын Тохиргоо** > **Хүлээн авах Тохиргоо** > **Алсын Хүлээн авалт** сонгоно.
3. **Алсын Хүлээн авалт**-г идэвхжүүлсний дараа, хоёр оронтой код (0 – 9, *, ба #-г оруулж болно) оруулна.
4. ОК товчийг дарна.

Алсын Хүлээн авалт ашиглах

1. Телефон утас дуугарах үед, харилцуурыг авна.
2. Та факсын дуу сонсвол, телефон утас ашиглаж эхлүүлэн кодыг оруулна.
3. Принтер факс хүлээж авч эхэлснийг бататгасны дараа, харилцуурыг тавина.

Санал хураалтаар факс хүлээн авах (Бүртгэгдсэн факсыг хүлээн авах)

Факсын дугаар залгаснаар өөр факс машин дээр хадгалсан факсыг хүлээн авах боломжтой. Факсын мэдээллийн үйлчилгээнээс баримт бичиг хүлээн авахад энэхүү тохиргоог ашиглана. Гэсэн хэдий ч, баримт бичиг хүлээн авахад шаардагдах факсын мэдээллийн үйлчилгээ аудио зааврын тохиргоотой бол та энэхүү тохиргоог ашиглах боломжгүй.

Тэмдэглэл:

Факсын мэдээллийн үйлчилгээнээс аудио удирдамж ашигладаг баримтыг хүлээн авахын тулд, зүгээр л холбогдсон утсыг ашиглан факсын дугаар руу залгаж, аудио удирдамжийг дагаж утас, принтерийг ажиллуулахад болно.

1. Үндсэн дэлгэцнээс **Факсдах**-г оруулна уу.
2. ОК товч дээр дарж, дараа нь **Бүртгэгдсэн факсыг хүлээн авах**-г идэвхжүүлнэ.
3. Факсын дугаарыг оруулна.
4. ◇ товчийг дарна.

Холбогдох мэдээлэл

➔ 77 хуудас дээрх "Утасны гадаад төхөөрөмжөөс факсад дуудлага илгээх"

Хүлээн авсан факсыг компьютерт хадгалах

Хүлээн авсан баримтыг PDF формат руу хөрвүүлж, принтерт холбогдсон компьютерт хадгалахаар тохируулах боломжтой. Мөн баримтыг компьютерт хадгалахын зэрэгцээ автоматаар хэвлэхээр бас тохируулж болно.

Энэ тохиргоог хийхийн тулд FAX Utility ашиглах шаардлагатай. FAX Utility-г компьютер дээрээ суулга.

Windows FAX Utility заавар ашигласан хувилбараас хамаарч ялгаатай байна. Энэ бичиг баримтад Version 1.xx-н заавар орсон. Windows FAX Utility Version 2.xx-н хувьд, **Basic Operations** гэснийг FAX Utility онлайн тусламжаас харна уу. Аль хувилбарыг ашиглаж байгаагаа шалгахын тулд, FAX Utility нэрийн мөрөн дээр баруун товшиж, дараа нь **Хувилбарын мэдээлэл** дээр товш.

**Чухал:**

- ☐ Принтерийн хүлээн авах горимыг **Автомат** дээр тохируул.
- ☐ Хүлээн авсан баримтууд нь факсыг хадгалахаар тохируулсан компьютерт хадгалагдахын өмнө принтерийн санах ойд түр хадгалагддаг. Санах ой дүүрсэн алдаа нь факс илгээх, хүлээн авах боломжгүй болгодог учраас, факсыг хадгалахаар тохируулсан компьютерыг принтерт залгаатай байлгаарай.

1. Принтерт холбогдсон компьютер дээр FAX Utility-г эхлүүл.
2. FAX Utility-н тохиргооны дэлгэцийг нээ.
 - ☐ Windows
Fax Settings for Printer > Received Fax Output Settings-г сонгоно.
 - ☐ Mac OS X
Fax Receive Monitor-ийг дарж, принтерийг сонгоод **Received Fax Output Settings**-ийг дар.
3. **Save faxes on this computer**-г дарж, хүлээн авсан баримтыг хадгалах хавтсыг зааж өгнө.
4. Бусад шаардлагатай тохиргоог хийсний дараа тохиргоог принтер рүү илгээнэ.

Тэмдэглэл:

Тохиргооны зүйлс болон үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах бол FAX Utility-н тусламжийн тохиргооны дэлгэцийг үзнэ үү.

5. Тохиргооны мэдээллийг принтерт илгээ.

- ☐ Windows
ОК дарна.
- ☐ Mac OS X
Илгээх дарна.

Хэрэв та нэгэн зэрэг хадгалж, хэвлэхийг хүсвэл дараах алхамыг гүйцэтгэнэ үү.

6. Принтерийн хянах самбар дээрээс **Тохируулга > Факсын Тохиргоо > Гаралтын Тохиргоо** > сонго.

Факсдах

7. **Факсын Гаралт-г Хадгалаад Хэвлэх** болгож тохируулна.

Тэмдэглэл:

Хүлээн авсан баримтыг компьютерт хадгалахын болиулахын тулд **Факсын Гаралт — Хэвлэх** болгон тохируул. Энэ тохиргоог бас FAX Utility ашиглан хийх боломжтой, гэвч компьютерт хараахан хадгалж амжаагүй хүлээн авсан факс байгаа тохиолдолд FAX Utility дээрээс өөрчлөх боломжгүй.

Холбогдох мэдээлэл

- ➔ 106 хуудас дээрх "FAX Utility"
- ➔ 79 хуудас дээрх "Хүлээн авах горимыг тохируулах"

Факсын бусад тохиргоог ашиглах

Факсын тайлан, жагсаалтыг хэвлэх

Факсын тайлан гар аргаар хэвлэх

1. Үндсэн дэлгэцнээс **Факсдах**-г оруулна уу.
2. ОК товч дээр дарж, дараа нь **Факсын Тайлан**-г сонгоно.
3. Хэвлэх тайлангаа сонгоод дараа нь дэлгэц дээрх зааврыг дагана.

Тэмдэглэл:

Та тайлангийн форматыг өөрчилж болно. Үндсэн дэлгэцээс, **Тохируулга > Факсын Тохиргоо > Гаралтын Тохиргоо**-г сонгож, дараа нь **Тайланд зураг хавсаргах** эсвэл **Тайлангийн Формат** тохиргоог сонгоно.

Холбогдох мэдээлэл

- ➔ 20 хуудас дээрх "Факсдах горим"
- ➔ 25 хуудас дээрх "Факсын Тохиргоо"

Факсын тайланг автоматаар хэвлэх тохиргоог хийх

Та дараах факсын тайланг автоматаар хэвлэх тохиргоог хийж болно.

Дамжуулалтын Тайлан

Үндсэн дэлгэцээс **Тохируулга > Факсын Тохиргоо > Хэрэглэгч. Анхны Тохиргоо > Дамжуулалтын Тайлан**-г сонгож, дараа нь **Хэвлэх** эсвэл **Алдаа гарсан үед Хэвлэх**-г сонгоно.

Тэмдэглэл:

Факс илгээх үед тохиргоог өөрчлөхийн тулд, факсын дээд дэлгэц дээрх ОК товчийг дарж, дараа нь **Дамжуулалтын Тайлан**-г сонгоно.

Факсдах

Факсын Лог

Үндсэн дэлгэцээс **Тохируулга > Факсын Тохиргоо > Гаралтын Тохиргоо > Факсын Логийг Автоматаар Хэвлэх**-г сонгож, дараа нь **Асаах(30 факс тутамд)** эсвэл **Асаах(Хугацаа)**-г сонгоно.

Холбогдох мэдээлэл

- ➔ 20 хуудас дээрх "**Факсдах** горим"
- ➔ 25 хуудас дээрх "**Факсын Тохиргоо**"

Хүлээн авсан факсыг дахин хэвлэх

Та аль хэдийнэ хэвлэсэн хүлээж авч буй баримт бичгээ дахин хэвлэх боломжтой. Принтерийн санах ойд хадгалсан бүх хүлээн авсан баримт бичгийг он дарааллын урвуу дарааллаар хэвлэнэ. Гэсэн хэдий ч, принтерийн санах ой дүүрвэл, аль хэдийнэ хэвлэгдсэн баримт бичиг хамгийн эртний баримт бичгээс эхлэн автоматаар устгагдах болно.

1. Үндсэн дэлгэцнээс **Факсдах**-г оруулна уу.
2. ОК товч дээр дарж, дараа нь **Факсыг Дахин хэвлэх**-г сонгоно.
3. ⬠ товчийг дарна.

Тэмдэглэл:

Баримт бичгээ дахин хэвлэсний дараа, хэвлэхийн зогсоохын тулд ⌂ товч дээр дарна.

Бэх дүүргэх

Бэхний Түвшинг Шалгах

Бэхний бодит үлдэгдлийн шалгахын тулд принтерийн бүх саван доторх бэхний түвшинг нүдээр шалгана.

Та барагцаалсан бэхний түвшинг компьютероос шалгах боломжтой.

Бэхний түвшинг шалгах - Windows

1. Принтерийн драйверийн цонхонд хандана.
2. **Бэхний Түвшин-г Үндсэн** таб дээрээс дарна.

Тэмдэглэл:

Хэрэв **EPSON Status Monitor 3** цуцлагдсан бол, бэхний түвшин харагдахгүй. **Өргөтгөсөн Тохиргоо-г Арчилгаа** таб дээрээс дараад, **EPSON Status Monitor 3-г идэвхжүүл-г** сонгоно.

Холбогдох мэдээлэл

➔ [102 хуудас дээрх "Windows принтерийн драйвер"](#)

Бэхний түвшинг шалгах — Mac OS X

1. Системийн тохиргоо-г  цэс > **Принтер ба Сканнер** (эсвэл **Хэвлэх ба Скандах, Хэвлэх ба Факсдах**)-г сонгоод, дараа нь принтерийг сонгоно.
2. **Сонголт ба Хангамж** > **Хэрэгсэл** > **Принтерийн хэрэгслийг нээх** дээр дарна.
3. **EPSON Status Monitor** дээр дарна.

Бэхний хайрцагны код

Epson нь Epson-н жинхэнэ бэхний хайрцгийг ашиглахыг санал болгож байна. Epson баталгаа нь зориулалтын зааснаас бусад бэхнээс үүссэн эвдрэлийг хамрахгүй болно, үүнд энэхүү принтерт зориулагдаагүй Epson бэх буюу бусад гуравдагч үйлдвэрлэгчийн бэх бүгд орно.

Epson-н үйлдвэрлээгүй бусад бүтээгдэхүүн эвдрэл гэмтэл учруулж болох бөгөөд үүнийг Epson-н баталгаагаар нөхөн төлөхгүй. Зарим тохиолдолд, принтерийн ажиллагаанд хэвийн бус байдал бий болно.

Дараах нь Epson-н бэхний хайрцгийн код болно.

ВК: Black (Хар)	С: Cyan (Хөх)	М: Magenta (Ягаан)	Y: Yellow (Шар)
774	664	664	664

Бэх дүүргэх



Чухал:

Зориулалтын зааснаас бусад жинхэнэ Epson бэхийг ашиглах нь Epson-н баталгаанд хамрагдахгүй гэмтэл учруулж болзошгүй.

Тэмдэглэл:

Европын хэрэглэгчид Epson-н бэхний лонхны гарцын талаарх мэдээллийг авахын тулд дараах вэбсайтад зочлоорой.

<http://www.epson.eu/pageyield>

Бэхний лонхтой харьцах урьдчилсан санамж

Бэхийг дүүргэхээс өмнө дараах зааврыг уншина уу.

Ашиглах урьдчилсан санамж

- ☐ Энэхүү принтерийн зөв кодыг агуулсан бэхний хайрцгийг ашиглана.
- ☐ Энэхүү принтер нь бэхтэй болгоомжтой харьцахыг шаарддаг. Бэхний сав дүүрэх, эсвэл дахин дүүргэх үед бэх асгарах аюултай. Бэх таны хувцас, эд зүйлс дээр асгарвал, арилахгүй байх аюултай.
- ☐ Бэхийн хайрцгийг өрөөний ердийн температурт хадгалж, нарны шууд тусгалаас хол байлгана.
- ☐ Сав баглаанд дээр заасан огнооноос өмнө бэхний хайрцгийг ашиглахыг Epson санал болгож байна.
- ☐ Принтерийг хадгалж байгаатай адил орчинд бэхний хайрцгийг хадгална.
- ☐ Лацыг нь авсны дараа бэхний хайрцгийг хадгалах эсвэл тээвэрлэх үед, хайрцгийг хазайлгаж болохгүй ба цохиулах, эсвэл температурын өөрчлөлтөд оруулахаас сэргийлнэ. Эс тэгвээс, бэхний хайрцгийн таг бат хаагдсан байсан ч бэх асгарах аюултай. Таглааг хаах үедээ бэхний хайрцгийг босоо байрлалд байлгаж, хайрцгийг тээвэрлэх үед бэх асгарахаас сэргийлэх бүх арга хэмжээг авна.
- ☐ Бэхний хайрцгийг хүйтэн агуулахын талбайгаас өрөөн дотор оруулсны дараа, түүнийг ашиглахаас өмнө 3-с доошгүй цаг өрөөний температурт бүлээцүүлнэ.
- ☐ Бэхний савыг дүүргэхэд бэлэн болтлоо бэхний хайрцгийн сав баглаа боодлыг онгойлгохгүй байна. Найдвартай байдлыг хадгалахын тулд бэхний хайрцгийг вакумжуулж савласан байдаг. Бэхний хайрцгийг ашиглахаас өмнө удаан хугацаагаар онгорхой байлгавал, ердийн байдлаар хэвлэх боломжгүй болох аюултай.
- ☐ Бэхний түвшинг бэхний саван дээрээс бодитоор харж шалгаарай. Бэх барагдсан үед принтерийг үргэлжлүүлэн хэрэглэх нь принтерт гэмтэл учруулж болзошгүй. Принтер ажиллаагүй үед бэхний савыг дээд зураас хүртэл нь дүүргэн, бэхний түвшинг дахин тохируулахыг Epson зөвлөж байна.
- ☐ Та дээд зэргийн хэвлэлийн чанараар хэвлэж, өөрийн принтерийн толгойг хамгаалж байхын тулд, таны принтер бэх дүүргэх дохио өгөх үед бэхний саванд бэхний аюулгүй ажиллагааны янз бүрийн нөөцийг үлдээнэ. Танд харуулсан өгөөжид энэхүү нөөцийг оруулж тооцохгүй.
- ☐ Хамгийн сайн хэвлэлтийн үр дүнд хүрэхийн тулд, жилд дор хаяж нэг удаа бэхний савнуудыг дээд зураас хүртэл нь дүүргэж байгаарай.
- ☐ Бэхний хайрцагт дахин боловсруулсан материал ашиглаж болдог боловч, энэ нь принтерийн үйл ажиллагаа, гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Бэх дүүргэх


- ❑ Сайжруулсан талаар урьдчилсан мэдэгдэл өгөхгүйгээр бэхний хайрцгийн үзүүлэлт, гаднах байдлыг өөрчилж болно.
- ❑ Өгсөн гарцын хэмжээ нь таны хэвлэж байгаа зураг, хэрэглэж байгаа цаасны төрөл, хэвлэх давтамж болон температур зэрэг орчны нөхцлөөс хамаарч ялгаатай байж магадгүй.

Бэх зарцуулалт

- ❑ Принтерийн толгойн оновчтой хэрэглээг хадгалахын тулд, хэвлэлийн үед төдийгүй, принтерийн толгойг цэвэрлэх зэрэг засвар үйлчилгээний үед бүх бэхний савнаас тодорхой хэмжээний бэхийг хэрэглэж болно.
- ❑ Нэг өнгөөр эсвэл грейскейлээр хэвлэхэд, цаасны төрөл, хэвлэх чанарын тохиргооноос хамаарч хар бэхний оронд өнгөт бэх хэрэглэгдэх боломжтой. Өнгөт бэхнүүдийн хольцоор хар өнгийг үүсгэх боломжтой болохоор юм.
- ❑ Принтертэй хамт ирсэн бэхний хайрцаг дотор бэх нь анхан шатны тохиргооны үед баг зэрэг хэрэглэгддэг. Дээд чанарын хэвлэмэл материал гаргахын тулд принтер дээрх принтерийн толгойг бэхээр бүрэн дүүргэсэн байна. Энэхүү нэг удаагийн үйл явцад тодорхой хэмжээний бэх хэрэглэгддэг тул дараагийн удаад дүүргэх бэхний хайрцагтай харьцуулахад цөөн тооны цаас хэвлэж болно.

Бэхний савыг дахин дүүргэх


1. Нүүр дэлгэцнээс **Тохируулга**-д нэвтэрнэ.
2. **Арчилгаа > Бэхний Түвшинг Ресет хийх**-ийг сонгоно.
3.  товчийг дарна.
4. Бэхний савны нэгжийн тагийг нээж, бэхний савны таглааг авна. Таглааг авсны дараа доорх зурагт үзүүлсэнчлэн байрлуулна.




Бэх дүүргэх

Чухал:

- ❑ Аливаа бэх асгарахгүй байхад анхаарна.
- ❑ Бэхний савны өнгө таны дүүргэхийг хүсэж буй бэхний өнгөтэй таарч байгаа эсэхэд анхаарна.




5. Таглааны дээд хэсгийг тасдан салгаж, бэхний лонхны таглааг аван, лонхны лацыг салгасны дараа таглааг буцааж таглана.



Чухал:

Бэхний хайрцгийн тагийг чанга хаана, эс тэгвээс бэх асгарч болно.




Тэмдэглэл:

Тагны оройг салгаж болохгүй. Савыг дүүргэсний дараа бэхний хайрцганд бага хэмжээний бэх үлдвэл, бэхний хайрцгийн таглааг лацдахын тулд тагны оройг ашиглана.

Бэх дүүргэх

6. Бэхний савны дээд зураас хүртэл тохирох өнгөт бэхээр бэхний савыг дүүргэнэ.




Чухал:


Бэхний савны дотор талыг харах хэцүү байж магадгүй. Тиймээс амсараас нь бэх хальж гарахаас сэргийлж бэхийг болгоомжтой дүүргээрэй.

Тэмдэглэл:

Бэхний савыг дээд шугам хүртэл дүүргэсний дараа бэхний саванд бэх үлдвэл, тагийг чанга таглаж, дараа ашиглахаар бэхний хайрцгийг босоо байдалд хадгална.




7. Бэхний савны таглааг бат бөх таглаж хаана.



Бэх дүүргэх

8. Бэхний савны нэгжийн тагийг хаана.



9. ОК товчийг дарна.

10. LCD дэлгэц дээрх зааврыг дагаж бэхний түвшинг дахин тохируулна.

Тэмдэглэл:

Бэхийг дээд зураас хүртэл дүүргээгүй байсан ч гэсэн бэхний түвшинг дахин тохируулах боломжтой. Гэвч энэ нь ойролцоо бэхний түвшин болон бодит бэхний түвшингийн хооронд зөрүү үүсгэхийг анхаараарай. Принтерээ хамгийн сайн нөхцөлд ажиллуулахын тулд, бэхний савнуудыг дээд зураас хүртэл нь дүүргээд, бэхний түвшинг дахин тохируулаарай.

Холбогдох мэдээлэл

- ➔ 85 хуудас дээрх "Бэхний хайрцагны код"
- ➔ 86 хуудас дээрх "Бэхний лонхтой харьцах урьдчилсан санамж"

Хэвлэх, скандах чанарыг сайжруулах

Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх

Цорго бөглөрсөн бол, хэвлэмэл материал бүдэг болж, зураас харагдаж, санаандгүй өнгөнүүд гарч ирнэ. Хэвлэлийн чанар муудсан бол, цорго шалгах тохиргоог ашиглаж, цорго бөглөрсөн эсэхийг шалгана. Цорго бөглөрсөн бол, принтерийн толгойг цэвэрлэнэ.



Чухал:

Толгой цэвэрлэгээний үед сканнерын нэгжийг нээх буюу принтерийг унтрааж болохгүй. Хэрэв толгой цэвэрлэгээ бүрэн дуусаагүй бол, хэвлэх боломжгүй байж магадгүй.

Тэмдэглэл:

- ☐ Толгой цэвэрлэгээнд тодорхой хэмжээний бэх хэрэглэгдэх учраас, зөвхөн чанао муудсан үед л хэвлэх толгойг цэвэрлээрэй.
- ☐ Бэх багассан бол, та принтерийн толгойг цэвэрлэх боломжгүй байна. Шинэ бэхний хайрцаг авна уу.
- ☐ Цорго шалгах, толгой цэвэрлэхээ 3 удаа давтсаны дараа ч хэвлэлийн чанар сайжрахгүй бол, хэвлэхгүйгээр 12 цагаас доошгүй хүлээж, дараа нь цорго шалгаа давтаж, шаардлагатай толгойг давтан цэвэрлэнэ. Бид принтерээ унтраахыг зөвлөж байна. Хэвлэлийн чанар сайжрахгүй хэвээр байвал, Epson тусламж үйлчилгээний албатай холбоо барина уу.
- ☐ Принтерийн толгойг хатахаас сэргийлэхийн тулд, тэжээл залгаатай байхад принтерийг тогноос салгаж болохгүй.
- ☐ Принтерийн толгойг хамгийн сайн гүйцэтгэлээр ажиллуулахын тулд, цөөн тооны хуудсыг байнга хэвлэж байхыг санал болгож байна.

Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх — Хяналтын самбар

1. A4 хэмжээтэй ердийн цаасыг принтер дээр ачаална.
2. Үндсэн дэлгэцнээс **Тохируулга**-г оруулна уу.
3. **Арчилгаа > Хэвлэх Толгой Хошуу Шалгах** сонгоно.
4. Цорго шалгах дүрсийг хэвлэхийн тулд дэлгэц дээрх зааврыг дагана уу.


Тэмдэглэл:

Туршилтын дүрс загвар бүрээс хамаарч өөр байна.


Хэвлэх, скандах чанарыг сайжруулах

5. Хэвлэсэн шалгах дүрсийг доор харуулсан жишээтэй харьцуулж үзнэ.

- ☐ Бүх шугамыг хэвлэсэн: Принтерийн толгойн цорго бөглөрөөгүй байна. Цорго шалгах тохиргоог хаана.



- ☐ Хугарсан шугам, хоосон хэсэг байна: Принтерийн толгойн цорго бөглөрсөн байж болно. Дараагийн алхам руу шилж.



6. Принтерийн толгойг цэвэрлэхийн тулд дэлгэц дээрх зааврыг дагана уу.

7. Цэвэрлэж дуусахад, цорго шалгах дүрсийг дахин хэвлэнэ. Бүх шугам бүрэн хэвлэгдэх хүртэл цэвэрлэгээг давтаж, дүрс хэвлэхээ үргэлжлүүлнэ.

Холбогдох мэдээлэл

➔ [31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"](#)

Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх — Windows

- А4 хэмжээтэй ердийн цаасыг принтер дээр ачаална.
- Принтерийн драйверийн цонхонд хандана.
- Хошуу Шалгах-г Арчилгаа** таб дээрээс дарна.
- Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Холбогдох мэдээлэл

➔ [31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"](#)

➔ [102 хуудас дээрх "Windows принтерийн драйвер"](#)

Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх — Mac OS X

- А4 хэмжээтэй ердийн цаасыг принтер дээр ачаална.

Хэвлэх, скандах чанарыг сайжруулах

2. Системийн тохиргоо-г  цэс > **Принтер ба Сканнер** (эсвэл **Хэвлэх ба Скандах, Хэвлэх ба Факсдах**)-г сонгоод, дараа нь принтерийг сонгоно.
3. **Сонголт ба Хангамж** > **Хэрэгсэл** > **Принтерийн хэрэгслийг нээх** дээр дарна.
4. **Хошуу Шалгах** дээр дарна.
5. Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Холбогдох мэдээлэл

➔ [31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"](#)

Бэхний Хоолой доторх Бэхийг Солих

Хэрэв та принтерийг удаан хугацаанд хэрэглэхгүй байж байгаад хэвлэсэн үр дүнд үелсэн зураас эсвэл дутуу өнгө ажиглагдвал, асуудлыг шийдэхийн тулд бэхний хоолой доторх бэхийг солих шаардлагатай байж магадгүй. **Бэх Зайлалт** хэрэглүүр нь танд бэхний хоолой доторх бүх бэхийг солих боломжийг олгоно.



Чухал:

- ❑ Энэхүү тохиргоо нь маш их бэхийг хэрэглэдэг. Энэхүү тохиргоог хэрэглэхийн өмнө, принтерийн бэхийн саванд хангалттай бэх байгаа эсэхийг шалгана уу. Хангалттай бэх байхгүй бол, бэхний савыг дүүргэнэ.
- ❑ Энэ үзүүлэлт нь бэхний дэвсгэрийн эдэлгээний хугацаанд нөлөөлнө. Энэ үзүүлэлтийг ажиллуулсанаар бэхний дэвсгэр багтаамжиндаа илүү хурдан хүрнэ. Эдэлгээний хугацаа нь дуусахаас өмнө Epson буюу Epson-ы итгэмжлэгдсэн үйлчилгээ үзүүлэгчид хандан сэлбэгийг захиалаарай. Энэ нь хэрэглэгчийн-засах боломжгүй эд анги юм.
- ❑ Бэх Зайлалт тохиргоог ашигласны дараа, принтерийг унтрааж, 12-с доошгүй хугацаагаар хүлээх хэрэгтэй. Энэхүү тохиргоог ашиглах нь 12 цагийн дараагаас хэвлэх чанарыг дээшлүүлнэ. Гэсэн хэдий ч, энэ нь сүүлд хэрэглэснээс хойш 12 цагийн дотор дахин ашиглах боломжгүй. Дээр дурдсан бүх аргыг оролдоод асуудлаа шийдэж чадахгүй байвал, Epson-н тусламж дэмжлэгтэй холбоо барина уу.

Бэхний хоолой доторх бэхийг солих — Windows

1. Принтерийн драйверийн цонхонд хандана.
2. **Бэх Зайлалт**-г **Арчилгаа** таб дээрээс дарна.
3. Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Холбогдох мэдээлэл

➔ [102 хуудас дээрх "Windows принтерийн драйвер"](#)

Бэхний хоолой доторх бэхийг солих — Mac OS X

1. Системийн тохиргоо-г  цэс > **Принтер ба Сканнер** (эсвэл **Хэвлэх ба Скандах, Хэвлэх ба Факсдах**)-г сонгоод, дараа нь принтерийг сонгоно.
2. **Сонголт ба Хангамж** > **Хэрэгсэл** > **Принтерийн хэрэгслийг нээх** дээр дарна.
3. **Бэх Зайлалт** дээр дарна.
4. Дэлгэц дээрх зааврыг дагана уу.


Принтерийн толгойг тохируулна

Та босоо шугамын үл тохирол, эсвэл бүдэг зургийг ажиглавал, принтерийн толгойг тохируулна.

Хэвлэх Толгойг Тэгштгэх - Хянах Самбар

1. А4 хэмжээтэй цулгүй цаасыг принтерт ачаална.
 2. Нүүр дэлгэцнээс **Тохируулга**-д нэвтэрнэ.
 3. **Арчилгаа** > **Хэвлэх Толгойг Тэгштгэх**-ийг сонгоно.
 4. **Босоогоор Тэгшитгэх** буюу **Хөндлөнгөөр Тэгштгэх**-ийг сонгоод, дэлгэцэн дээрх зааврыг дагаж тэгштгэх хээг хэвлэнэ.
 - ☐ Босоогоор Тэгшитгэх: Хэрэв таны хэвлэсэн материал бүрэлзэж харагдах буюу босоо заагч шугамууд нь тэгш бүс байвал үүнийг сонгоорой.
 - ☐ Хөндлөнгөөр Тэгштгэх: Хэрэв тогтмол зайтай хөндлөн судлууд харагдвал үүнийг сонгоорой.
- Тэмдэглэл:**
Туршилтын хээ нь загвараас хамаарч өөр байж магадгүй.
5. Дэлгэцэн дээрх зааврыг дагаж хэвлэх толгойг тэгшитгэнэ.
 - ☐ Босоогоор Тэгшитгэх: Бүлэг бүр дэх хамгийн тод хээг хайн олж дугаарыг нь оруулна.

#1



Хэвлэх, скандах чанарыг сайжруулах

- ☐ Хөндлөнгөөр Тэгштгэх: Хамгийн бага давхцсан, бага тусгаарлагдсан хээг хайн олж дугаарыг нь оруулна.



Холбогдох мэдээлэл

➔ [31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"](#)

Принтерийн толгойг тохируулах — Windows

1. А4 хэмжээтэй ердийн цаасыг принтер дээр ачаална.
2. Принтерийн драйверийн цонхонд хандана.
3. **Хэвлэх Толгой Зэрэгцүүлэлт**-г **Арчилгаа** таб дээрээс дарна.
4. Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Холбогдох мэдээлэл

➔ [31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"](#)

➔ [102 хуудас дээрх "Windows принтерийн драйвер"](#)

Принтерийн толгойг тохируулах — Mac OS X

1. А4 хэмжээтэй ердийн цаасыг принтер дээр ачаална.
2. **Системийн тохиргоо**-г  цэс > **Принтер ба Сканнер** (эсвэл **Хэвлэх ба Скандах, Хэвлэх ба Факсдах**)-г сонгоод, дараа нь принтерийг сонгоно.
3. **Сонголт ба Хангамж** > **Хэрэгсэл** > **Принтерийн хэрэгслийг нээх** дээр дарна.
4. **Print Head Alignment** дээр дарна.
5. Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Холбогдох мэдээлэл

➔ [31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"](#)

Цаасны замын бэхний өнгөрийг цэвэрлэх

Хэвлэмэл материал бохирдож цоорсон байвал, доторх бортогыг цэвэрлэнэ.



Чухал:

Принтерийн доторхыг цэвэрлэхдээ ариун цэврийн цаас ашиглаж болохгүй. Принтерийн толгойн цорго ленттэйгээ бөглөрсөн байж болно.

1. A4 хэмжээтэй ердийн цаасыг принтер дээр ачаална.
2. Үндсэн дэлгэцнээс **Тохируулга**-г оруулна уу.
3. **Арчилгаа > Цаас Заагчийг Цэвэрлэх** сонгоно.
4. Цаасны замыг цэвэрлэхийн тулд дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Тэмдэглэл:

Цаас бэхээр бохирдохгүй болох хүртэл энэхүү үйл явцыг давтан явуулна.

Холбогдох мэдээлэл

➔ [31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"](#)

ADF-г цэвэрлэх


ADF-с хуулбарласан, эсвэл скандсан зураг бохирдож, эсвэл түүний эх хувь нь ADF руу зөв орохгүй байвал, ADF-г цэвэрлэнэ.



Чухал:


Принтерийг цэвэрлэхдээ алкоголь болон шингэрүүлэгчийг хэзээ ч ашиглаж болохгүй. Эдгээр химийн бодис нь принтерт эвдрэл гэмтэл учруулж болно.

1. ADF-н тагийг нээнэ.




Хэвлэх, скандах чанарыг сайжруулах

2. ADF-г цэвэрлэхдээ хөнгөн, хуурай, цэвэр даавууг ашиглана.




3. Баримт бичгийн тагийг нээнэ.



Хэвлэх, скандах чанарыг сайжруулах

4. Зураг дээр харуулсан эд ангийг цэвэрлэнэ.



Тэмдэглэл:

- ❑ Хэрэв шилний гадаргуун дээр өөх тос, эсвэл арилгахад хэцүү бусад материалын толбо суусан байвал, бага хэмжээний шил арчигчийг ашиглаж, зөөлөн даавуугаар арилгана. Үлдсэн бүх шингэнийг арчиж хатаана.
- ❑ Шилний гадаргуу дээр хэт чанга дарж болохгүй.
- ❑ Шилний гадаргууг зурах, эвдэлж гэмтээхгүйн тулд болгоомжтой арчина. Эвдэрч гэмтсэн шилэн гадаргуу сканы чанарыг бууруулах магадлалтай.

Сканнерын Шил-г цэвэрлэх

Хуулбарласан зүйл, эсвэл скандсан зургууд бохирдож цоорсон байвал, сканнерын шил-г цэвэрлэнэ.



Болгоомжтой:

Баримтын тагийг нээж хаах үедээ гар, хуруугаа хавчуулахгүй байхад анхаарна. Эс тэгвээс, та гэмтэлд өртөх болно.




Чухал:

Принтерийг цэвэрлэхдээ алкоголь болон шингэрүүлэгчийг хэзээ ч ашиглаж болохгүй. Эдгээр химийн бодис нь принтерт эвдрэл гэмтэл учруулж болно.

Хэвлэх, скандах чанарыг сайжруулах

1. Баримт бичгийн тагийг нээнэ.



2. сканнерын шил-н гадаргууг цэвэрлэхдээ хөнгөн, хуурай, цэвэр даавууг ашиглана.

Тэмдэглэл:

- ❑ Хэрэв шилний гадаргуун дээр өөх тос, эсвэл арилгахад хэцүү бусад материалын толбо суусан байвал, бага хэмжээний шил арчигчийг ашиглаж, зөөлөн даавуугаар арилгана. Үлдсэн бүх шингэнийг арчиж хатаана.
- ❑ Шилний гадаргуу дээр хэт чанга дарж болохгүй.
- ❑ Шилний гадаргууг зурах, эвдэлж гэмтээхгүйн тулд болгоомжтой арчина. Эвдэрч гэмтсэн шилэн гадаргуу сканы чанарыг бууруулах магадлалтай.

Сүлжээний үйлчилгээ болон програмын мэдээлэл

Энэ хэсэгт Epson вэбсайт эсвэл дагалдах CD дээрх, таны принтерт зориулсан сүлжээний үйлчилгээ болон програм хангамжийн бүтээгдэхүүнийг танилцуулах болно.

Epson Connect үйлчилгээ

Интернэт дээр бэлэн байгаа Epson Connect үйлчилгээг ашигласнаар, та ухаалаг утас, таблет компьютер, эсвэл нөтбүүкээсээ хэзээд ч хаанаас ч хэвлэх боломжтой.

Интернэт дээр бэлэн байгаа үйлчилгээний шинж чанарыг доор харуулав.

Email Print	Epson iPrint алсын принтер	Scan to Cloud	Remote Print Driver
✓	✓	✓	✓

Дэлгэрэнгүй мэдээллийг Epson Connect портал вэбсайтаас үз.

<https://www.epsonconnect.com/>

<http://www.epsonconnect.eu> (Зөвхөн Европт)

Web Config

Web Config нь Internet Explorer, Chrome зэрэг вэб хөтчөөр дамжуулж компьютер, эсвэл ухаалаг төхөөрөмж дээр ажилладаг программ хангамж юм. Та принтерийн төлөвийг баталгаажуулж, сүлжээний үйлчилгээ болон принтерийн тохиргоог өөрчилж болно. Web Config-г ашиглахын тулд, принтер, компьютер, эсвэл төхөөрөмжөө нэг сүлжээнд холбох хэрэгтэй.

Тэмдэглэл:

Дараах хөтчийг дэмжиж ажилладаг.

Үйлдлийн систем	Хөтөч
Windows XP эсвэл түүнээс хойших	Internet Explorer 8 эсвэл түүнээс хойших, Firefox*, Chrome*
Mac OS X v10.6.8 эсвэл түүнээс хойших	Safari*, Firefox*, Chrome*
iOS*	Safari*
Android 2.3 эсвэл түүнээс хойших	Өгөгдмөл хөтөч
Chrome OS*	Өгөгдмөл хөтөч

*: Хамгийн сүүлийн хувилбарыг хэрэглэх.

Web Config-г вэб хөтөч дээр ажиллуулах

1. Принтерийн IP хаягаа шалгах.

Тохируулга > Сүлжээний Тохиргоо > Сүлжээний Статус > Утастай LAN/Wi-Fi Статус эсвэл **Wi-Fi Статус**-г эхлэл дэлгэцээс сонгоод дараа нь принтерийн IP хаягийг шалгана.

2. Вэб хөтчийг компьютер, эсвэл ухаалаг төхөөрөмжөөсөө ажиллуулж, дараа нь принтерийн IP хаягийг оруулна.

Формат:

IPv4: <http://принтерийн IP хаяг/>

IPv6: [http://\[принтерийн IP хаяг\]/](http://[принтерийн IP хаяг]/)

Жишээ:

IPv4: <http://192.168.100.201/>

IPv6: [http://\[2001:db8::1000:1\]/](http://[2001:db8::1000:1]/)

Тэмдэглэл:

Ухаалаг төхөөрөмж ашигласнаар та Web Config-г Epson iPrint-н засвар үйлчилгээний дэлгэцнээс ажиллуулж болно.

Холбогдох мэдээлэл

➔ [56 хуудас дээрх "Epson iPrint ашиглах"](#)

Web Config-ыг Windows дээр ажиллуулах

WSD ашиглан компьютерыг принтерт холбох үед, доорх алхамуудыг дагаж Web Config-ыг ажиллуулна.

1. Windows дээр төхөөрөмж болон принтерүүдэд ханд.

☐ Windows 8.1/Windows 8/Windows Server 2012 R2/Windows Server 2012

Десктоп > Тохиргоо > Хянах Самбар > Төхөөрөмж болон принтерүүдийг үзэх-ийг **Техник хангамж болон Дуу** (эсвэл **Техник хангамж**) дээрээс сонго.

☐ Windows 7/Windows Server 2008 R2

Эхлэл товчийг дараад **Хянах Самбар > Төхөөрөмж болон принтерүүдийг үзэх**-ийг **Техник хангамж болон Дуу** дээрээс сонго.

☐ Windows Vista/Windows Server 2008

Эхлэл товчийг дараад **Хянах Самбар > Принтерүүд**-ийг **Техник хангамж болон Дуу** дээрээс сонго.

2. Принтер дээрээ хулганы баруун товчоор дарж **Шинж чанарууд**-ыг сонго.

3. **Вэб үйлчилгээ** табыг сонгоод URL-ыг дар.

Web Config-г Mac OS X дээр ажиллуулах

1. Системийн тохиргоо-г  цэс > **Принтер ба Сканнер** (эсвэл **Хэвлэх ба Скандах, Хэвлэх ба Факсдах**)-г сонгоод, дараа нь принтерийг сонгоно.
2. **Сонголт ба хангамж** > **Принтерийн вэб хуудсыг харуулах** дээр дарна.

Windows принтерийн драйвер

Принтерийн драйвер нь бусад програмаас авсан хэвлэх командын дагуу принтерийг удирддаг. Принтерийн драйвер дээр тохиргоог хийх нь хамгийн сайн хэвлэлтийн үр дүнд хүргэнэ. Мөн принтерийн драйверийн хэрэглүүрийг ашиглан принтерийн төлвийг шалган, үйл ажиллагаа явуулах хамгийн сайн нөхцлийг хангах боломжтой.

Тэмдэглэл:

Та принтерийн драйверийн хэлийг өөрчилж болно. **Хэл** тохиргооноос **Арчилгаа** таб дээрээс та хэрэглэхийг хүсэж буй хэлээ сонгоно.

Программ хангамжаас принтерийн драйверт хандах

Таны ашиглаж буй программ хангамжид зориулсан тохиргоог хийхийн тулд, тус программ хангамжаас драйверт хандана.

Хэвлэх эсвэл **Принтерийн тохиргоо** from the **Файл** цэснээс сонгоно. Принтерээ сонгож, дараа нь **Тохиргоо** эсвэл **Үзүүлэлт** дээр дарна.

Тэмдэглэл:

Программ хангамжаас шалтгаалж явуулах үйл ажиллагаа өөр өөр байна. Дэлгэрэнгүй мэдээллийг программ хангамжийн тусламжаас үзнэ үү.

Хяналтын самбараас принтерийн драйверт хандах

Бүх программ хангамжид ашиглаж болох тохиргоог хийхийн тулд хяналтын самбараас драйверт хандана.

- ☐ Windows 8.1/Windows 8/Windows Server 2012 R2/Windows Server 2012

Десктоп > Тохиргоо > Хяналтын самбар > Төхөөрөмж, принтер харах-г Техник хангамж ба дуу дээрээс сонгоно. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарах эсвэл түүн дээр дарж байгаад **Хэвлэх тохиргоо**-г сонгоно.

- ☐ Windows 7/Windows Server 2008 R2

Старт товч дээр дарж, **Хяналтын самбар > Техник хангамж, принтерийг харах-г Техник хангамж ба дуу** дээрээс сонгоно. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарж **Хэвлэх тохиргоо**-г сонгоно.

- ☐ Windows Vista/Windows Server 2008

Старт товч дээр дарж, **Хяналтын самбар > Принтер-г Техник хангамж ба дуу** дээрээс сонгоно. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарж **Хэвлэх тохиргоог сонгох**-г сонгоно.

- ☐ Windows XP/Windows Server 2003 R2/Windows Server 2003

Старт товч дээр дарж, **Хяналтын самбар > Принтер ба бусад Техник хангамж > Принтер ба Факс**-г сонгоно. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарж **Хэвлэх тохиргоо**-г сонгоно.

Сүлжээний үйлчилгээ болон програмын мэдээлэл

Хэрэгслийг эхлүүлэх

Принтерийн драйверийн цонхонд хандана. **Арчилгаа** табыг товшино.

Windows-н принтерийн драйверын тохиргоог хязгаарлах

Бусад хэрэглэгчид принтерийн тохиргоог өөрчилж болохгүй байхаар та принтерийн драйверийн тохиргоог түгжиж болно.

Тэмдэглэл:

Компьютер руу админы эрхээр нэвтэрнэ.

1. Принтерийн тохиргоон дээрх **Дагалдах Тохиргоо** табыг нээнэ.

☐ Windows 8.1/Windows 8/Windows Server 2012

Десктоп > Тохиргоо > Хяналтын самбар > Төхөөрөмж, принтер харах-г Техник хангамж ба дуу дээрээс сонгоно. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарах эсвэл түүн дээр дарж байгаад **Принтерийн тохиргоо**-г сонгоно. **Дагалдах Тохиргоо** табыг товшино.

☐ Windows 7/Windows Server 2008 R2

Старт товч дээр дарж, **Хяналтын самбар > Техник хангамж, принтерийг харах-г Техник хангамж ба дуу** дээрээс сонгоно. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарж, **Принтерийн үзүүлэлт**-г сонгоно. **Дагалдах Тохиргоо** табыг товшино.

☐ Windows Vista/Windows Server 2008

Старт товч дээр дарж, **Хяналтын самбар > Принтер-г Техник хангамж ба дуу** дээрээс сонгоно. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарж, **Үзүүлэлт**-г сонгоно. **Дагалдах Тохиргоо** табыг товшино.

☐ Windows XP/Windows Server 2003 R2/Windows Server 2003

Старт товч дээр дарж, **Хяналтын самбар > Принтер ба бусад Техник хангамж > Принтер ба Факс**-г сонгоно. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарж, **Үзүүлэлт**-г сонгоно. **Дагалдах Тохиргоо** табыг товшино.

2. **Драйверийн Тохиргоо** дээр дарна.

3. Хязгаарлахыг хүсэж буй тохиргоог сонгоно.

Зүйлсийг тохируулах тайлбарыг онлайн тусламжаас харна уу.

4. **ОК** дээр дарна.

Windows принтерийн драйверт ашиглалтын тохиргоог хийх

EPSON Status Monitor 3-г идэвхжүүлэх зэрэг тохиргоог хийж болно.

1. Принтерийн драйверийн цонхонд хандана.

2. **Өргөтгөсөн Тохиргоо**-г **Арчилгаа** таб дээрээс дарна.

Сүлжээний үйлчилгээ болон програмын мэдээлэл

3. Зохих тохиргоог хийж, дараа нь **ОК**-г дарна.
Зүйлсийг тохируулах тайлбарыг онлайн тусламжаас харна уу.

Холбогдох мэдээлэл

➔ [102 хуудас дээрх “Windows принтерийн драйвер”](#)

Mac OS X принтерийн драйвер

Принтерийн драйвер нь бусад програмаас авсан хэвлэх командын дагуу принтерийг удирддаг. Принтерийн драйвер дээр тохиргоог хийх нь хамгийн сайн хэвлэлтийн үр дүнд хүргэнэ. Мөн принтерийн драйверийн хэрэглүүрийг ашиглан принтерийн төлвийг шалган, үйл ажиллагаа явуулах хамгийн сайн нөхцлийг хангах боломжтой.

Программ хангамжаас принтерийн драйверт хандах

Цаасны Тохируулга буюу **Хэвлэх**-ийг програмынхаа **Файл** цэснээс дар. Хэрэв шаардлагатай бол, **Дэлгэрэнгүйг Харуулах** (эсвэл ▼)-г дарж хэвлэх цонхыг томруулж болно.

Тэмдэглэл:

Хэрэглэж байгаа програмаас шалтгаалж, **Цаасны Тохируулга** нь **Файл** цэсэд байхгүй байж магадгүй ба хэвлэх цонхыг харуулах үйлдлүүд өөр байж бас магадгүй. Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.

Хэрэгслийг эхлүүлэх

Системийн тохиргоо-г  цэс > **Принтер ба Сканнер** (эсвэл **Хэвлэх ба Скандых, Хэвлэх ба Факсдах**)-г сонгоод, дараа нь принтерийг сонгоно. **Сонголт ба Хангамж** > **Хэрэгсэл** > **Принтерийн хэрэгслийг нээх** дээр дарна.

Mac OS X Принтерийн Драйверт Ажиллагааны Тохиргоо хийх

Mac OS X Принтерийн Драйверын Ажиллагааны Тохиргоонд Хандах

System Preferences-ыг  цэс > **Printers & Scanners** (эсвэл **Print & Scan, Print & Fax**)-аас сонгоод принтерийг сонго. **Options & Supplies** > **Options** (эсвэл **Driver**)-ыг дар.

Mac OS X принтерийн драйверын үйлдлийн тохиргоонууд

- ☐ Хоосон Хуудсыг Алгас: Хоосон хуудсыг хэвлэхээс сэргийлнэ.
- ☐ Чимээгүй Горим: Чимээгүй хэвлэнэ. Гэвч, принтерийн хурд удааширч магадгүй.
- ☐ High Speed Printing: Хэвлэх толгой хоёр чиглэлд хөдлөх үед хэвлэнэ. Хэвлэх хурд илүү хурдан боловч, хэвлэлтийн чанар муудаж магадгүй.
- ☐ Warning Notifications: Принтерийн драйвер анхааруулгын зурвас харуулах боломжтой болно.

Сүлжээний үйлчилгээ болон програмын мэдээлэл

- ❑ Establish bidirectional communication: Ихэнх тохиолдолд үүнийг **On** байлгах шаардлагатай. **Off**-г, принтерийг сүлжээн дээр Windows компьютерүүдтэй хуваалцан хэрэглэж байгаа буюу бусад ямарваа шалтгааны улмаас принтерийн мэдээллийг авах боломжгүй үед хэрэглэнэ.

EPSON Scan (Сканнерийн драйвер)

EPSON Scan нь скандах үйл ажиллагааг хянадаг программ хангамж юм. Та скандах зурагны хэмжээ, нягтрал, цайвар, өнгө ялгарал, чанарыг тохируулж болно.

Тэмдэглэл:

Түүнчлэн, та TWAIN тохируулгатай сканы программ хангамжаас EPSON Scan-г ажиллуулж болно.

Windows дээр асаах

Тэмдэглэл:

Windows Server үйлдлийн системийн хувьд, та **Десктопын туршлага** тохиргоог суулгах шаардлагатай.

- ❑ Windows 8.1/Windows 8/Windows Server 2012 R2/Windows Server 2012
Хайлтын талбар дээр программ хангамжийн нэрийг оруулж, дараа нь гарч ирсэн тэмдгийг сонгоно.
- ❑ Windows 8.1/Windows 8/Windows Server 2012 R2/Windows Server 2012-с бусдад
Старт товч дээр дарж **Бүх программ** эсвэл **Программ > EPSON > EPSON Scan > EPSON Scan**-г сонгоно.

Mac OS X дээр асаах

Тэмдэглэл:

EPSON Scan нь Mac OS X-н хэрэглэгчийг хурдан солих тохиргоог дэмждэггүй. Хэрэглэгчийг хурдан солих тохиргоог унтраана.

Шилжих > Программ хангамж > Epson Software > EPSON Scan-г сонгоно.

Epson Event Manager

Epson Event Manager нь үйл ажиллагааны менежер нь хяналтын самбараас скандах ажиллагааг удирдах, компьютерт зураг хадгалах боломж олгодог программ хангамж юм. Та баримт бичгийн төрөл, хадгалах хавтасны байрлал, зургийн формат зэрэг өөрийн тохиргоогоо урьдчилсан тохиргоо байдлаар нэмж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг программ хангамжийн тусламжаас үзнэ үү.

Тэмдэглэл:

Windows Server үйлдлийн системийг дэмжиж ажилладаггүй.

Windows дээр асаах

- ❑ Windows 8.1/Windows 8
Хайлтын талбар дээр программ хангамжийн нэрийг оруулж, дараа нь гарч ирсэн тэмдгийг сонгоно.

Сүлжээний үйлчилгээ болон програмын мэдээлэл

- ❑ Windows 7/Windows Vista/Windows XP

Старт товч дээр дарж **Бүх программ** эсвэл **Программууд > Epson Software > Event Manager**-г сонгоно.

Mac OS X дээр асаах

Шилжих > Программ хангамж > Epson Software > Event Manager-г сонгоно.

Холбогдох мэдээлэл

➔ [61 хуудас дээрх "Компьютер руу скандах"](#)

PC-FAX Драйвер (Факсын драйвер)

PC-FAX драйвер нь, өөр программ дээр бүтээсэн баримтыг компьютероос шууд факс хэлбэрээр илгээх боломжтой програм юм. PC-FAX драйвер нь ФАКС Хэрэглүүрийг суулгах үед давхар суулгагдана. Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.

Тэмдэглэл:

- ❑ *Windows Server үйлдлийн системүүд дэмжигдэхгүй.*
- ❑ *Тухайн баримтыг үүсгэхэд ашигласан програмаас хамаарч үйлдэл харилцан адилгүй байна. Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.*

Windows-оос хандах

Програмын **Хэвлэх** эсвэл **Хэвлэх Тохируулга**-г **Файл** цэснээс сонгоно. Принтер (ФАКС)-ээ сонгож, дараа нь **Тохируулгууд** эсвэл **Шинж чанар** дээр дарна.

Mac OS X-оос хандах

Програмын **Хэвлэх**-г **Файл** цэснээс сонгоно. Принтер (ФАКС)-ээ **Принтер**-н тохиргоо болгож сонгоод, дараа нь **Fax Settings** эсвэл **Recipient Settings**-г дэлгэгддэг цэснээс сонгоно.

FAX Utility

FAX Utility нь компьютероос факс илгээхэд зориулсан төрөл бүрийн тохиргоо хийх боломж олгодог программ хангамж юм. Та факс илгээх үед ашиглах харилцах жагсаалтаа үүсгэж эсвэл өөрчилж болох ба хүлээж авсан файлаа компьютер дээр PDF форматаар хадгалахаар тохиргоо хийж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг программ хангамжийн тусламжаас үзнэ үү.

Тэмдэглэл:

- ❑ *Windows Server үйлдлийн системийг дэмжиж ажилладаггүй.*
- ❑ *FAX Utility-г суулгахаас өмнө, та энэхүү принтерийн драйверийг суулгасан гэдгээ бататгана.*

Windows дээр асаах

- ❑ Windows 8.1/Windows 8

Хайлтын талбар дээр программ хангамжийн нэрийг оруулж, дараа нь гарч ирсэн тэмдгийг сонгоно.

Сүлжээний үйлчилгээ болон програмын мэдээлэл

☐ Windows 7/Windows Vista/Windows XP

Старт товч дээр дарж **Бүх программ** (эсвэл **Программ**) > **Epson Software** > **FAX Utility**-г сонгоно.

Mac OS X дээр асаах

Системийн тохиргоо-г  цэс > **Принтер ба Сканнер** (эсвэл **Хэвлэх ба Скандах, Хэвлэх ба Факсдах**)-г сонгоод, дараа нь принтерийг сонгоно. **Сонголт ба Хангамж** > **Хэрэгсэл** > **Принтерийн хэрэгслийг нээх** дээр дарна.

Epson Easy Photo Print

Epson Easy Photo Print нь төрөл бүрийн загвартайгаар фото зураг хялбараар хэвлэх боломж олгодог программ хангамж юм. Та фото зургийг урьдчилан харж, зураг эсвэл байрлалыг нь тохируулах боломжтой. Түүнчлэн, та фото зургаа хүрээтэйгээр хэвлэж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг программ хангамжийн тусламжаас үзнэ үү.

Тэмдэглэл:

- ☐ Windows Server үйлдлийн системийг дэмжиж ажилладаггүй.
- ☐ Энэхүү программ хангамжийг ашиглахын тулд принтерийн драйверийг суулгах шаардлагатай.

Windows дээр асаах

☐ Windows 8.1/Windows 8

Хайлтын талбар дээр программ хангамжийн нэрийг оруулж, дараа нь гарч ирсэн тэмдгийг сонгоно.

☐ Windows 7/Windows Vista/Windows XP

Старт товч дээр дарж **Бүх программ** эсвэл **Программууд** > **Epson Software** > **Epson Easy Photo Print**-г сонгоно.

Mac OS X дээр асаах

Очих > **Програмууд** > **Epson Software** > **Epson Easy Photo Print**-г сонго.

E-Web Print (Windows-т зөвхөн)

E-Web Print нь төрөл бүрийн загвартайгаар вэб хуудас хялбараар хэвлэх боломж олгодог программ хангамж юм. Дэлгэрэнгүй мэдээллийг программ хангамжийн тусламжаас үзнэ үү. Та тусламж руу **E-Web Print** цэснээс **E-Web Print** багажийн мөр дээрээс орж болно.

Тэмдэглэл:

Windows Server үйлдлийн системийг дэмжиж ажилладаггүй.

Асаах

E-Web Print-г суулгах үед, энэ нь таны вэб хөтөч дээр харагдана. **Print** эсвэл **Clip** дар.

EPSON Software Updater

EPSON Software Updater нь интернэт дээр шинэ эсвэл шинэчилсэн программ хангамж байгаа эсэхийг шалгаж түүнийг суулгадаг программ хангамж юм. Түүнчлэн, та принтерийн компаниас гаргасан программ хангамж, гарын авлагыг шинэчилж болно.

Тэмдэглэл:

Windows Server үйлдлийн системийг дэмжиж ажилладаггүй.

Windows дээр асаах

☐ Windows 8.1/Windows 8

Хайлтын талбар дээр программ хангамжийн нэрийг оруулж, дараа нь гарч ирсэн тэмдгийг сонгоно.

☐ Windows 7/Windows Vista/Windows XP

Старт товч дээр дарж **Бүх программ** (эсвэл **Программ**) > **Epson Software** > **EPSON Software Updater**-г сонгоно.

Mac OS X дээр асаах

Шилжих > **Программ хангамж** > **Epson Software** > **EPSON Software Updater**-г сонгоно.

EpsonNet Config

EpsonNet Config нь сүлжээний интерфэйсийн хаяг, протоколыг тохируулах боломж олгодог программ хангамж юм. EpsonNet Config-н ажиллуулах заавар эсвэл программ хангамжийн тусламж үйлчилгээг дэлгэрэнгүй үзнэ үү.

Windows дээр асаах

☐ Windows 8.1/Windows 8/Windows Server 2012 R2/Windows Server 2012

Хайлтын талбар дээр программ хангамжийн нэрийг оруулж, дараа нь гарч ирсэн тэмдгийг сонгоно.

☐ Windows 8.1/Windows 8/Windows Server 2012 R2/Windows Server 2012-с бусдад

Старт товч дээр дарж **Бүх программ** (эсвэл **Программ**) > **EpsonNet** > **EpsonNet Config V4** > **EpsonNet Config**-г сонгоно.

Mac OS X дээр асаах

Шилжих > **Программ хангамж** > **Epson Software** > **EpsonNet** > **EpsonNet Config V4** > **EpsonNet Config**-г сонгоно.

Программ хангамжийг суулгах

Тэмдэглэл:

Компьютер руу админы эрхээр нэвтэрнэ. Компьютер танаас шаардвал админы нууц үгийг оруулна.

Программ хангамжийг устгах — Windows

1. Принтерийг унтраахын тулд  товчийг дарна.
2. Ажиллаж буй бүх программ хангамжаас гарч хаана.
3. **Хяналтын самбар**-г нээнэ:
 - ☐ Windows 8.1/Windows 8/Windows Server 2012 R2/Windows Server 2012
Десктоп > Тохиргоо > Хяналтын самбар-г сонгоно.
 - ☐ Windows 8.1/Windows 8/Windows Server 2012 R2/Windows Server 2012-с бусдад
Старт товч дээр дарж **Хяналтын самбар**-г сонгоно.
4. **Программ хангамжийг устгах**-г нээнэ (эсвэл **Программ хангамжийг нэмэх эсвэл устгах**):
 - ☐ Windows 8.1/Windows 8/Windows 7/Windows Vista/Windows Server 2012 R2/Windows Server 2012/Windows Server 2008 R2/Windows Server 2008
Программыг устгах-г **Программууд** дээрээс сонгоно.
 - ☐ Windows XP/Windows Server 2003 R2/Windows Server 2003
Программ хангамжийг нэмэх эсвэл устгах дээр дарна.
5. Устгахыг хүсэж буй программ хангамжаа сонгоно.
6. Программ хангамжийг устгах:
 - ☐ Windows 8.1/Windows 8/Windows 7/Windows Vista/Windows Server 2012 R2/Windows Server 2012/Windows Server 2008 R2/Windows Server 2008
Устгах/Өөрчлөх эсвэл **Устгах** дээр дарна.
 - ☐ Windows XP/Windows Server 2003 R2/Windows Server 2003
Өөрчлөх/Устгах эсвэл **Устгах** дээр дарна.

Тэмдэглэл:
*Хэрэглэгчийн дансны хяналт-н цонх гарч ирвэл, **Үргэлжлүүлэх** дээр дарна.*
7. Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Программ хангамжийг устгах — Mac OS X

1. Uninstaller-г EPSON Software Updater ашиглаж татаж авна.
Uninstaller-г татаж авсны дараа, та тус программ хангамжийг устгах бүртээ үүнийг дахин татаж авах шаардлагагүй болно.
2. Принтерийг унтраахын тулд  товчийг дарна.
3. Принтерийн драйвер эсвэл PC-FAX драйверийг устгахын тулд, **Системийн тохиргоо**-г -г цэс > **Принтер ба Сканнер** (эсвэл **Хэвлэх ба Скандах, Хэвлэх ба Факсдах**)-г сонгож, дараа нь идэвхжүүлсэн принтерийн жагсаалтаас принтерийг устгана.
4. Ажиллаж буй бүх программ хангамжаас гарч хаана.

Сүлжээний үйлчилгээ болон програмын мэдээлэл

5. **Шилжих > Программ хангамж > Epson Software > Uninstaller**-г сонгоно.
6. Устгахыг хүсэж буй программ хангамжаа сонгож, дараа нь **Uninstall** дээр дарна.



Чухал:

Uninstaller нь компьютер дээрх Epson бэхээр ажилладаг принтерийн бүх драйверийг устгана. Та Epson бэхээр ажилладаг олон тооны принтер ашиглаж бөгөөд та тэдгээрийн заримыг устгахыг хүсэж байгаа бол, эхлээд тэдгээрийг бүгдийг устгаад дараа нь шаардлагатай принтерийн драйверийг дахин суулгана.

Тэмдэглэл:

Та программ хангамжийн жагсаалт дээр устгахыг хүсэж буй программ хангамжаа олж чадахгүй байвал, Uninstaller устгагчийг ашиглаж устгаж чадахгүй. Энэ тохиолдолд, **Шилжих > Програмууд > Epson Software** руу орж, устгахыг хүсэж буй программ хангамжаа сонгож дараа нь түүнийг хогийн савын тэмдэг рүү зөөнө.

Холбогдох мэдээлэл

➔ [108 хуудас дээрх "EPSON Software Updater"](#)

Программ хангамжийг устгах

Компьютерөө сүлжээнд холбож вэбсайтаас програмын хамгийн сүүлийн хувилбарыг татаарай.

Тэмдэглэл:

- ❑ Компьютер руу админы эрхээр нэвтэрнэ. Компьютер танаас шаардвал админы нууц үгийг оруулна.
- ❑ Программ хангамжийг дахин суулгах үед, та үүнийг эхлээд устгах шаардлагатай.

1. Ажиллаж буй бүх программ хангамжаас гарч хаана.
2. Принтерийн драйвер эсвэл EPSON Scan суулгах үед, принтер, компьютер хоёрыг түр хугацаагаар салгана.

Тэмдэглэл:

Таныг холбо гэж заавар өгөх хүртэл принтер, компьютер хоёрыг холбож болохгүй.

3. Доорх вэбсайт дээрх зааврыг дагаж программ хангамжийг суулгана.

<http://epson.sn>

Тэмдэглэл:

Хэрэв та Windows хэрэглэж байгаа ба вэбсайтаас програмыг татаж авч чадахгүй байвал, принтертэй хамт ирсэн програм хангамжийн дискнээс суулгаж болно.

Холбогдох мэдээлэл

➔ [108 хуудас дээрх "Программ хангамжийг суулгах"](#)

Программ хангамж, компанийн программыг шинэчлэх

Та программ хангамж, компанийн программыг шинэчилснээр тодорхой асуудлыг шийдэж, үүрэг ажиллагааг сайжруулан мөн нэмэх боломжтой. Та программ хангамж, компанийн программын хамгийн сүүлийн үеийн хувилбарыг ашиглаж байгаагаа баталгаажуулна уу.

1. Принтер, компьютер хоёр холбогдсон бөгөөд компьютер интернэтэд холбогдсон эсэхийг шалгана уу.
2. EPSON Software Updater-г асааж, программ хангамж болон компанийн программ хангамжийг шинэчилнэ.



Чухал:

Шинэчилж байхдаа компьютер, принтерээ унтрааж болохгүй.

Тэмдэглэл:

Та жагсаалт дээр шинэчлэхийг хүсэж буй программ хангамжаа олж чадахгүй байвал, EPSON Software Updater-г ашиглаж шинэчилж чадахгүй. Программ хангамжийн хамгийн сүүлийн хувилбарыг Epson-н вэбсайтаас шалгана.

<http://www.epson.com>

Холбогдох мэдээлэл

➔ [108 хуудас дээрх "EPSON Software Updater"](#)

Асуудлыг шийдэх

Принтерийн төлөвийг шалгах

LCD дэлгэц дээрх зурвасыг шалгах

Хэрэв LCD дэлгэц дээр алдааны зурвас гарч ирвэл, дэлгэц дээрх заавар эсвэл доорх шийдлүүдийг дагаж асуудлыг шийдээрэй.

Алдааны Зурвас	Шийдлүүд
Принтерийн Алдаа 0xXX Тэжээлийг унтраагаад дахин асаа. Дэлгэрэнгүйг бичиг баримтаасаа үзнэ үү.	Принтер доторх аливаа цаас буюу хамгаалалтын материал бүгдийг гаргана. Хэрэв тэжээлийг унтрааж дахин асаасны дараа алдааны зурвас гарсан хэвээр байвал, Epson дэмжлэг үйлчилгээтэй холбоо барина үү.
Принтерийн бэхний дэвсгэрийн үйлчилгээний хугацаа дуусах дөхөж байна. Epson Тусламжтай холбогдоно үү.	Бэхний дэвсгэрийг солихын тулд Epson эсвэл итгэмжлэгдсэн Epson үйлчилгээ үзүүлэгчтэй холбоо барина үү*. Энэ нь хэрэглэгчийн-засах боломжгүй эд анги юм. Энэ зурвас нь бэхний дэвсгэрийн сольтол гарч ирсээр байх болно. ◇ товчийг дарж үргэлжлүүлэн хэвлэнэ.
Принтерийн бэхний дэвсгэрийн үйлчилгээний хугацаа дуусч байна. Epson Тусламжтай холбогдоно үү.	Бэхний дэвсгэрийг солихын тулд Epson эсвэл итгэмжлэгдсэн Epson үйлчилгээ үзүүлэгчтэй холбоо барина үү*. Энэ нь хэрэглэгчийн-засах боломжгүй эд анги юм.
Холбооны алдаа. Компьютер холбогдсон эсэхийг шалга.	Компьютер болон принтерийг зөв холбоно. Хэрэв сүлжээгээр холбогдож байгаа бол, <i>Сүлжээний Заавар</i> -г үзнэ үү. Хэрэв алдааны зурвас гарсан хэвээр байвал, EPSON Scan болон Epson Event Manager компьютер дээр суулгагдсан эсэхийг шалга.
Хүчингүй IP хаяг болон сабнэт маск. Зөв оруулна үү. Бичиг баримтыг үзнэ үү.	<i>Сүлжээний Заавар</i> -г үзнэ үү.
Ямар ч дуудлагын дохио танигдсангүй.	Тохируулга > Факсын Тохиргоо > Үндсэн Тохиргоо > Шугамын Төрөл -г сонгоод, дараа нь PBX -г сонгож энэхүү асуудлыг шийдэх боломжтой байж магадгүй. Хэрэв таны утасны систем гадны шугам руу нэвтрэхийн тулд гадаад хандалтын код шаарддаг бол, PBX -г сонгосны дараа хандалтын кодыг тохируулна. Гадаад факсын дугаарыг оруулахдаа бодит хандалтын кодын оронд # (чагт) ашиглаарай. Энэ нь холболтыг илүү аюулгүй болгоно. Хэрэв алдааны зурвас гарсан хэвээр байвал, Дуудлагын Дохио Танилт тохиргоог идэвхгүй болго. Гэвч, энэхүү тохиргоог идэвхгүй болгосноор факсын дугаарын эхний орон гээгдэж, факс буруу дугаар руу илгээгдэж болзошгүй байдаг.

Асуудлыг шийдэх

Алдааны Зурвас	Шийдлүүд
Recovery Mode	Фирмварийн шинэчлэл амжилтгүй болсон тул принтер сэргээх горимд эхэллээ. Доорх алхмыг дагаж фирмварийг дахин шинэчлэнэ үү. 1. Компьютер болон принтерийг USB кабелиар холбо. (Сэргээх горимын үед, фирмварийг сүлжээний холболтоор дамжуулж шинэчлэх боломжгүй.) 2. Дотоодынхоо Epson вэбсайт руу зочилж дэлгэрэнгүй зааврыг аваарай.

* Зарим хэвлэлтийн мөчлөгт, маш бага хэмжээний илүүдэл бэх бэхний дэвсгэрт хуримтлагдаж магадгүй байдаг. Дэвгэрээс бэх гоожихоос сэргийлж, дэвсгэр хязгаартаа хүрэхэд принтер хэвлэлтээ зогсоохоор зохиогдсон байгаа. Ийм явдал тохиолдох эсэх болон хэр олон тохиолдох нь таны хэвлэх хуудасны тоо, хэвлэх материалын төрөл, принтерийн гүйцэтгэсэн цэвэрлэгээний мөчлөг зэргээс хамаарч ялгаатай байна. Үзүүлэлтийн дагуу, дэвсгэрийг солих шаардлагатай гэдэг нь, таны принтер ажиллахаа болино гэсэн үг биш юм. Принтер танд дэвсгэрийг солих шаардлагатай болоход зөвлөх ба зөвхөн итгэмжлэгдсэн Epson Үйлчилгээ үзүүлэгч дээр хийх боломжтой. Epson баталгаа энэ солих явцын үнийг даахгүй.

Холбогдох мэдээлэл

- ➔ [150 хуудас дээрх "Epson-н тусламжтай холбогдох"](#)
- ➔ [110 хуудас дээрх "Программ хангамжийг устгах"](#)
- ➔ [111 хуудас дээрх "Программ хангамж, компанийн программыг шинэчлэх"](#)

Принтерийн төлөвийг шалгах — Windows

1. Принтерийн драйверийн цонхонд хандана.
2. **EPSON Status Monitor 3-г Арчилгаа** таб дээрээс дарна.

Тэмдэглэл:

- ☐ Түүнчлэн, ажлын мөр дээрх принтерийн тэмдэг дээр хулганаар хоёр товшиж принтерийн төлөвийг шалгаж болно. Принтерийн тэмдэг ажлын мөр дээр нэмэгдээгүй бол **Ажиглалтын Тохируулгууд-г Арчилгаа** таб дээрээс сонгоод дараа нь **Товчилбор тэмдэгийг taskbart бүртгүүл-г** сонгоно.
- ☐ **EPSON Status Monitor 3-г** идэвхгүйжүүлсэн бол **Өргөтгөсөн Тохиргоо-г Арчилгаа** таб дээрээс сонгоод дараа нь **EPSON Status Monitor 3-г идэвхжүүл-г** сонгоно.

Холбогдох мэдээлэл

- ➔ [102 хуудас дээрх "Windows принтерийн драйвер"](#)

Принтерийн төлөвийг шалгах — Mac OS X

1. Системийн тохиргоо-г  цэс > **Принтер ба Сканнер** (эсвэл **Хэвлэх ба Скандах, Хэвлэх ба Факсдах**)-г сонгоод, дараа нь принтерийг сонгоно.
2. **Сонголт ба Хангамж** > **Хэрэгсэл** > **Принтерийн хэрэгслийг нээх** дээр дарна.

Асуудлыг шийдэх

3. **EPSON Status Monitor** дээр дарна.

Бөглөрсөн цаасыг салгах

Аливаа урагдсан хэсгээс бүрдэх бөглөрсөн цаасыг салгахын тулд хяналтын самбар дээр гарсан алдааг шалгаж, зааврыг дагана уу. Дараа нь алдааг арилгана.



Чухал:

Бөглөрсөн цаасыг болгоомжтой салгана. Цаасыг хүчтэй салгавал принтерт эвдрэл гэмтэл учруулж болно.


Принтер дотроос бөглөрсөн цаасыг салгах



Болгоомжтой:


- ❑ Сканныйн хэсгийг нээж хаах үедээ гар, хуруугаа хавчуулахгүй байхад анхаарна. Эс тэгвээс, та гэмтэлд өртөх болно.
- ❑ Таны гар принтер дотор байх үед хяналтын самбар дээрх товчнуудад хүрч болохгүй. Принтер ажиллаж эхэлсэн бол, энэ нь биед гэмтэл учруулах боломжтой. Гэмтлээс сэргийлэхийн тулд цухуйсан хэсгүүдэд хүрэхгүй байхад анхаарах хэрэгтэй.

1. Баримт бичгийн тагийг хаалттай хэвээр сканныйн хэсгийг нээнэ.




Асуудлыг шийдэх

2. Бөглөрсөн цаасыг салгана.




Чухал:

Принтер доторх цагаан хавтгай кабель утас, тунгалаг хэсэг, бэхний хоолойнд хүрч болохгүй. Ингэвэл, принтерийн ажиллагааг доголдуулахад хүргэж болно.




3. Сканнерийн хэсгийг хаана.




Асуудлыг шийдэх

Цаасан Кассет дотроос гацсан цаасыг авах


1. Гаралтын тэвшийг хаана.
2. цаасан кассет-ийг татаж гаргана.



3. Гацсан цаасыг авна.



4. Цаасны ирмэгүүдийг тэгшилж, ирмэг заагчийг цаасны ирмэгт тулгаж гулгуулна.




5. цаасан кассет-ийг принтерт суулгана.


Асуудлыг шийдэх

Арын Таг дотроос гацсан цаасыг авах


1. арын таг-ийг салга.



2. Гацсан цаасыг авна.




3. арын таг дотроос гацсан цаасыг авна.




Асуудлыг шийдэх


4. арын таг-ийн тагийн нээнэ.



5. Гацсан цаасыг авна.



6. арын таг-ийн тагийг хааж, арын таг-ийг принтерт суурилуулна.



ADF-аас гацсан цаасыг авах




Болгоомжтой:


Баримтын тагийг хаахдаа хуруугаа хавчуулахаас болгоомжлоорой. Эс бөгөөс гэмтэх аюултай.

Асуудлыг шийдэх


1. ADF-н тагийг нээнэ.



2. Гацсан цаасыг авна.




3. Баримтын тагийг нээнэ.




Асуудлыг шийдэх

4. Гацсан цаасыг авна.



5. Баримтын тагийг хаана.

6. ADF оролтын тэвшийг дээш нь өргөж, гацсан цаасыг авна.



7. ADF-н тагийг хаана.

Цаас зөв татагдахгүй байна

Асуудлыг шийдэхийн тулд, дараах зүйлсийг шалгаад, зохих арга хэмжээг авна уу.

- ☐ Принтерийг тэгш гадаргуу дээр тавьж, зөвлөмж болгосон орчны нөхцөлд ажиллуул.
- ☐ Энэхүү принтерийн дэмждэг цаасыг ашигла.
- ☐ Цаастай харьцах санамжийг дага.
- ☐ Цаасны тохиргоо болон цаасны төрлийн тохиргоо нь бодитоор принтерт ачаалсан цаасны хэмжээ болон төрөлтэй таарч байгаа эсэхийг магадла.

Асуудлыг шийдэх

Холбогдох мэдээлэл

- ➔ 143 хуудас дээрх "Орчны үзүүлэлт"
- ➔ 29 хуудас дээрх "Бэлэн байгаа цаас ба багтаамж"
- ➔ 28 хуудас дээрх "Цаас ашиглахтай холбоотой анхааруулга"

Цаас гацалт

Цаасыг зөв чиглэлд ачаалж, ирмэг заагчийг цаасны ирмэгт тулгаж гулгуулна.

Холбогдох мэдээлэл

- ➔ 31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"

Цаас хазайж татагдаж байвал

Цаасыг зөв чиглэлд ачаалж, ирмэг заагчийг цаасны ирмэгт тулгаж гулгуулна.

Холбогдох мэдээлэл

- ➔ 31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"

Цаасны таталт байхгүй бол

Тухайн цаасанд заасан хуудасны дээд тооноос илүү ихийг бүү ачаалаарай. Цулгүй цаасны хувьд, ирмэг заагч дээрх гурвалжин тэмдгийн заасан шугамаас дээш гаргаж ачаалахгүй байх хэрэгтэй.

Холбогдох мэдээлэл

- ➔ 29 хуудас дээрх "Бэлэн байгаа цаас ба багтаамж"

Нэг дор хэд хэдэн хуудас татагдвал

Гар аргаар 2-талт хэвлэлтийг гүйцэтгэх үед хэд хэдэн хуудас нэг зэрэг татагдаж байгаа бол, цаасыг дахин ачаалахын өмнө принтерт ачаалагдсан бүх цаасыг гарга.

ADF дээр орохгүй эх хувь

- ☐ ADF-н дэмждэг эх хувийг ашиглана.
- ☐ Эх хувийг зөв чиглэлд ачаалж эх хувийн өнцгийг үзүүрийн чиглэлд гулгуулна.
- ☐ ADF-н дотор талыг цэвэрлэнэ.
- ☐ Эхийг ирмэг заагч дээрх гурвалжин тэмдгийн заасан шугамаас дээш гаргаж ачаалахгүй байх хэрэгтэй.
- ☐ ADF-н тэмдэг хяналтын самбар дээр гарч ирэх эсэхийг шалгана. Гарч ирэхгүй байвал, эх хувийг дахин тавина.

Асуудлыг шийдэх

Холбогдох мэдээлэл

- ➔ 34 хуудас дээрх "ADF-д зориулж бэлдсэн эх хувилбар"
- ➔ 34 хуудас дээрх "ADF дээр эх хувийг байрлуулах"
- ➔ 96 хуудас дээрх "ADF-г цэвэрлэх"

Тэжээл ба хяналтын самбарын асуудал

Тэжээл асахгүй байна

- ☐  товчийг бага зэрэг удаан дарна.
- ☐ Тэжээлийн цахилгаан утсыг залгасан эсэхийг шалгана.

Тэжээл унтрахгүй байна

 товчийг бага зэрэг удаан дарна. Та принтерийг унтрааж чадахгүй хэвээр байвал, тэжээлийн цахилгаан утсыг салгана. Принтерийн толгойг хатахаас сэргийлэхийн тулд, принтерийг буцаан асааж  товчийг дарж унтраана.

Тэжээл автоматаар унтарна

- ☐ **Унтраах Тохиргоо-г Тохируулга** дээр сонгоод, **Идэвхгүй бол Унтраах** болон **Салгагдсан бол Унтраах** тохиргоонуудыг идэвхгүй болго.
- ☐ **Унтраах Цаг Тоологч** тохиргоог **Тохируулга** дээр идэвхгүй болго.

Тэмдэглэл:

Үйлдвэрлэсэн огноо, худалдан авсан газраас хамааран таны бүтээгдэхүүнд энэ үзүүлэлт эсвэл **Унтраах Тохиргоо** эсвэл **Унтраах Цаг Тоологч** үзүүлэлт байж магадгүй.

Холбогдох мэдээлэл

- ➔ 21 хуудас дээрх "**Тохируулга** Горим"

LCD дэлгэц бараан болох

Принтер унтах горимд байна. LCD дэлгэцийг өмнөх байдалд нь буцаахын тулд хяналтын самбар дээрх аль нэг товчийг дарна.

Принтер хэвлэхгүй байна

Принтер ажиллахгүй байх эсвэл юу ч хэвлэхгүй байвал дараахыг шалгана уу.

- ☐ USB кабелийг принтер болон компьютерт сайтар холбо.
- ☐ Та USB хаб ашиглаж байгаа бол, принтерийг компьютертой шууд холбоно уу.

Асуудлыг шийдэх

- ❑ Принтерийг сүлжээгээр дамжуулж хэрэглэж байгаа үед, принтерийг сүлжээнд холбогдсон эсэхийг шалгана. Та хяналтын самбар дахь үзүүлэлтийг шалгах, эсвэл сүлжээний төлөвийн хуудсыг хэвлэх замаар төлөвөө шалгаж болно. Принтерийг сүлжээнд холбоогүй бол, *Сүлжээний Заавар*-г үзнэ үү.
- ❑ Та том хэмжээний мэдээлэл бүхий зураг хэвлэж байгаа бол, компьютерын санах ой хүрэхгүй байж болно. Зургийг бага нягтралтайгаар эсвэл бага хэмжээтэйгээр хэвлэнэ үү.
- ❑ Windows дээр **Хэвлэх Дараалал**-г принтерийн драйверийн **Арчилгаа** таб дээрээс дарж, дараа нь доорхыг шалгана уу.
 - ❑ Түр зогсоосон ямарваа хэвлэх ажил байгаа эсэхийг шалгах.
Шаардлагатай бол хэвлэхээ цуцлах.
 - ❑ Принтер оффлайн биш эсэх, эсвэл түр зогссон эсэхийг шалгах.
Хэрэв принтер оффлайн эсвэл түр зогссон бол **Принтер** цэснээс оффлайн эсвэл түр зогссон тохиргоог арилгах.
 - ❑ **Принтер** цэснээс принтерийг өгөгдмөл принтер гэж сонгосон эсэхийг шалгах (цэсний зүйлс дээр зөвлөх тэмдэг байх ёстой).
Хэрэв принтерийг өгөгдмөл принтер гэж сонгоогүй бол, түүнийг өгөгдмөл принтер гэж сонгох.
- ❑ Mac OS X дээр, принтерийн төлөвийг **Түр зогсоосон** гэж тэмдэглээгүй эсэхийг шалгах.
Системийн тохиргоо-г  цэс > **Принтер ба Сканнер** (эсвэл **Хэвлэх ба Скандах, Хэвлэх ба Факсдах**)-г сонгоод, дараа нь принтерийг 2 товшино. Принтерийг түр зогсоосон бол, **Буцаан асаах** (эсвэл **Принтерийг буцаан асаах**) дээр дарна.
- ❑ Цоргоны шалгалтыг гүйцэтгэж, дараа нь принтерийн толгойн аль нэг цорго бөглөрсөн байвал принтерийн толгойг цэвэрлэнэ.
- ❑ Хэрэв та AirPrint-р принтерийг ашиглаж буй бол, AirPrint-н тохиргоог Web Config дээр идэвхжүүл. Энэхүү тохиргоог идэвхгүй болговол, та AirPrint-г ашиглах боломжгүй.

Холбогдох мэдээлэл

- ➔ [58 хуудас дээрх "Хэвлэхийг цуцлах"](#)
- ➔ [91 хуудас дээрх "Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх"](#)
- ➔ [100 хуудас дээрх "Web Config"](#)

Хэвлэмэл материалын асуудал

Хэвлэлтийн чанар муу байвал

Бүдэг хэвлэгдэх, судалтах, өнгө дутуу гарах, өнгө гандах, тэгш бус шугам, шигтгэмэл шиг хээ хэвлэлтэнд гарах зэргээс болж хэвлэлтийн чанар муу бол дараахыг шалгана уу.

- ❑ Эхний бэх цэнэглэлт дууссан эсэхийг магадла.
- ❑ Бэхний савыг шалга. Хэрэв сав хоосон байвал, бэхийг даруй дахин дүүргэж, хэвлэх толгойг цэвэрлэ.
- ❑ Принтерийг удаан хугацааны турш ашиглаагүй бол, принтерийн драйверийн Бэх Зайлалт хэрэгслийг ашиглана.
- ❑ Энэхүү принтерийн дэмждэг цаасыг ашигла.

Асуудлыг шийдэх

- ☐ Принтерт ачаалсан цаасны төрөлд таарсан цаасны зөв төрлийн тохиргоог сонго.
- ☐ Нойтон, урагдсан, эсвэл хэт хуучин цаасан дээр хэвлэхгүй байх.
- ☐ Цаас мушгирсан эсвэл дугтуй овоорсон байвал тэдгээрийг тэнийлгэнэ.
- ☐ Хошуу шалгалтыг гүйцэтгэж, хэвлэх толгойн аль нэг хошуу бөглөрсөн байвал хэвлэх толгойг цэвэрлэ.
- ☐ Хэвлэх толгойг тэгшитгэ.
- ☐ Илүү өндөр чанарын тохиргоогоор хэвлэ.
- ☐ Хэрэв **Стандарт-Тод**-г Windows принтерийн драйвер дээр чанарын тохиргоогоор сонгосон бол **Стандарт** руу соль. Хэрэв **Normal-Vivid**-г Mac OS X принтерийн драйвер дээр чанарын тохиргоогоор сонгосон бол **Normal** руу соль.
- ☐ Хэвлэсний дараа цааснуудыг шууд давхарлаж болохгүй.
- ☐ Хэвлэсэн материалыг хавтаслах, үзүүлэнд тавихаас өмнө бүрэн хатаагаарай. Хэвлэсэн материалыг хатаахдаа, нарны шууд тусгалаас хол байлгаж, хатаагч ашиглахгүй, цаасны хэвлэсэн хэсэгт хүрэхгүй байх хэрэгтэй.
- ☐ Зураг буюу фото зураг хэвлэхдээ, ердийн цулгүй цааснаас илүү жинхэнэ Epson цаасыг ашиглахыг Epson зөвлөж байна. Жинхэнэ Epson цаасны хэвлэж болох тал дээр хэвлэнэ.
- ☐ Epson-н жинхэнэ бэхний хайрцгийг ашиглахыг хичээнэ үү. Энэхүү бүтээгдэхүүн нь Epson-н жинхэнэ бэхний хайрцгийг ашиглах дээр суурилж өнгийг тохируулахаар бүтээгдсэн байдаг. Жинхэнэ бус бэхний хайрцгийг ашиглавал хэвлэлийн чанар муудаж болно.
- ☐ Энэхүү принтерийн зөв кодыг агуулсан бэхний хайрцгийг ашиглана.
- ☐ Сав баглаанд дээр заасан огнооноос өмнө бэхний хайрцгийг ашиглахыг Epson санал болгож байна.
- ☐ Зураг буюу фото зураг хэвлэхдээ, өндөр нарийвчлалтай өгөгдөл ашиглан хэвлээрэй. Вэбсайт дээрх зургууд ихэвчлэн нарийвчлал багатай байдаг ба хэдий дэлгэц дээр гоё харагдах ч хэвлэхэд чанар муутай харагдана.

Холбогдох мэдээлэл

- ➔ 87 хуудас дээрх "Бэхний савыг дахин дүүргэх"
- ➔ 93 хуудас дээрх "Бэхний Хоолой доторх Бэхийг Солих"
- ➔ 29 хуудас дээрх "Бэлэн байгаа цаас ба багтаамж"
- ➔ 30 хуудас дээрх "Цаасны төрлийн жагсаалт"
- ➔ 28 хуудас дээрх "Цаас ашиглахтай холбоотой анхааруулга"
- ➔ 91 хуудас дээрх "Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх"
- ➔ 94 хуудас дээрх "Принтерийн толгойг тохируулна"

Хэвлэх толгойг тэгшитгэсний дараа ч хэвлэлтийн чанар сайжрахгүй байвал

Хоёр чиглэлт (эсвэл өндөр хурдны) хэвлэлтийн үед, хэвлэх толгой хоёр тийш хөдөлж хэвлэдэг учраас босоо шугамууд тэгш бус болж магадгүй байдаг. Хэрэв хэвлэлтийн чанар сайжрахгүй бол, хоёр чиглэлт (эсвэл өндөр хурдны) тохиргоог цуцла. Энэ тохиргоог цуцлах нь хэвлэх хурдыг удаашруулж болзошгүй.

Асуудлыг шийдэх

☐ Windows

Өндөр Хурд-г принтерийн драйверын **Илүү Сонголтууд** таб дээрээс арилга.

☐ Mac OS X

Системийн Тохируулгууд-ыг  цэс > **Принтер & Сканнер** (эсвэл **Хэвлэх & Сканнердах, Хэвлэх & Факсдах**)-аас сонгоод, дараа нь принтерийг сонго. **Сонголт & Хангамж** > **Сонголт** (эсвэл **Драйвер**) дээр дар. **Off**-ыг **High Speed Printing** тохиргоогоор сонго.

Зураг юмуу фото зураг хэвийн бус өнгөөр хэвлэгдэж байвал

Өнгийг тааруулж дахин хэвлэ. Өнгийг автоматаар засах үзүүлэлт нь **ФотоСайжрилт** дахь стандарт засах горимыг ашигладаг. **ФотоСайжрилт** дахь **Автомат Засагч**-аас бусад сонголтыг **Зураг Засвар** тохиргоонд сонгож өөр засах горимыг туршиж үзээрэй. Хэрэв асуудалтай хэвээр байвал, **ФотоСайжрилт**-аас бусад өөр өнгө засах үзүүлэлтийг ашигла.

Холбогдох мэдээлэл

➔ [54 хуудас дээрх "Принтерийн өнгийг тохируулах"](#)

Барагцаагаар 3.3 см-ийн зайтай судлууд гарч ирвэл

Хэвлэх толгойг тэгшитгэ.

Холбогдох мэдээлэл

➔ [94 хуудас дээрх "Принтерийн толгойг тохируулна"](#)

Хуулах Чанар Муу байна

Хэрэв хуулсан зураг дээр жигд бус өнгө, балархай, цэг, шулуун шугам гарч ирвэл дараахыг шалга.

☐ Цаасны замыг цэвэрлэ.

☐ сканнерын шил-ийг цэвэрлэ.

☐ ADF-ийг цэвэрлэ.

☐ Эхийг сканнерын шил дээр байрлуулах үедээ, эх буюу баримтын таг дээр хэт хүчтэй дарж болохгүй. Эх буюу баримтын тагийг хэт хүчтэй дарсан үед жигд бус өнгө, балархайталт, цэгнүүд харагдаж магадгүй.

☐ Хэрэв Муар (хөндлөн огтолсон) хээ харагдвал, жижигрүүлэх томсгох тохиргоог өөрчлөх, эсвэл эхийг бага зэрэг өөр өнцгөөр тавьж үзээрэй.

☐ Цаас балархайтвал, хувилах нягтшилийн тохиргоог багасга.

Холбогдох мэдээлэл

➔ [96 хуудас дээрх "Цаасны замын бэхний өнгөрийг цэвэрлэх"](#)

➔ [98 хуудас дээрх "Сканнерын Шил-г цэвэрлэх"](#)

Асуудлыг шийдэх

- ➔ 96 хуудас дээрх "ADF-г цэвэрлэх"
- ➔ 123 хуудас дээрх "Хэвлэлтийн чанар муу байвал"
- ➔ 18 хуудас дээрх "**Хувилах** Горим"

Эх хувийн эсрэг талын зураг хуулбарласан зураг дээр гарах

- ☐ Нимгэн эх хувийн хувьд эх хувийг сканнерын шил дээр тавьж дараа нь түүний дээгүүр хар цаас тавина.
- ☐ Хяналтын самбар дээрх хуулбарын нягтралын тохиргоог бууруулна.

Холбогдох мэдээлэл

- ➔ 18 хуудас дээрх "**Хувилах** Горим"

Хэвлэмэл материалын байрлал, хэмжээ, хүрээ буруу байх

- ☐ Цаасыг зөв чиглэлд ачаалж цаасны өнцгийг үзүүрийн чиглэлд гулгуулна.
- ☐ Эх хувийг сканнерын шил дээр байрлуулах үед эх хувийн буланг scanner glass-н хүрээний тэмдгээр харуулсан булантай тааруулна. Хуулбарын өнцөг зүсэгдсэн байвал, эх хувийг булангаас бага зэрэг холдуулж гулгуулна.
- ☐ сканнерын шил, баримт бичгийг тагийг цэвэрлэнэ. Шилэн дээр тоос, эсвэл толбо байвал, хуулбарлах талбай нь уг тоос, толбыг багтаахаар томорч болох ба үр дүнд нь хэвлэлийн буруу байрлал, жижиг зургийг бий болгоно.
- ☐ Хяналтын самбар дээр зохих цаасны хэмжээний тохиргоог сонгоно.
- ☐ Хяналтын самбар эсвэл принтерийн драйвер дээр зохих цаасны хэмжээг сонгоно.
- ☐ Хүрээний тохиргоог программ хангамж дээр тохируулж, ингэснээр энэ нь хэвлэх талбай дотор багтах болно.

Холбогдох мэдээлэл

- ➔ 31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"
- ➔ 34 хуудас дээрх "Эх хувийг байрлуулах"
- ➔ 98 хуудас дээрх "Сканнерын Шил-г цэвэрлэх"
- ➔ 139 хуудас дээрх "Хэвлэх талбай"

Цаас балархайтах буюу үнгэгдсэн байвал

Хэвлэх үед цаас балархайтах буюу үнгэгдсэн бол дараахыг шалгана уу.

- ☐ Цаасны замыг цэвэрлэ.
- ☐ сканнерын шил болон баримтын тагийг цэвэрлэ.
- ☐ Цаасыг зөв чиглэлд ачаал.

Асуудлыг шийдэх

- ☐ Гар аргаар 2-талт хэвлэлтийг гүйцэтгэх үед, цаасыг дахин ачаалахын өмнө бэх бүрэн хатсан эсэхийг шалгана.
- ☐ Автомат 2-талт хэвлэлт ашиглан зураг, граф зэрэг өндөр нягтшилтай өгөгдлийг хэвлэх үед, хэвлэх нягтшилийн тохиргоог бууруулж удаан хатах хугацааг сонгоно.
- ☐ Цаасыг хувилах үед балархайтсан бол, хянах самбар дээрх хувилах нягтшилийн тохиргоог багасгана.

Холбогдох мэдээлэл

- ➔ 96 хуудас дээрх "Цаасны замын бэхний өнгөрийг цэвэрлэх"
- ➔ 98 хуудас дээрх "Сканнерын Шил-г цэвэрлэх"
- ➔ 31 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"
- ➔ 41 хуудас дээрх "2-талаар хэвлэх"
- ➔ 18 хуудас дээрх "**Хувилах** Горим"
- ➔ 123 хуудас дээрх "Хэвлэлтийн чанар муу байвал"

Хэвлэсэн тэмдэгт буруу, ташаа байх

- ☐ USB кабелийг принтер болон компьютерт сайтар холбо.
- ☐ Түр зогсоосон бүх хэвлэх ажлыг цуцлах.
- ☐ Хэвлэж байхад компьютерийг **Ичих** эсвэл **Унтах** горимд гар аргаар оруулахгүй байх. Ташаа хэвлэсэн текст бүхий хуудсыг дараагийн удаа компьютероо асаахдаа хэвлэж болно.

Холбогдох мэдээлэл

- ➔ 58 хуудас дээрх "Хэвлэхийг цуцлах"

Хэвлэсэн зураг буруу харах

Принтерийн драйвер эсвэл программ хангамж доторх бүх зургийн толин тохируулгыг арилгах.

- ☐ Windows
Толин Тусгал-г принтерийн драйверийн **Илүү Сонголтууд** таб дээрээс арилгана.
- ☐ Mac OS X
Mirror Image-г хэвлэх харилцах цонхны **Хэвлэх Тохиргоо** цэснээс арилгана.

Хэвлэмэл материалын асуудал шийдэгдэхгүй байх

Та бүх шийдлийг оролдож үзээд асуудлыг шийдэж чадахгүй байвал, принтерийн драйверийг устгаж дараа нь дахин суулгана уу.

Холбогдох мэдээлэл

- ➔ 108 хуудас дээрх "Программ хангамжийг суулгах"
- ➔ 110 хуудас дээрх "Программ хангамжийг устгах"

Хэвлэх бусад асуудал

Хэт удаан хэвлэх

- ☐ Аливаа шаардлагагүй программ хангамжийг хаах.
- ☐ Чанарын тохиргоог багасга. Дээд зэргийн чанартай хэвлэх нь хэвлэх хурдыг удаашруулдаг.
- ☐ Хоёр чиглэлт (эсвэл өндөр хурдны) тохиргоог идэвхжүүлэх. Энэхүү тохиргоог идэвхжүүлсэн үед, принтерийн толгой нь хоёр чиглэлд хөдлөнгөө хэвлэдэг бөгөөд хэвлэх хурд нэмэгддэг.
 - ☐ Windows
Өндөр Хурд-г принтерийн драйверийн **Илүү Сонголтууд** таб дээрээс сонгоно.
 - ☐ Mac OS X
Системийн тохиргоо-г  цэс > **Принтер ба Сканнер** (эсвэл **Хэвлэх ба Скандах, Хэвлэх ба Факсдах**)-г сонгоод, дараа нь принтерийг сонгоно. **Сонголт ба Хангамж** > **Сонголт** (эсвэл **Драйвер**) дээр дарна. **On**-г **High Speed Printing** тохиргоо болгож сонгоно.
- ☐ **Чимээгүй Горим**-ыг идэвхгүй болго.
 - ☐ Windows
Унтраах-г **Чимээгүй Горим** тохиргоо болгож принтерийн драйверийн **Үндсэн** таб дээрээс сонгоно.
 - ☐ Mac OS X
Системийн тохиргоо-г  цэс > **Принтер ба Сканнер** (эсвэл **Хэвлэх ба Скандах, Хэвлэх ба Факсдах**)-г сонгоод, дараа нь принтерийг сонгоно. **Сонголт ба Хангамж** > **Сонголт** (эсвэл **Драйвер**) дээр дарна. **Off**-г **Чимээгүй Горим** тохиргоо болгож сонгоно.

Үргэлжилсэн Хэвлэлтийн Үед Хэвлэлт Удаашрах

Принтерийн механизмийг хэт халах, эвдэрч гэмтэхээс сэргийлж хэвлэлт удааширдаг. Гэвч та үргэлжлүүлэн хэвлэх боломжтой. Эргэж хэвийн хурд руу буцаахын тулд принтерийг дор хаяж 30 минут сул зогсоо. Хэрэв тэжээл унтраалттай бол хэвлэх хурд хэвийн хэмжээндээ буцаж орохгүй.

Сканыг эхлүүлж чадахгүй байна

- ☐ Та ADF-г скандаж буй үед, баримт бичгийн таг, ADF таг хаалттай эсэхийг шалгана.
- ☐ USB кабелийг принтер болон компьютерт сайтар холбо.
- ☐ Хэрэв USB хаб ашиглаж байгаа бол, принтерийг компьютертой шууд холбоод үз.
- ☐ Хэрэв сүлжээгээр сканнердаж болохгүй байвал, *Сүлжээний Заавар*-г үзнэ үү.
- ☐ Хэрэв сүлжээгээр дамжуулан өндөр нарийвчлалтай сканнердвал, холбооны алдаа гарч болзошгүй. Нарийвчлалыг бууруул.
- ☐ EPSON Scan-г асаах үед сканнерын жагсаалт харагдаж байвал та зөв принтер (сканнер)-тай холбосон эсэхийг шалгана.
- ☐ Та ямарваа TWAIN нийцсэн программ хангамжийг ашиглаж байгаа бол, ашиглаж буй принтер (сканнер)-ээ сонгоно уу.

Асуудлыг шийдэх

- ❑ Windows дээр **Сканнер ба Камер** хэсэгт принтер (сканнер) харагдаж байгаа эсэхийг шалгана. Принтер (сканнер) нь "EPSON XXXXX (принтерийн нэр)" гэж харагдах ёстой. Принтер (сканнер) харагдахгүй байвал, түүнийг устгаж EPSON Scan-г дахин суулгана уу. **Сканнер ба Камер**-т хандахын тулд дараахыг мөрдөнө үү.
- ❑ Windows 8.1/Windows 8/Windows Server 2012 R2/Windows Server 2012
Десктоп > Тохиргоо > Хяналтын самбар, -г сонгож, хайлтын талбарт "Сканнер ба Камер" гэж оруулан, **Сканнер ба Камерийг харуулах** дээр дарах ба дараа нь принтер харагдаж байгаа эсэхийг шалгана.
- ❑ Windows 7/Windows Server 2008 R2
Старт товчийг дарж, **Хяналтын самбарыг** сонгон, хайлтын талбарт "Сканнер ба Камер" гэж оруулна. Дараа нь **Сканнер, камерийг харах** дээр дарж, улмаар принтер харагдаж байгаа эсэхийг шалгана.
- ❑ Windows Vista/Windows Server 2008
Старт товч дээр дарж, **Хяналтын самбар > Техник хангамж ба Дуу > Сканнер ба Камер**-г сонгож дараа нь принтер харагдаж байгаа эсэхийг шалгана.
- ❑ Windows XP/Windows Server 2003 R2/Windows Server 2003
Старт товч дээр дарж, **Хяналтын самбар > Принтер ба Бусад техник хангамж > Сканнер ба Камер**-г сонгож дараа нь принтер харагдаж байгаа эсэхийг шалгана.
- ❑ Та TWAIN-тай нийцсэн аливаа программ хангамж ашиглан скандаж чадахгүй байгаа бол, TWAIN-тай нийцсэн программ хангамжийг устгаж дахин суулгана.
- ❑ Intel процессортой Mac OS X, хэрэв EPSON Scan-с бусад Epson сканнер болох Rosetta эсвэл PPC суулгасан байвал, тэдгээрийг болон EPSON Scan-г устгаад дараа нь EPSON Scan-г буцааж суулгана.

Холбогдох мэдээлэл

- ➔ [108 хуудас дээрх "Программ хангамжийг суулгах"](#)
- ➔ [110 хуудас дээрх "Программ хангамжийг устгах"](#)

Хяналтын самбар ашиглаж байхад сканыг асааж чадахгүй байна

- ❑ EPSON Scan ба Epson Event Manager-г зөв суулгасан эсэхийг шалгана.
- ❑ Epson Event Manager дээр хийсэн скандах тохиргоог шалгана.

Холбогдох мэдээлэл

- ➔ [105 хуудас дээрх "Epson Event Manager"](#)

Скандсан зурагны асуудал

Сканнердах Чанар Муу байна

- ❑ сканнерын шил-ийг цэвэрлэ.

Асуудлыг шийдэх

- ☐ ADF-ийг цэвэрлэ.
- ☐ Эхийг сканнерын шил дээр байрлуулах үедээ, эх буюу баримтын таг дээр хэт хүчтэй дарж болохгүй. Эх буюу баримтын тагийг хэт хүчтэй дарсан үед жигд бус өнгө, балархайталт, цэгнүүд харагдаж магадгүй.
- ☐ Эхээс тоосыг арилга.
- ☐ Зохих ёсны баримтын төрлийн тохиргоог хий.
- ☐ Илүү өндөр нарийвчлалаар сканнерд.
- ☐ EPSON Scan-д зургийг тааруулаад сканнерд. Дэлгэрэнгүйг EPSON Scan тусламжаас лавлаарай.

Холбогдох мэдээлэл

- ➔ [98 хуудас дээрх "Сканнерын Шил-г цэвэрлэх"](#)
- ➔ [96 хуудас дээрх "ADF-г цэвэрлэх"](#)

Тэмдэгтүүд тод бус гарах

- ☐ **Home Mode** эсвэл **Office Mode** дээр EPSON Scan, **Image Option Image Adjustments** тохиргооноос сонгох ба, дараа нь **Text Enhancement**-г сонгоно.
- ☐ **Professional Mode**-г EPSON Scan дээрээс **Document**-г **Auto Exposure Type Original** тохиргооноос сонгоно.
- ☐ EPSON Scan дээрх босго тохиргоог тохируулна.
 - ☐ **Home Mode**
Black & White-г **Image Type** болгож сонгоод **Brightness** дээр дарж дараа нь босгыг тохируулна.
 - ☐ **Office Mode** эсвэл **Professional Mode**
Black & White-г **Image Type** тохиргоо болгож сонгоод дараа нь босгыг тохируулна.
- ☐ Өндөр нягтралтайгаар скандана.

Скандсан зураг дээр эх зурагны ар тал харагдах

- ☐ Нимгэн эх хувийн хувьд эх хувийг сканнерын шил дээр тавьж дараа нь түүний дээгүүр хар цаас тавина.
- ☐ Баримтын төрлийн зохих тохиргоог хийнэ.
- ☐ **Home Mode** эсвэл **Office Mode** дээр EPSON Scan, **Image Option Image Adjustments** тохиргооноос сонгох ба, дараа нь **Text Enhancement**-г сонгоно.

Холбогдох мэдээлэл

- ➔ [19 хуудас дээрх "Сканнердах горим"](#)

Скандсан зураг дээр муар (хөндлөн зураас)-н дүрс харагдах

- ☐ Эх хувийг бага зэрэг өөр өнцгөөр тавина.

Асуудлыг шийдэх

- ❑ **Descreening**-г EPSON Scan дээр сонгоно.
- ❑ Нарийвчлалын тохиргоог өөрчил.

Скандах талбай, эсвэл чиглэл буруу байх

- ❑ Эх хувийг сканнерын шил дээр байрлуулах үед эх хувийн буланг сканнерын шил-н хүрээний тэмдгээр харуулсан булантай тааруулна. Скандсан зургийн булан багассан бол, эх хувийг бага зэрэг булангаас холдуулна.
- ❑ сканнерын шил, баримт бичгийг тагийг цэвэрлэнэ. Шилэн дээр тоос, эсвэл толбо байвал, уг тоос эсвэл толбыг агуулахаар скандах талбай томорч болох ба үр дүнд нь скандах буруу байршил, жижиг зургийг гаргана.
- ❑ Тус тусад нь скандахаар боловч нэг файл болгож скандахаар хэд хэдэн эх хувийг сканнерын шил дээр тавих үед, эх хувийг хооронд нь 20 мм (0.8 инч)-с багагүй зайд тусад нь байрлуулна. Асуудал шийдэгдэхгүй байвал, нэг удаад нэг эх хувийг тавина.
- ❑ Сканнердах талбайг зөв тохируул.
- ❑ Хураангуй харагдцыг хураангуй харагдцыг EPSON Scan дээр скандах үед, сканнерын шил-н булангаас эх хувийг 4.5 мм (0.18 инч) холдуулна.
- ❑ **Home Mode** эсвэл **Professional Mode**-г EPSON Scan дээр том хэмжээний эх хувийн хураангуй харагдацыг ашиглах бол, скандах талбай буруу байж болох талтай. EPSON Scan-г урьдчилан харах үед, **Preview** таб дээр **Preview** цонхноос скандахыг хүсэж буй талбайн хүрээг үүсгэж болно.
- ❑ Хэрэв **Auto Photo Orientation** EPSON Scan дээр хүссэнээр ажиллахгүй байвал, EPSON Scan тусламжийг үзнэ үү.
- ❑ **Auto Photo Orientation**-г EPSON Scan дээр арилгана.
- ❑ Нягтралын тохиргоо хэт өндөр байвал, EPSON Scan-р скандах үед скандах боломжтой талбай хязгаарлагдаж болно. Нягтралыг бууруулж, **Preview** цонхон дээрх скандах талбайг тохируулна.

Холбогдох мэдээлэл

- ➔ [34 хуудас дээрх "Эх хувийг байрлуулах"](#)
- ➔ [98 хуудас дээрх "Сканнерын Шил-г цэвэрлэх"](#)

Скандсан зургийн асуудал шийдэгдэхгүй байх

Та бүх шийдлийг оролдож үзээд асуудлыг шийдэж чадахгүй байвал, **Configuration**-г EPSON Scan цонхон дээрээс товшоод **Reset All**-г **Other** таб дээрээс дарж EPSON Scan-н тохиргоог эхлүүлнэ. Дахин эхлүүлэх нь асуудлыг шийдэхгүй бол, EPSON Scan-г устгаж дахин суулгана.

Холбогдох мэдээлэл

- ➔ [108 хуудас дээрх "Программ хангамжийг суулгах"](#)
- ➔ [110 хуудас дээрх "Программ хангамжийг устгах"](#)

Скандах бусад асуудал

Хураангуй урьдчилан харах функц зөв ажиллахгүй байна

EPSON Scan-н тусламжийг үз.

Холбогдох мэдээлэл

➔ [105 хуудас дээрх "EPSON Scan \(Сканнерийн драйвер\)"](#)

Хэт удаан скандаж байна

Нягтралыг бууруулна.

PDF/Multi-TIFF руу скандах үед скандах ажиллагаа зогсоод байна

- ☐ EPSON Scan-г ашиглаж скандах үед, та PDF форматаар 999 хуудас, Multi-TIFF форматаар 200 хүртэл хуудсыг скандах боломжтой. Хяналтын самбарыг ашиглаж скандах үед, та PDF болон Multi-TIFF форматаар 50 хүртэл хуудсыг скандах боломжтой.
- ☐ Том хэмжээний мэдээлэл скандах үед, саарал дүрсээр скандахыг бид санал болгож байна.
- ☐ Компьютерийн хатуу дискэн дээрх сул зайг нэмэгдүүлнэ. Хангалттай сул зай байхгүй бол скандах ажиллагаа зогсож болно.
- ☐ Бага нягтралтайгаар скандах гэж оролдоно уу. Нийт мэдээллийн хэмжээ хязгаартаа хүрсэн бол скандах ажиллагаа зогсоно.

Холбогдох мэдээлэл

➔ [19 хуудас дээрх "Сканнердах горим"](#)

Факс илгээх, хүлээн авахад үүсэх асуудлууд

Факс илгээж, хүлээн авч чадахгүй байна

- ☐ Автомат факсын холболтын шалгалтыг явуулахын тулд хяналтын самбар дээрх **Факсын Холболтыг шалгах**-г шалгана. Тайлан дээр хэвлэгдсэн шийдлийг оролдоод үзнэ.
- ☐ **Шугамын Төрөл** тохиргоог шалгана. **PBX**-д зориулан үүнийг тохируулснаар асуудлыг шийдвэрлэж болно. Таны утасны систем гадны шугам руу нэвтрэхийн тулд гадаад нэвтрэх код шаарддаг бол, нэвтрэх кодыг принтерт бүртгэж, илгээх үедээ факсын дугаарын өмнө # (чагт)-г оруулна уу.
- ☐ Холболтын алдаа гарвал, хяналтын самбар дээрх **Факсын Хурд**-д зориулсан **Удаан(9,600bps)** тохиргоог өөрчилнө.

Асуудлыг шийдэх

- ❑ Утсыг ханын үүрэнд холбож шалгаснаар утасны ханын үүр ажиллаж байгаа эсэхийг шалгана. Та дуудлага хийх, хүлээж авч чадахгүй байвал, харилцаа холбооны компанитайгаа холбоо барина уу.
- ❑ DSL утасны шугамыг холбохын тулд, та дотор нь суурилуулсан DSL фильтрээр тоноглогдсон DSL модемийг ашиглах хэрэгтэй болно, эсвэл утасны шугамд салангид DSL фильтртийг суурилуулна. DSL үйлчилгээ үзүүлэгчтэйгээ холбоо барина.
- ❑ Та DSL утасны шугамтай холбогдож байвал, принтерээс факс илгээж болох эсэхийг шалгахын тулд утасны ханын үүртэй принтерээ шууд холбоно. Хэрэв энэ ажиллаж байвал, асуудал DSL-н фильтртэй холбоотой байж болно. DSL үйлчилгээ үзүүлэгчтэйгээ холбоо барина.
- ❑ Хяналтын самбар дээрх **ЕСМ** тохиргоог идэвхжүүлнэ. ЕСМ унтарсан үед өнгөт факс илгээж эсвэл хүлээж авч болохгүй байна.
- ❑ Компьютер ашиглан факс илгээж хүлээн авахын тулд, принтер нь USB кабель утас эсвэл сүлжээтэй холбогдсон эсэх болон принтерийн драйвер болон PC-FAX драйверийг компьютерт суулгасан эсэхийг шалгана. PC-FAX драйверийг FAX Utility-н хамт суулгадаг.
- ❑ Windows дээр, принтер (факс) нь **Төхөөрөмж ба Принтер, Принтер, эсвэл Принтер ба бусад техник хангамж** дээр харагдаж байгаа эсэхийг шалгана. Принтер (факс) "EPSON XXXXX (FAX)" гэж харагдана. Принтер (факс) харагдахгүй байвал, FAX Utility-г устгаж дахин суулгана. **Төхөөрөмж ба Принтер, Принтер, эсвэл Принтер ба Бусад техник хангамж**-д нэвтрэхийн тулд дараахыг шалгана.
- ❑ Windows 8.1/Windows 8
Десктоп > Тохиргоо > Хяналтын самбар > Төхөөрөмж ба принтер харах Техник хангамж ба Дуу эсвэл **Техник хангамж** дээр сонгоно.
- ❑ Windows 7
 Старт товч дээр дарж, дараа нь **Хяналтын самбар > Төхөөрөмж ба принтерийг харах Техник хангамж ба Дуу** эсвэл **Техник хангамж** дээр сонгоно.
- ❑ Windows Vista
 Старт товч дээр дарж, **Хяналтын самбар > Принтер-г Техник хангамж ба дуу** дээрээс сонгоно.
- ❑ Windows XP
 Старт товч дээр дарж, **Хяналтын самбар > Принтер ба бусад Техник хангамж > Принтер ба Факс**-г сонгоно.
- ❑ Mac OS X дээр, дараахыг шалгана.
 - ❑ **Системийн тохиргоо**-г  цэс > **Принтер ба Сканнер** (эсвэл **Хэвлэх ба Скандах, Хэвлэх ба Факсдах**)-г сонгоод, дараа нь принтерийг сонгоно. Принтер (факс) "FAX XXXX (USB)" эсвэл "FAX XXXX (IP)" гэж харагдана. Принтер (факс) харагдахгүй байвал, + дараад принтерийг (факс) бүртгүүлнэ.
 - ❑ **Системийн тохиргоо**-г  цэснээс сонгоод **Принтер ба Сканнер** (эсвэл **Хэвлэх ба Скандах, Хэвлэх ба Факсдах**)-г сонгоод, дараа нь принтерийг (факс) 2 товшино. Принтерийг түр зогсоосон бол, **Буцаан асаах** (эсвэл Принтерийг буцаан асаах) дээр дарна.

Холбогдох мэдээлэл

- ➔ 25 хуудас дээрх **"Факсын Тохиргоо"**
- ➔ 74 хуудас дээрх **"РВХ утасны системийн тохиргоог хийх"**
- ➔ 69 хуудас дээрх **"Принтерийг утасны шугамтай холбох"**
- ➔ 108 хуудас дээрх **"Программ хангамжийг суулгах"**

Асуудлыг шийдэх

➔ 110 хуудас дээрх "Программ хангамжийг устгах"

Факс илгээж чадахгүй байна

- ☐ Гадагш явуулж буй факсан дээр албан бичгийг толгойн мэдээллийг хяналтын самбар дээр тохируулна. Албан бичгийг толгойн мэдээлэлгүй ирж буй факсыг зарим факс машин автоматаар хүлээж авдаггүй.
- ☐ Та өөрийн дуудлага ирүүлэгчийг ID-г хориглосон бол, уг хоригийг арилгана. Зарим утас эсвэл факсын машин үл мэдэгдэх дуудлагыг автоматаар хориглодог.
- ☐ Факсын дугаар зөв эсэх, хүлээн авагчийн факс машин факс хүлээн авахад бэлэн эсэхийг хүлээн авагчаас асууна.

Холбогдох мэдээлэл

➔ 25 хуудас дээрх "Факсын Тохиргоо"

➔ 132 хуудас дээрх "Факс илгээж, хүлээн авч чадахгүй байна"

Тухайн хүлээн авагч руу факс илгээж чадахгүй байна

Алдаанаас улмаас тухайн хэрэглэгч рүү факс илгээж чадахгүй байвал дараахыг шалгана уу.

- ☐ Принтер дуудлага хийж дууссанаас хойш 50 секундын дотор хүлээн авагч машин таны дуудлагыг авахгүй бол, дуудлага алдаатай дуусах болно. Факсын дохиог сонсохоос өмнө хэр удахыг шалгахын тулд холбогдсон утсыг ашиглаж дуудлага явуулна. 50 секундээс удаан хүлээвэл, факсын дугаарын ард паузыг нэмж факс илгээнэ. Пауз оруулахын тулд  дээр дарна. Паузын тэмдэг болж зураас орно. Нэг пауз нь 3 секунд орчим байдаг. Шаардлагатай бол хэд хэдэн пауз нэмнэ.
- ☐ Харилцах жагсаалтаас хүлээн авагчийг сонгосон бол, бүртгүүлсэн мэдээлэл зөв эсэхийг шалгана. Мэдээлэл зөв байвал, харилцах жагсаалтаас хүлээн авагчийг сонгож, ► товч дээр дарж, дараа нь **Засварлах**-г сонгоно. **Оролт Нэмэх** дэлгэц дээр **Факсын Хүрд**-г **Удаан(9,600bps)** болгож өөрчилнө.

Холбогдох мэдээлэл

➔ 77 хуудас дээрх "Утасны гадаад төхөөрөмжөөс факсад дуудлага илгээх"

➔ 75 хуудас дээрх "Факсдах харилцах хаягийг бүртгүүлэх"

➔ 132 хуудас дээрх "Факс илгээж, хүлээн авч чадахгүй байна"

Факсыг тогтоосон цагт илгээж чадахгүй байна

Хяналтын самбар дээр огноо, цагийг зөв тохируулах.

Холбогдох мэдээлэл

➔ 78 хуудас дээрх "Факсыг тогтоосон цагт илгээх (Факсыг Дараа Илгээх)"

➔ 21 хуудас дээрх "Тохируулга Горим"

Асуудлыг шийдэх

Факс хүлээж авахгүй байна

- ☐ Та дуудлага шилжүүлэх үйлчилгээнд бүртгүүлсэн бол, принтер факс хүлээн авах боломжгүй байж магадгүй. Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоо барина уу.
- ☐ Хэрэв принтерт телефон утас холбоогүй бол, **Хүлээн авах Горим** тохиргоог хянах самбар дээрх **Автомат** руу шилжүүлнэ.

Холбогдох мэдээлэл

- ➔ 79 хуудас дээрх "Хүлээн авах горимыг тохируулах"
- ➔ 132 хуудас дээрх "Факс илгээж, хүлээн авч чадахгүй байна"

Санах ой дүүрсэн алдаа заав

- ☐ Хэрэв хүлээн авсан факсыг компьютер дээр хадгалахаар принтерийг тохируулсан бол, факс хадгалахаар тохируулсан компьютерийг асаана. Факсыг компьютер дээр хадгалсны дараа, принтерийн санах ойгоос тэдгээрийг устгана.
- ☐ Хэдийгээр санах ой дүүрсэн ч, та **Шууд Илгээх** тохиргоог ашиглаж монохромт факс илгээх боломжтой. Эсвэл эх хувиа хоёр болон түүнээс дээш хэсэгт хувааж хэд хэдээр нь илгээнэ.
- ☐ Принтер нь цаас бөглөрөх зэрэг принтерийн алдаанаас болоод хүлээн авсан факсыг хэвлэж чадахгүй байвал, санах ой дүүрэх алдаа гарч болно. Принтерийн асуудлыг шийдэж, дараа нь илгээгчтэй холбоо барин, факсаа дахин явуулахыг хүснэ.

Холбогдох мэдээлэл

- ➔ 82 хуудас дээрх "Хүлээн авсан факсыг компьютерт хадгалах"
- ➔ 20 хуудас дээрх "Факсдах горим"
- ➔ 114 хуудас дээрх "Бөглөрсөн цаасыг салгах"

Илгээсэн факсын чанар муу байна

- ☐ сканнерын шил, баримт бичгийг тагийг цэвэрлэнэ.
- ☐ ADF-н бортогыг цэвэрлэнэ.
- ☐ Хяналтын самбар дээрх **Нарийвчлал** тохиргоог өөрчилнө. Таны эх хувьд текст ба фото зурган мэдээлэл агуулагдаж буй бол **Фото**-г сонгоно.
- ☐ Хяналтын самбар дээрх **Нягтшил** тохиргоог өөрчилнө.
- ☐ Хяналтын самбар дээрх **ЕСМ** тохиргоог идэвхжүүлнэ.

Холбогдох мэдээлэл

- ➔ 98 хуудас дээрх "Сканнерын Шил-г цэвэрлэх"
- ➔ 96 хуудас дээрх "ADF-г цэвэрлэх"
- ➔ 20 хуудас дээрх "Факсдах горим"
- ➔ 25 хуудас дээрх "Факсын Тохиргоо"

Факсыг буруу хэмжээтэй илгээж байна

- ☐ сканнерын шил-г ашиглаж факс илгээх үедээ, эх хувийн тэмдэгтэй эх хувийг таарахаар байрлуулна.
- ☐ сканнерын шил, баримт бичгийг тагийг цэвэрлэнэ. Шилэн дээр тоос, эсвэл толбо байвал, уг тоос эсвэл толбыг агуулахаар скандах талбай томорч болох ба үр дүнд нь скандах буруу байршил, жижиг зургийг гаргана.

Холбогдох мэдээлэл

- ➔ [34 хуудас дээрх "Эх хувийг байрлуулах"](#)
- ➔ [98 хуудас дээрх "Сканнерын Шил-г цэвэрлэх"](#)

Хүлээж авсан факсын чанар муу байна

- ☐ Хяналтын самбар дээрх **ЕСМ** тохиргоог идэвхжүүлнэ.
- ☐ Илгээгчтэй холбоо барьж, тэднээс дээд чанарын горимыг илгээхийг хүснэ.
- ☐ Хүлээн авсан факсыг дахин хэвлэнэ.

Холбогдох мэдээлэл

- ➔ [25 хуудас дээрх "Факсын Тохиргоо"](#)
- ➔ [84 хуудас дээрх "Хүлээн авсан факсыг дахин хэвлэх"](#)

Хүлээн авсан факсыг хэвлэхгүй байх

Принтерт цаас бөглөрөх зэрэг алдаа гарвал, хүлээн авсан факсыг хэвлэж чадахгүй. Принтерийг шалгана.

Холбогдох мэдээлэл

- ➔ [114 хуудас дээрх "Бөглөрсөн цаасыг салгах"](#)

Факсдах бусад асуудал

Сүлжээнд холбогдсон утаснаас дуудлага хийж болохгүй байна

Принтер дээрх EXT. порт руу утсыг холбож дараа нь хүлээн авагчийг авна. Та хүлээн авагчаар дамжуулж дуудах дууг сонсож чадахгүй бол, утасны кабель утсыг зөв холбоно.

Холбогдох мэдээлэл

- ➔ [71 хуудас дээрх "Утасны төхөөрөмжийг принтертэй холбох"](#)

Хариулагч машин дуут дуудлагад хариу өгөхгүй байна

Хяналтын самбар дээр, принтерийн **Хариулах Дохио өгөх** тохиргоог хариулагч машины дуудлагын тооноос их тоогоор тохируулна.

Холбогдох мэдээлэл

- ➔ 25 хуудас дээрх **"Факсын Тохиргоо"**
- ➔ 80 хуудас дээрх **"Хариулагч машины тохиргоо"**

Илгээгчийн факсын дугаар хүлээн авсан факс дээр харагдахгүй байна, эсвэл дугаар нь буруу байна.

Илгээгч факсын толгойн мэдээллийг тохируулаагүй ба үүнийг буруу тохируулсан байж болно. Илгээгчтэй холбогд.

Бусад асуудал

Принтерт хүрэхэд бага зэргийн тог цохиж байна

Компьютерт олон тооны дагалдах хэрэгсэл холбосон үед, принтерт хүрэх үед та бага зэргийн тог цохилт мэдэрч болно. Принтерт холбогдсон компьютерт газардуулагч утас суулгана уу.

Ажиллагаа чанга дуутай байвал

Хэрэв ажиллагааны дуу хэт чанга байвал, **Чимээгүй Горим**-ыг идэвхижүүл. Энэ үзүүлэлтийг идэвхижүүлэх нь хэвлэх хурдыг удаашруулж магадгүй.

- ☐ Windows принтерийн драйвер

Асаах-г **Чимээгүй Горим** тохиргоо болгож **Үндсэн** таб дээрээс сонгоно.

- ☐ Mac OS X принтерийн драйвер

Системийн Тохируулгууд-ыг  цэс > **Принтер & Сканнер** (эсвэл **Хэвлэх & Сканнердах, Хэвлэх & Факсдах**)-аас сонгоод, дараа нь принтерийг сонго. **Сонголт & Хангамж** > **Сонголт** (эсвэл **Драйвер**) дээр дар. **Он**-г **Чимээгүй Горим**-д сонго.

- ☐ EPSON Scan

Configuration-г дараад, **Quiet Mode**-г **Other** цэсэн дээр тохируул.

ADF ажиллахгүй

сканнерын шил-н зүүн урд талын нүхэнд тоос орсон байж болно. Бүх тоос шороог цэвэрлэнэ.

ADF сканнердалт удаашрах

ADF ашиглан таван минутаас дээш хугацаагаар тасралтгүй сканнердах тохиолдолд, сканнерын механизмийг хэт халж эвдрэл үүсэхээс сэргийлж сканнердалт удаашрах болно. Гэсэн хэдий ч, та үргэлжлүүлэн сканнердаж болно. Хэвийн сканнердах хурдад буцаж очихын тулд, ADF-ийг дор хаяж 30 минут сул зогсоох шаардлагатай. Тэжээлийг салгасан ч сканнердах хурд хэвэндээ орохгүй болно.

Огноо, цаг буруу байна.

Хяналтын самбар дээр огноо, цагийг зөв тохируулах. Аянга цахилгааны цохилтоос болж эрчим хүч тасалдах, урт хугацааны турш эрчим хүч тасарсан бол, цаг буруу явах болно.

Холбогдох мэдээлэл

➔ 21 хуудас дээрх ["Тохируулга Горим"](#)

Программ хангамжийг Firewall хаах (Windows-т зөвхөн)

Программ хангамжийн Windows Галт ханын зөвшөөрөлтэй аюулгүй байдлын программд нэмж **Хяналтын самбар дээр** тохируулна.

Бэхний түвшинг дахин тохируулахыг сануулсан зурвас гарч ирвэл

Бүх эсвэл тодорхой зарим бэхний савнуудыг дүүргээд, дүүргэсэн өнгөө LCD дэлгэц дээр сонгосны дараа,  товч дээр дарж бэхний түвшинг дахин тохируулна.

Ашиглалтын нөхцлөөс хамаарч, саван дотор бэх байхад ч энэхүү зурвас гарч ирж болно.

Хэрэв бэхний савны талаас их бэх үлдсэн байхад энэ зурвас гарч ирсэн бол, принтер алдаатай ажиллаж байж болзошгүй. Epson тусламжтай холбогдоорой.

Холбогдох мэдээлэл

➔ 87 хуудас дээрх ["Бэхний савыг дахин дүүргэх"](#)

Хавсралт

Техникийн тодорхойлолт

Принтерийн үзүүлэлт


Принтерийн толгойд цорго суурилуулах		Хар бэхний хошуу: 400 Өнгөт бэхний хошуу: 128 өнгө бүрт
Цаасны жин*	Ердийн цаас	64 – 90 гр/м ² (17 – 24 фунт)
	Дугтуйнууд	Дугтуй #10, DL, C6: 75 – 90 г/м ² (20 – 24 фунт)

* Цаасны зузаан энэ хүрээнд байсан ч гэсэн цаасыг принтерт татахгүй эсвэл хэвлэлтийн чанар цаасны үзүүлэлт болон чанараас хамаарч буурч болзошгүй.


Хэвлэх талбай

Принтерийн механизмаас шалтгаалж сүүдэртэй талбай дээр хэвлэлийн чанар муудаж болно.

Дан хуудаснууд (ердийн хэвлэх)

	A	3.0 мм (0.12 инч)
	B	3.0 мм (0.12 инч)
	C	47.0 мм (1.85 инч)
	D	45.0 мм (1.77 инч)

Дугтуй

	A	3.0 мм (0.12 инч)
	B	5.0 мм (0.20 инч)
	C	47.0 мм (1.85 инч)
	D	18.0 мм (0.71 инч)

Сканнерийн Үзүүлэлтүүд

Сканнерийн Төрөл	Хавтгай суурьтай
------------------	------------------

Хавсралт

Фотоэлектрик Төхөөрөмж	CIS
Хүчинтэй Пиксель	10200×14040 пиксель (1200 dpi)
Баримтын Дээд Хэмжээ	216×297 мм (8.5×11.7 инч) A4, Letter
Сканнердах Нарийвчлал	1200 dpi (үндсэн скан) 2400 dpi (дэд скан)
Гаралтын Нарийвчлал	50-аас 4800, 7200, 9600 dpi (1 dpi алхамаар 50-аас 4800 dpi)
Өнгөний Гүн	Өнгө ☐ дотоод 48 бит/пиксель (дотоод өнгө бүрт 16 бит/пиксель) ☐ гадаад 24 бит/пиксель (гадаад өнгө бүрт 8 бит/пиксель) Грейскейл ☐ дотоод 16 бит/пиксель ☐ гадаад 8 бит/пиксель Хар, цагаан ☐ дотоод 16 бит/пиксель ☐ гадаад 1 бит/пиксель
Гэрлийн Эх үүсвэр	LED

Интерфэйсийн үзүүлэлт

Компьютерийн хувь	Өндөр хурдны USB
-------------------	------------------

Факсын үзүүлэлт

Факсын төрөл	Хар цагаан болон өнгөт факсын хүчин чадлыг нэмэгдүүлэх (ITU-T Супер Групп 3)
Дэмждэг шугамууд	Стандарт аналог телефон утасны шугам болон PBX (Хувийн салбарын солилцоо) телефоны систем
Хурд	33.6 kbps хүртэл
Нягтрал	Монохром ☐ Стандарт: 8 пел/мм×3.85 шугам/мм (203 пел/инч×98 шугам/инч) ☐ Нарийн: 8 пел/мм×7.7 шугам/мм (203 пел/инч×196 шугам/инч) ☐ Фото: 8 пел/мм×7.7 шугам/мм (203 пел/инч×196 шугам/инч) Өнгө ☐ Нарийн: 200×200 dpi ☐ Фото: 200×200 dpi

Хавсралт

Цаасны санах ой	100 хуудас хүртэл (ITU-T №1 хүснэгтийг монохромт төслийн горимоор хүлээн авах үед)
Дахин залгах*	2 удаа (1 минутын зайтайгаар)
Интерфэйс	RJ-11 утасны шугам, RJ-11 утасны иж бүрдлийн холболт

* Техникийн үзүүлэлт улс орон болон бүс нутаг бүрт өөр өөр байна.

Wi-Fi үзүүлэлт

Стандарт	IEEE802.11b/g/n ^{*1}
Үелзлийн хүрээ	2.4 ГГц
Хамгийн дээд радио давтамжийн цахилгаан дамжсан	19.8 dBm (EIRP)
Зохицуулах горим	Дэд бүтцийн, Ад хок ^{*2} , Wi-Fi Direct ^{*3 *4}
Утасгүй сүлжээний аюулгүй байдал	WEP (64/128bit), WPA2-PSK (AES) ^{*5}

*1 Худалдан авалтын байршлаас хамааран IEEE 802.11b/g/n юмуу IEEE 802.11b/g-г мөрдлөгө болгоно.

*2 IEEE 802.11n дэмжихгүй.

*3 IEEE 802.11b дэмжихгүй.

*4 Энгийн AP горим нь Wi-Fi холболт (дэд бүтэц) эсвэл Этернэт холболттой нийцэлтэй. Дэлгэрэнгүй мэдээллийг *Сүлжээний Заавар*-с үзнэ үү.

*5 Хувийн WPA/WPA2-г дэмжих WPA2 стандартуудыг хангана.

Ethernet үзүүлэлт

Стандарт	IEEE802.3i (10BASE-T) ^{*1} IEEE802.3u (100BASE-TX) IEEE802.3az (Эрчим хүчний хэмнэлттэй Ethernet) ^{*2}
Харилцах горим	Автомат, 10Mbps бүрэн дуплекс, 10Mbps хагас дуплекс, 100Mbps бүрэн дуплекс, 100Mbps хагас дуплекс
Холбогч	RJ-45

*1 Радио холбооны саатлаас сэргийлэхийн тулд 5е ангилал эсвэл өндөр түвшний STP (хамгаалалттай эрчилсэн хос шугам) кабель утсыг ашиглана.

*2 Холбогдсон төхөөрөмж IEEE802.3az стандартыг дагаж ажиллана.

Аюулгүй байдлын протокол

SSL/TLS	HTTPS сервер/клиент, IPPS
---------	---------------------------

Хавсралт

Дэмждэг гуравдагч талын үйлчилгээ

AirPrint	Хэвлэх	iOS 5 эсвэл дараа гарсан хувилбар/Mac OS X v10.7.x эсвэл дараа гарсан хувилбар
	Скан	Mac OS X v10.9.x эсвэл түүнээс хойших
	Факс	Mac OS X v10.8.x эсвэл түүнээс хойших
Google Cloud Print		

Хэмжээс

Хэмжээс	Хадгалах ☐ Өргөн: 515 мм (20.3 инч) ☐ Зузаан: 360 мм (14.2 инч) ☐ Өндөр: 241 мм (9.5 инч) Хэвлэх ☐ Өргөн: 515 мм (20.3 инч) ☐ Зузаан: 559 мм (22.0 инч) ☐ Өндөр: 241 мм (9.5 инч)
Жин*	Ойролцоогоор 7.4 кг (16.3 фунт)

* Бэх, цахилгаан утасгүйгээр.

Цахилгааны Үзүүлэлтүүд


Загвар	100 – 240 В Загвар	220 – 240 В Загвар
Нэрлэсэн Давтамжийн Хамрах Хүрээ	50 – 60 Гц	50 – 60 Гц
Нэрлэсэн Гүйдэл	0.5-аас 0.3 А	0.3 А
Эрчим хүчний зарцуулалт (USB холболттой)	Дангаар хуулбарлах: Ойролцоогоор 11.0 W (ISO/ IEC24712) Бэлтгэх горим: Ойролцоогоор 4.4 W Унтах горим: Ойролцоогоор 1.5 W Тэжээл унтраах: Ойролцоогоор 0.3 W	Дангаар хуулбарлах: Ойролцоогоор 11.0 W (ISO/ IEC24712) Бэлтгэх горим: Ойролцоогоор 4.4 W Унтах горим: Ойролцоогоор 1.5 W Тэжээл унтраах: Ойролцоогоор 0.3 W

Хавсралт

Тэмдэглэл:

- ❑ Принтер дээрх шошгоноос хүчдэлийг шалгана уу.
- ❑ Европын хэрэглэгчид эрчим хүчний зарцуулалтын талаар дэлгэрэнгүйг дараах Вэбсайтаас үзнэ үү.
<http://www.epson.eu/energy-consumption>
- ❑ Бельгийн хэрэглэгчидийн хувьд, хувилах үеийн эрчим хүчний зарцуулалт ялгаатай байж магадгүй.
Сүүлийн үеийн үзүүлэлтийг <http://www.epson.be>-с үзнэ үү.

Орчны үзүүлэлт

Үйл ажиллагаа	Доорх графикт харуулсан хүрээнд доторх принтерийг ашиглана.  Температур: 10 – 35°C (50 – 95°F) Чийгшил: 20 – 80% RH (конденсацигүйгээр)
Хадгалах	Температур: -20 – 40°C (-4 – 104°F)* Чийгшил: 5 – 85% RH (конденсацигүйгээр)

* Та 40°C (104°F) -т нэг сарын турш хадгалах боломжтой.

Бэхний хайрцгийн байгаль орчны үзүүлэлт

Хадгалах температур	-20-с 40 °C (-4-с 104 °F)*
Хөлдөх температур	-15 °C (5 °F) Бэх царцах бөгөөд 25 °C (77 °F) дээр 2 цаг байлгасны дараа ашиглах боломжтой болно.

* Та 40 °C (104 °F) дээр нэг сарын турш хадгалах боломжтой.

Системийн шаардлага

- ❑ Windows 8.1 (32-bit, 64-bit)/Windows 8 (32-bit, 64-bit)/Windows 7 (32-bit, 64-bit)/Windows Vista (32-bit, 64-bit)/Windows XP Professional x64 Edition/Windows XP (32-bit)/Windows Server 2012 R2/Windows Server 2012/Windows Server 2008 R2/Windows Server 2008 (32-bit, 64-bit)/Windows Server 2003 R2 (32-bit, 64-bit)/Windows Server 2003 (32-bit, 64-bit)
- ❑ Mac OS X v10.10.x/Mac OS X v10.9.x/Mac OS X v10.8.x/Mac OS X v10.7.x/Mac OS X v10.6.8

Тэмдэглэл:

- ❑ Mac OS X нь зарим програм хангамж, тохиргоог дэмжихгүй байж магадгүй.
- ❑ Mac OS X-д зориулсан UNIX Файлын систем (UFS) нь дэмжигдэхгүй.

Хууль журмын мэдээлэл

Стандарт ба зөвшөөрөл

Америк загварын стандарт болон зөвшөөрөл

Аюулгүй байдал	UL60950-1 CAN/CSA-C22.2 No.60950-1
EMC	FCC Part 15 Subpart B Class B CAN/CSA-CEI/IEC CISPR 22 Class B

Энэхүү тоног төхөөрөмж нь дараах утасгүй модулийг агуулсан.

Үйлдвэрлэгч: Askey Computer Corporation

Төрөл: WLU6320-D69 (RoHS)

Энэхүү бүтээгдэхүүн нь FCC Дүрмийн Хэсэг 15 болон IC дүрмийн RSS-210 шаардлагыг хангасан. Бүтээгдэхүүнд санал болгоогүй өөрчлөлт шинэчлэлийг хийснээс үүдэн хамгаалалтын шаардлагыг хангахгүй болсон аливаа тохиолдлын хариуцлагыг Epson хүлээхгүй болно. Ажиллагаа нь дараах хоёр нөхцлүүдэдтэй. Үүнд: (1) энэхүү төхөөрөмж нь хор уршигтай интерференц үүсгэхгүй (2) энэхүү төхөөрөмж нь, төхөөрөмжийн ажиллагаанд сөргөөр нөлөөлөх интерференцийг оруулан хүлээн авсан бүх интерференцийг өөртөө шингээнэ.

Лицензлэгдсэн үйлчилгээнд радио интерференц үүсгэхээс сэргийлэхийн тулд, энэхүү төхөөрөмж нь тасалтгаан дотор, цонхноос хол байрлалд дээд зэргийн хамгаалалтыг бүрдүүлэн ажиллах шаардлагатай. Гадаа суурилуулсан тоног төхөөрөмж (буюу дамжуулах антенна) нь аливаа лицензийг зөрчиж байж болзошгүй.

Энэхүү төхөөрөмж нь хяналтгүй байгаль орчинд заасан FCC/IC цацрагийн ялгаралтын хязгаарыг дагаж мөрдөн, FCC радио давтамж (RF) хавсралт С ялгаралтын зааварчилгаанаас IC радио давтамжийн (RF) ялгаралтын дүрмийн OET65 болон RSS-102 шаардлагыг хангасан. Энэхүү төхөөрөмжийг халаагч нь хүний биеэс (гар, бугуй, хөл, шагай) 7.9 инч (20 см) юмуу түүнээс хол байхаар суурилуулж ажиллуулах ёстой.

Европ загварын стандарт болон зөвшөөрөл

Европын хэрэглэгчдэд

Seiko Epson корпорац дараах радио техник төхөөрөмжийг 2014/53/EU-н заалтад нийцүүлсэн гэдгээ мэдэгдэж байна. ЕХ-ны заалтад нийцүүлсэн тухай мэдэгдлийг дараах сайтаас авах боломжтой.

<http://www.epson.eu/conformity>

C531C

Зөвхөн Ирланд, Их Британи, Австри, Герман, Лихтенштейн, Швейцари, Франц, Бельги, Люксембург, Нидерланд, Итали, Португал, Испани, Дани, Финлянд, Норвеги, Швед, Исланд, Хорват, Кипр, Грек, Словени, Мальт, Болгар, Чех, Эстони, Унгар, Латви, Литва, Польш, Румын, Словак улсад ашиглахад зориулав.

Хавсралт

Бүтээгдэхүүнүүдэд санал болгоогүй өөрчлөлт шинэчлэлийг хийснээс үүдэн хамгаалалтын шаардлагыг хангахгүй болсон аливаа тохиолдлын хариуцлагыг Epson хүлээхгүй болно.

**Австралийн загварын стандарт ба зөвшөөрөл**

EMC	AS/NZS CISPR22 Class B
-----	------------------------

Дараах тоног төхөөрөмжийн загвар AS/NZS4268-н үндсэн шаардлага болон бусад холбогдох шаардлагыг хангасан гэдгийг Epson энд баталгаажуулж байна:

C531C

Бүтээгдэхүүнүүдэд санал болгоогүй өөрчлөлт шинэчлэлийг хийснээс үүдэн хамгаалалтын шаардлагыг хангахгүй болсон аливаа тохиолдлын хариуцлагыг Epson хүлээхгүй болно.

Хуулбарлахад тавигдах хязгаарлалт

Принтерийг хариуцлагатай, хуулийн дагуу хэрэглүүлэхийн тулд дараах хязгаарлалтыг тавьж байна.

Дараах зүйлсийг хуулбарлахыг хуулийн дагуу хориглож байна:

- ☐ Мөнгөн тэмдэгт, зоос, засгийн газрын хэвлэсэн, зах зээлд гаргах үнэт цаас, засгийн газрын бондын үнэт цаас болон хотоос гаргасан үнэт цаас
- ☐ Хүчинтэй шуудангийн тэмдэг бүхий ашиглаагүй шуудангийн марк, урьдчилан тамгалсан шуудангийн карт, бусад шуудангийн зүйлс
- ☐ Засгийн газрын хуулийн дагуу хэвлэсэн орлогын тэмдэг, болон үнэт цаас

Дараах зүйлсийг хуулбарлах үед тавих анхаарал:

- ☐ Зах зээлд худалдах хувийн үнэт цаас (хувьцааны гэрчилгээ, харилцан тохиролцсон тэмдэг, чек гэх мэт), сарын хураамж, концессийн тасалбар гэх мэт.
- ☐ Паспорт, жолоочийн үнэмлэх, зохистой байдлын баталгаа, зам нэвтрэх, хүнсний зүйл, тасалбар гэх мэт.

Тэмдэглэл:

Эдгээр зүйлсийг хуулбарлахыг мөн хуулиар хориглосон.

Зохиогчийн эрхтэй баримт бичгийг хариуцлагатай ашиглах:

Зохиогчийн эрхтэй баримт бичгийг зүй бусаар хуулбарлаж принтерийг зохистой бусаар ашиглах аюул бий. Мэдлэг туршлагатай хуульчийн зөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулахгүй бол, хэвлэгдсэн баримт бичгийг хуулбарлахаас өмнө зохиогчийн эрх эзэмшигчээс зөвшөөрөл авч хариуцлагаа хүлээн хүндэтгэлтэй хандана уу.

Принтерээр дамжиж буй хуудасны нийт тоог шалгах

Принтерээр дамжиж буй хуудасны нийт тоог та шалгах боломжтой.

Принтерээр дамжиж буй хуудасны нийт тоог шалгах — Хяналтын самбар

Цорго шалгах дүрстэй хамт тус мэдээлэл хэвлэгдэнэ.

1. А4 хэмжээтэй ердийн цаасыг принтер дээр ачаална.
2. Үндсэн дэлгэцнээс **Тохируулга**-г оруулна уу.
3. **Арчилгаа > Хэвлэх Толгой Хошуу Шалгах** сонгоно.
4. Цорго шалгах дүрсийг хэвлэхийн тулд дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Принтерээр дамжиж буй хуудасны нийт тоог шалгах — Windows

1. Принтерийн драйверийн цонхонд хандана.
2. **Принтер болон Сонголтын Мэдээлэл**-г **Арчилгаа** таб дээрээс дарна.

Принтерээс гарсан нийт хуудасны тоог шалгах — Mac OS X

1. **Системийн тохиргоо**-г  цэс > **Принтер ба Сканнер** (эсвэл **Хэвлэх ба Скандах, Хэвлэх ба Факсдах**)-г сонгоод, дараа нь принтерийг сонгоно.
2. **Сонголт ба Хангамж > Хэрэгсэл > Принтерийн хэрэгслийг нээх** дээр дарна.
3. **Printer and Option Information** дээр дарна.

Эрчим хүч хэмнэх

Хэсэг хугацааны турш ямарваа ажиллагаа явагдаагүй бол принтер унтах горимд орж автоматаар унтарна. Эрчим хүчний менежмент хийгдэхээс өмнө та цагийг тохируулж болно. Ямарваа нэмэгдэл принтерийн эрчим хүчний үр ашигт байдалд нөлөөлнө. Ямарваа өөрчлөлт хийхээс өмнө байгаль орчинд анхаарал тавина уу.

Эрчим хүч хэмнэх - Хянах самбар

1. Нүүр дэлгэцнээс **Тохируулга**-д нэвтэрнэ.
2. **Түгээмэл Тохиргоонууд**-ийг сонгоно.
3. Дараах үйлдлүүдийн аль нэгийг хий.
 - ☐ **Унтах Цаг тоологч** эсвэл **Унтраах Тохиргоо** > **Идэвхгүй бол Унтраах**-ийг сонгосны дараа тохиргоог хийнэ.
 - ☐ **Унтах Цаг тоологч** эсвэл **Унтраах Цаг Тоологч**-ийг сонгосны дараа тохиргоог хийнэ.

Тэмдэглэл:

Үйлдвэрлэсэн огноо, худалдан авсан газраас хамааран таны бүтээгдэхүүнд энэ үзүүлэлт эсвэл **Унтраах Тохиргоо** эсвэл **Унтраах Цаг Тоологч** үзүүлэлт байж магадгүй.

Принтерийг зөөвөрлөх

Принтерийг зөөвөрлөх эсвэл засварт өгөх шаардлагатай үед, доорх алхмыг дагаж принтерийг баглаарай.




Болгоомжтой:

Сканнерын нэгцийг нээж хаах үедээ гар, хуруугаа хавчуулахаас болгоомжлоорой. Эс бөгөөс гэмтэх аюултай.



Чухал:

- ☐ Принтерийг хадгалах буюу зөөвөрлөх үед, хазайлгах, босоогоор нь байрлуулах, доош нь харуулахаас болгоомжил; эс бөгөөс бэх гоожиж болзошгүй.



- ☐ Лацыг нь авсны дараа бэхний хайрцгийг хадгалах эсвэл тээвэрлэх үед, хайрцгийг хазайлгаж болохгүй ба цохиулах, эсвэл температурын өөрчлөлтөд оруулахаас сэргийлнэ. Эс тэгвээс, бэхний хайрцгийн таг бат хаагдсан байсан ч бэх асгарах аюултай. Таглааг хаах үедээ бэхний хайрцгийг босоо байрлалд байлгаж, хайрцгийг тээвэрлэх үед бэх асгарахаас сэргийлэх бүх арга хэмжээг авна.
- ☐ Принтер бүхий хайрцган дээр бэхний онгойлгосон хайрцгийг тавьж болохгүй.

1.  товч дээр дарж принтерийг унтраана.

Хавсралт


- Тэжээлийн гэрэл унтарсан эсэхийг шалгаж, тэжээлийн залгуурыг салгана.




Чухал:

Тэжээлийн гэрэл унтарсан үед тэжээлийн залгуурыг салгана. Эс бөгөөс, хэвлэх толгой үндсэн байрлалдаа шилжилгүй, бэх хатах, улмаар хэвлэх боломжгүй болоход хүргэнэ.

- Тэжээлийн залгуур, USB кабел зэрэг бүх кабелийг салгана.
- Принтерээс бүх цаасыг авна.
- Принтер дээр эх хувь үлдээгүй эсэхийг шалгана.
- Баримтын тагийг хаалттай хэвээр сканнерийн нэгжийг нээнэ. Хэвлэх толгойг наалддаг туузаар саванд нь бэхэлж хөдөлгөөнгүй болгоно.




- Сканнерийн нэгжийг хаана.




Хавсралт

8. Доор харуулсны дагуу принтерийг баглахад бэлтгэнэ.



9. Бэхний савны таглааг бат бөх таглаж хаасан эсэхээ магадлаарай.



10. Принтерийг хайрцганд нь хамгаалалтын материалаар баглаж хийнэ.

Принтерийг дахин ашиглахдаа, хэвлэх толгойг бэхэлж тогтоосон наалтыг салгаа мартуузай. Дараагийн удаа хэвлэх үед хэвлэх чанар муудсан байвал, хэвлэх толгойг цэвэрлэж тэгшигтэнэ.

Холбогдох мэдээлэл

- ➔ 14 хуудас дээрх "Эд ангийн нэр ба функцууд"
- ➔ 91 хуудас дээрх "Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх"
- ➔ 94 хуудас дээрх "Принтерийн толгойг тохируулна"

Хаанаас тусламж авах вэ

Техник туслалцааны вэбсайт

Танд нэмэлт тусламж хэрэгтэй бол, доор үзүүлсэн Epson-н тусламжийн вэбсайт руу орно уу. Улс, бүс нутгаа сонгоод өөрийн дотоодын Epson вэбсайтын тусламжийн хэсэг рүү орно уу. Хамгийн сүүлийн үеийн драйвер, тусламж, гарын авлага эсвэл бусад татаж авах боломжтой материал энэхүү вэбсайт дээр байх болно.

<http://support.epson.net/>

<http://www.epson.eu/Support> (Европ)

Хавсралт

Таны Epson бүтээгдэхүүн зохих ёсоор ажиллахгүй бөгөөд та асуудлыг шийдвэрлэж чадахгүй байвал, туслалцаа авахын тулд Epson-н тусламжийн хэсэгтэй холбогдоно уу.

Epson-н тусламжтай холбогдох

Epson-той холбоо барихаас өмнө

Таны Epson бүтээгдэхүүн зөв зүйтэй ажиллахгүй, та бүтээгдэхүүний гарын авлага дээрх асуудлыг шийдэх мэдээллийг ашиглан асуудлыг шийдэж чадахгүй байвал, тусламж авахаар Epson-н дэмжлэгийн үйлчилгээг авахаар холбоо барина. Танай бүс нутаг дахь Epson-н дэмжлэгийг доор харуулаагүй байвал, бүтээгдэхүүнээ худалдаж авсан худалдааны газартай холбоо барина.

Та дараах мэдээллийг тэдэнд өгвөл Epson-н дэмжлэгийн үйлчилгээ танд илүү хурдан туслах болно:

- ☐ Бүтээгдэхүүний серийн дугаар
(Серийн дугаарын шошгыг гол төлөв бүтээгдэхүүний ард байрлуулдаг.)
- ☐ Бүтээгдэхүүний загвар
- ☐ Бүтээгдэхүүний программ хангамжийн хувилбар
(**Тухай, Хувилбарын мэдээлэл** дээр дарах, эсвэл бүтээгдэхүүний программ хангамжийн ижил төстэй товчин дээр дарна.)
- ☐ Таны компьютерийн брэнд ба загвар
- ☐ Таны компьютерийн үйлдлийн систем ба хувилбар
- ☐ Та байнга бүтээгдэхүүнтэйгээ хамт хэрэглэдэг программ хангамжийн нэр ба хувилбар

Тэмдэглэл:

Бүтээгдэхүүнээс шалтгаалж, факс ба/буюу сүлжээний тохиргооны дугаар цуглуулах жагсаалтын мэдээллийг бүтээгдэхүүний санах ойд хадгалж болно. Бүтээгдэхүүний эвдрэл гэмтэл эсвэл засвараас болоод мэдээлэл ба/буюу тохиргоог алдаж болно. Epson нь баталгаат хугацааны туршид хүртэл аливаа мэдээлэл, мэдээлэл ба/буюу тохиргоог хадгалах, эсвэл сэргээх асуудлыг хариуцахгүй. Та өөрийнхөө хадгалах мэдээллийг хийж, тэмдэглэл хөтлөхийг санал болгож байна.

Европын хэрэглэгчдэд тусламж үзүүлэх

Европ дахины баталгааны мэдээллээс Epson-н тусламж үйлчилгээтэй хэрхэн холбогдох талаар уншина уу.

Тайваны хэрэглэгчдэд тусламж үзүүлэх

Мэдээлэл, тусламж, үйлчилгээ авахын тулд холбоо барих хаяг:

Даян Дэлхийн Вэб

<http://www.epson.com.tw>

Бүтээгдэхүүний үзүүлэлт, татаж авах драйвер, бүтээгдэхүүний лавлагааны талаарх мэдээллийг авч болно.

Хавсралт

Еpson тусламжийн ширээ

Утас: +886-2-2165-3138

Манай тусламж үйлчилгээний хэсэг таны дараах асуудлыг утсаар шийдвэрлэж өгч чадна:

- ☐ Борлуулалтын лавлагаа ба бүтээгдэхүүний мэдээлэл
- ☐ Бүтээгдэхүүн ашиглалтын талаарх асуулт ба тулгарах асуудал
- ☐ Засвар үйлчилгээ ба баталгааны талаарх лавлагаа

Засвар үйлчилгээний төв:

<http://www.tekcare.com.tw/branchMap.page>

TekCare корпораци нь Epson Taiwan Technology & Trading Ltd компанийн баталгаат үйлчилгээний төв болно.

Австралийн хэрэглэгчдэд зориулсан тусламж

Epson Австрали нь танд дээд түвшний хэрэглэгчийн үйлчилгээг үзүүлэхийг хүсэж байна. Таны бүтээгдэхүүний гарын авлагаас гадна, бид мэдээлэл авах дараах эх үүсвэрийг танд санал болгож байна:

Интернэт URL

<http://www.epson.com.au>

Epson Австралийн дэлхий нийтийн вэбсайтын хуудсанд хандана уу. Модемоо энэ хаяг руу чиглүүлэн хааяа зочилж байхад харамсах зүйлгүй шүү! Тус сайтад драйвер татах хэсэг, Epson-той холбоо барих талбар, шинэ бүтээгдэхүүний мэдээлэл, техникийн туслалцаа (и-мэйл) бий.

Еpson тусламжын ширээ

Утас: 1300-361-054

Epson тусламжийн ширээ нь хэрэглэгчдийн зөвлөгөө авах эцсийн зогсоол болно. Тусламжын ширээн дэх операторууд нь танд Epson бүтээгдэхүүнээ суулгах, тохируулах, ажиллуулахад туслалцана. Манай борлуулалтын өмнөх тусламж үйлчилгээний ажилтнууд нь танд Epson-н шинэ бүтээгдэхүүний товхимол, хаана хамгийн ойрын худалдааны цэг, үйлчилгээний агент байгааг зааж өгнө. Энд олон төрлийн асуултад хариулт өгнө.

Бид таныг залгах үедээ бүх холбогдох мэдээллээ гарын дор байлгахыг зөвлөж байна. Та хэр их мэдээлэл бэлтгэнэ, тэр тусмаа бид таны асуудлыг хурдан шийдвэрлэж өгөх боломжтой болно. Энэхүү мэдээлэлд Epson-н бүтээгдэхүүний гарын авлага, компьютерийн төрөл, үйлдлийн систем, программ хангамж, болон таны шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл орно.

Бүтээгдэхүүнийг тээвэрлэх

Дараа дахин тээвэрлэхдээ бүтээгдэхүүний баглаа боодлыг нь хадгалж үлдэхийг Epson зөвлөж байна. Бэхний савыг наалддаг туузаар бэхэлж, бүтээгдэхүүнийг босоогоор нь байлгахыг бас зөвлөж байна.

Шинэ Зеландын хэрэглэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээ

Epson Шинэ Зеланд нь танд дээд түвшний хэрэглэгчийн үйлчилгээг үзүүлэхийг зорьж байна. Бүтээгдэхүүний гарын авлагаас гадна, мэдээлэл авах дараах эх үүсвэрийг бид танд санал болгож байна:

Интернэт URL

<http://www.epson.co.nz>

Epson Шинэ Зеланд дэлхий нийтийн вэб хуудсанд хандаарай. Модемоо энэ хаяг руу чиглүүлэн хааяа зочилж байхад харамсах зүйлгүй шүү! Тус сайтад драйвер татах хэсэг, Epson-той холбоо барих талбар, шинэ бүтээгдэхүүний мэдээлэл, техникийн туслалцаа (и-мэйл) бий.

Epson тусламжын ширээ

Утас: 0800 237 766

Epson тусламжийн ширээ нь хэрэглэгчдийн зөвлөгөө авах эцсийн зогсоол болно. Тусламжын ширээн дэх операторууд нь танд Epson бүтээгдэхүүнээ суулгах, тохируулах, ажиллуулахад туслалцана. Манай борлуулалтын өмнөх тусламж үйлчилгээний ажилтнууд нь танд Epson-н шинэ бүтээгдэхүүний товхимол, хаана хамгийн ойрын худалдааны цэг, үйлчилгээний агент байгааг зааж өгнө. Энд олон төрлийн асуултад хариулт өгнө.

Бид таныг залгах үедээ бүх холбогдох мэдээллээ гарын дор байлгахыг зөвлөж байна. Та хэр их мэдээлэл бэлтгэнэ, тэр тусмаа бид таны асуудлыг хурдан шийдвэрлэж өгөх боломжтой болно. Эдгээр мэдээлэлд, Epson бүтээгдэхүүний гарын авлага, компьютерийн төрөл, үйлдлийн систем, программ хангамж, болон таны шаардлагатай гэж үзсэн бусад бүх мэдээлэл орно.

Бүтээгдэхүүнийг тээвэрлэх

Дараа дахин тээвэрлэхдээ бүтээгдэхүүний баглаа боодлыг нь хадгалж үлдэхийг Epson зөвлөж байна. Бэхний савыг наалддаг туузаар бэхэлж, бүтээгдэхүүнийг босоогоор нь байлгахыг бас зөвлөж байна.

Сингапурын хэрэглэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээ

Epson Сингапурын зүгээс үзүүлэх мэдээлэл, тусламж, үйлчилгээний эх үүсвэр нь дараах болно:

Даян Дэлхийн Вэб

<http://www.epson.com.sg>

Бүтээгдэхүүний үзүүлэлт, татах драйвер, Тусламж, борлуулалтын лавлагаа, техникийн дэмжлэгийн талаарх мэдээллийг и-мэйлээр авах боломжтой байдаг.

Epson тусламжийн ширээ

Лавлах утас: 800-120-5564

Манай тусламж үйлчилгээний хэсэг таны дараах асуудлыг утсаар шийдвэрлэж өгч чадна:

- ☐ Борлуулалтын лавлагаа ба бүтээгдэхүүний мэдээлэл
- ☐ Бүтээгдэхүүн ашиглалтын талаарх асуулт ба асуудал шийдвэрлэх
- ☐ Засвар үйлчилгээ ба баталгааны талаарх лавлагаа

Тайландын хэрэглэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээ

Мэдээлэл, тусламж, үйлчилгээ авахын тулд холбоо барих хаяг:

Даян Дэлхийн Вэб

<http://www.epson.co.th>

Бүтээгдэхүүний үзүүлэлт, татах драйвер, Байнга асуудаг асуултууд (FAQ), болон и-мэйлийн талаарх мэдээллийг авах боломжтой байдаг.

Epson Дуудлагын төв

Утас: 66-2460-9699

И-мэйл: support@eth.epson.co.th

Манай Үйлчилгээний хэсэг таны дараах асуудлыг утсаар шийдвэрлэж өгч чадна:

- ☐ Борлуулалтын лавлагаа ба бүтээгдэхүүний мэдээлэл
- ☐ Бүтээгдэхүүн ашиглалтын талаарх асуулт ба тулгарах асуудал
- ☐ Засвар үйлчилгээ ба баталгааны талаарх лавлагаа

Вьетнамын хэрэглэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээ

Мэдээлэл, тусламж, үйлчилгээ авахын тулд холбоо барих хаяг:

Epson шууд холбоо

Утас(Хо Ши Мин хот): 84-8-823-9239

Утас(Ханой хот): 84-4-3978-4785, 84-4-3978-4775

Epson Үйлчилгээний төв

65 Truong Dinh Street, District 1, Ho Chi Minh City, Vietnam.

29 Tue Tinh, Quan Hai Ba Trung, Hanoi City, Vietnam

Индонезийн хэрэглэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээ

Мэдээлэл, тусламж, үйлчилгээ авахын тулд холбоо барих хаяг:

Даян Дэлхийн Вэб

<http://www.epson.co.id>

- ☐ Бүтээгдэхүүний үзүүлэлт, татаж авах драйверуудын тухай мэдээлэл
- ☐ Тусламж, борлуулалтын лавлагаа, асуултыг и-мэйлээр авна

Epson шууд холбоо

Утас: 62-1500-766

Факс: 62-21-808-66-799

Манай шууд холбооны баг дараах асуудлыг утсаар юмуу факсаар шийдвэрлэж өгөх боломжтой:

Хавсралт

- ☐ Борлуулалтын лавлагаа ба бүтээгдэхүүний мэдээлэл
- ☐ Техникийн туслалцаа

Epson Үйлчилгээний төв

Муж	Компанийн нэр	Хаяг	Утас Э-мэйл
ЖАКАРТА	ESS Jakarta MG. DUA	RUKO MANGGA DUA MALL NO. 48 JL. ARTERI MANGGA DUA - JAKARTA UTARA- DKI	(+6221)62301104 jkt-technical1@epson-indonesia.co.id
ХОЙД СУМАТРА	ESC Medan	Kompleks Graha Niaga, Jl. Bambu II No. A-4, Medan- 20114	(+6261)42066090/42066091 mdn-technical@epson-indonesia.co.id
БАРУУН ЯВА	ESC Bandung	JL. CIHAMPELAS NO. 48A-BANDUNG JABAR 40116	(+6222)4207033 bdg-technical@epson-indonesia.co.id
ДИ ЁГЯКАРТА	ESC Yogyakarta	YAP Square, Blok A No.6 Jl. C Simanjutak YOGYAKARTA - DIY	(+62274)581065 ygy-technical@epson-indonesia.co.id
ЗҮҮН ЯВА	ESC Surabaya	HITECH MALL LT.2 BLOK A NO. 24 JL. KUSUMA BANGSA NO. 116 -118 - SURABAYA JATIM	(+6231)5355035 sby-technical@epson-indonesia.co.id
ӨМНӨД СУЛАВЕС	ESC Makassar	JL. GUNUNG BAWAKARAENG NO. 68E - MAKASSAR SULSEL	(+62411)328212 mksr-technical@epson-indonesia.co.id
БАРУУН КАЛИМАНТА Н	ESC Pontianak	JL. NUSA INDAH I NO. 40A PONTIANAK KALBAR 78117	(+62561)735507 pontianak-technical@epson-indonesia.co.id
ПЕКАНБАРУ	ESC PEKANBARU	JL. TUANKU TAMBUSAI NO. 353 - PEKANBARU RIAU	(+62761)21420 pkb-technical@epson-indonesia.co.id
ЖАКАРТА	ESS JAKARTA KEIAI	WISMA KEIAI LT. 1 JL. JEND. SUDIRMAN KAV. 3 JAKPUS DKI JAKARTA	(+6221)5724335 ess.support@epson-indonesia.co.id
ЗҮҮН ЯВА	ESS SURABAYA	JL. JAWA NO. 2-4 KAV. 29, RUKO SURYA INTI, SURABAYA - JATIM	(+6231)5014949 esssby.support@epson-indonesia.co.id
БАНТЕН	ESS SERPONG	Ruko mall WTC MATAHARI no. 953 SERPONG - Banten	(+6221)53167051 esstag.support@epson-indonesia.co.id
ТӨВ ЯВА	ESS SEMARANG	Komplek Ruko Metro Plaza Blok C20 , Jl. MT Haryono No 970 Semarang - Jawa tengah	(+6224)8313807 esssmg.support@epson-indonesia.co.id

Хавсралт

Муж	Компанийн нэр	Хаяг	Утас Э-мэйл
ЗҮҮН КАЛИМАНТА Н	ESC SAMARINDA	Jl. KH. Wahid Hasyim (M. Yamin) Kel. Sempaja Selatan Kec. Samarinda Utara Samarinda- Kalimantan Timur (samping kantor pos)	(+62541)7272904 escsmd.support@epson- indonesia.co.id
ӨМНӨД СУМАТРА	ESC PALEMBANG	Jl. H.M. Rasyid Nawawi no.249, kelurahan 9 ilir Palembang - Sumsel	(+62711)311330 escplg.support@epson- indonesia.co.id
ЗҮҮН ЯВА	ESC JEMBER	Jl. Panglima Besar Sudirman No.1 D JEMBER - JAWA TIMUR (Depan Balai Penelitian dan Pengolahan Kakao)	(+62331) 486468,488373 jmr-admin@epson- indonesia.co.id jmr-technical@epson- indonesia.co.id
ХОЙД СУЛАВЕС	ESC MANADO	Tekno @Megamall, Megamall LG TK-21 Jl. Piere Tendean Kawasan Megamas Boulevard Manado 95111	(+62431)7210033 MND-ADMIN@EPSON- INDONESIA.CO.ID

Энэ жагсаалтанд ороогүй хотуудын хувьд дараах утсаар авна уу: 08071137766.

Гонконгийн хэрэглэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээ

Техникийн туслалцаа авах түүнчлэн борлуулалтын дараах бусад үйлчилгээг авахын тулд, Epson Гонконг Лимитед-тэй холбоо барихыг хэрэглэгчдээс хүсэж байна.

Интернэт нүүр хуудас

<http://www.epson.com.hk>

Epson Гонконг нь интернэт дээр хятад, англи хоёр хэлээр орон нутгийн вэбсайт ажиллуулж байгаа ба ингэснээр дараах мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх юм:

- ☐ Бүтээгдэхүүний мэдээлэл
- ☐ Тусламжийн асуултын хариу
- ☐ Epson-н бүтээгдэхүүний хамгийн сүүлийн драйвер

Техникийн туслалцааны шууд холбоо

Түүнчлэн, та дараах утас болон факсын дугаараар техникийн үйлчилгээний ажилтнуудтай холбоо барьж болно:

Утас: 852-2827-8911

Факс: 852-2827-4383

Малайзын хэрэглэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээ

Мэдээлэл, тусламж, үйлчилгээ авахын тулд холбоо барих хаяг:

Хавсралт

Даян Дэлхийн Вэб

<http://www.epson.com.my>

- ☐ Бүтээгдэхүүний үзүүлэлт, татаж авах драйверуудын тухай мэдээлэл
- ☐ Тусламж, борлуулалтын лавлагаа, асуултыг и-мэйлээр авна

Epson Дуудлагын төв

Утас: +60 1800-8-17349

- ☐ Борлуулалтын лавлагаа ба бүтээгдэхүүний мэдээлэл
- ☐ Бүтээгдэхүүн ашиглалтын талаарх асуулт ба тулгарах асуудал
- ☐ Засвар үйлчилгээ ба баталгааны талаарх лавлагаа

Төв оффис

Утас: 603-56288288

Факс: 603-5628 8388/603-5621 2088

Энэтхэгийн хэрэглэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээ

Мэдээлэл, тусламж, үйлчилгээ авахын тулд холбоо барих хаяг:

Даян Дэлхийн Вэб

<http://www.epson.co.in>

Бүтээгдэхүүний үзүүлэлт, татаж авах драйвер, бүтээгдэхүүний лавлагааны талаарх мэдээллийг авч болно.

Тусламжийн шугам

- ☐ Үйлчилгээ, бүтээгдэхүүний мэдээлэл, хэрэглээгтй захиалга (BSNL Lines)
Үнэгүй лавлах: 18004250011
Даваагаас Бямба хүртэл өглөөний 9 цагаас оройн 6 цаг хүртэл (Нийтээрээ амрах өдрөөс бусад)
- ☐ Үйлчилгээ (CDMA & Гар утас хэрэглэгчид)
Үнэгүй лавлах: 186030001600
Даваагаас Бямба хүртэл өглөөний 9 цагаас оройн 6 цаг хүртэл (Нийтээрээ амрах өдрөөс бусад)

Филиппиний хэрэглэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээ

Техникийн туслалцаа болон бусад борлуулалтын үйлчилгээг авахын тулд хэрэглэгч нар доорх утас, факс, и-мэйл хаягаар Epson Philippines Corporation-тай холбоо барьж болно:

Даян Дэлхийн Вэб

<http://www.epson.com.ph>

Бүтээгдэхүүний үзүүлэлт, татаж авах драйвер, Тусламжийн талаар И-мэйлээр лавлах боломжтой.

Хавсралт

Epson Филиппиний хэрэглэгчийн үйлчилгээ

Лавлах утас: (PLDT) 1800-1069-37766

Лавлах утас: (тоон) 1800-3-0037766

Метро Манила: (+632)441-9030

Вебсайт: <https://www.epson.com.ph/contact>

И-мэйл: customercare@epc.epson.som.ph

Манай Хэрэглэгчийн үйлчилгээний хэсэг таны дараах асуудлыг утсаар шийдвэрлэж өгч чадна:

- ☐ Борлуулалтын лавлагаа ба бүтээгдэхүүний мэдээлэл
- ☐ Бүтээгдэхүүн ашиглалтын талаарх асуулт ба тулгарах асуудал
- ☐ Засвар үйлчилгээ ба баталгааны талаарх лавлагаа

Epson Philippines Corporation

Гол шугам: +632-706-2609

Факс: +632-706-2665